- Газар нутгийн онцлогоос хамаарах

Үнэлгээ нь хот суурин бүрээр тохиромжтой, хязгаарлагдмал тохиромжтой, тохиромжгүй гэсэн ангиллаар тодорхойлогдоно.

- Тохиромжтой нөхцөлд 5 балл
- Хязгаарлагдмал тохиромжтой нөхцөлд 4 балл
- Тохиромжгүй нөхцөлд 3 балл гэсэн баллын тогтолцоогоор үзүүлэлт тус бүрийн үнэлгээг гаргаж, тэдгээрийн дундаж нь үнэлгээг тодорхойлно. Үүнд:

Хүснэгт №3.15. Хот суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ

д/д	Үзүүлэлтүүд	Зохицох балл		
		Тохиромжтой	Хязгаарлагдмал тохиромжтой	Тохиромжгүй
1	Гадаргын налуу 1-4% 5-10% 11%-ээс дээш	5	4	3
2	Далайн төвшнөөс дээш өргөгдсөн байдал 1500 метр хүртэл 1500-2000 метр хүртэл 2000-ээс дээш	5	4	3
3	Цэвдэг хөрсний тархалт /хот суурины нутаг дэвсгэрт тархсан хувиар / 0% 50% хүртэл 50%-иас дээш бол	5	4	3
4	Овойлт суултын хөрсний дархалт /хот суурины нутаг дэвсгэрт тархсан хувиар/ 0-5% 10% хүртэл 20%-иас дээш	5	4	3
5	Газар чичирхийллийн мужлал 6 балл 7-8 балл 9 балл ба дээш	5	4	3
6	Хөрсний усны илрэх төвшин 3 метрээс дээш 1-5 метр 10 метр хүртэл	5	4	3
7	Ундны усны хангамж Сайн Дунд Муу	5	4	3

Хот сууринд газрын гадаргын налуу нь 0.4-4% байх нь илүү тохиромжтой байдаг бол газар хөдлөлийн балл барилга байгууламжид сөрөг нөлөө бий болдог. Газар

хөдлөлтийн баллын эсрэг авах арга хэмжээ нь барилгын төсөвт өртгийг 4-12 %-иар, Цэвдэг хөрс хот суурины дэвсгэр газрын 60-70 %-д тархсан бол төсөвт өртөг 12-25 %, 25-30 хувьд тархсан бол 1-2 %-иар ихэсдэг. Хүчтэй овойлттой хөрс барилгын төсөвт өртгийг 10%, дунд зэргийн овойлттой хөрс 15%, сул овойлттой хөрс 6%-иар тус тус ихэсдэг байна. /Эх сурвалж: Т. Хоролжав <Монгол орны хот байгуулалтын байгалийн нөхцөл> Улаанбаатар 2011/

Шинээр байгуулах сум суурины төвийг <тохиромжтой> газрыг сонгон байршуулах бөгөөд харин одоо байгаа сумдын төвийн барилга байгууламжийн төлөвлөлтөд байгалийн нөхцлийн үнэлгээгээр төсөвт өртгийн тооцоог нарийвчлан хийх шаардлага тавигдана.

Хүснэгт.№3.16. Өмнөговь аймгийн хот суурин газрын хот байгуулалтын байгалийн нөхүлийн ерөнхий үнэлгээ

Д/д	Хот суурины нэр	Усан хангамж	Олон жилийн цэвдэг хөрс	Газар чичирхийлэл /балл/	Ул хөрс		Хөрсий усны түвшин /м/	Үерт авгагдсан байдал	Газрын гадаргын налуу %	Барилгын уур амьсгалын бүс	Далайн түвшнээс өргөгдсөн байдал /м /	Бусад
					Хөрсний төрөл	Норматив ачаалал /кг/см2/						
1	Даланзадгад	дунд		9-10			6.0-30.0	үерт ав	1.0		1700.0	
2	Баяндалай	+		9	Хөөлт		10 -41.0		0.6		1550.0	гулсалттай
3	Баяновоо	+		8			4.5 дээш		1.0		1100.0	
4	Булган	+		8	Хөөлт		4.5дээш		1.5		1250 0	
5	Гурвантэс	+		9			7.5		3.2		2503.0	
6	Мандаловоо	+		6	Хөөлт, суулт		1.95-8.7				1500.0	
7	Манлай	+		6	суулт				1.0		1300.0	
8	Номгон	+		8			2.8-3.4		1.2		1100.0	
9	Ноён	+		7	Хөөлт,суулт		1.9		1.0		1900.0	
10	Сэврэй	+		9	Хөөлт, суулт				1.0		12350	
11	Ханбогд	+		6			7.5		0.8-5.6		1300.0	гулсалттай
12	Ханхонгор	+		7			2.74.1				1500.0	
13	Хүрмэн	+		9			4.6-9.0		3.0		1800.0	
14	Цогтовоо	дунд		6	Хөөлт			боломж	1.0		1250 0	
15	Цогтцэций	+		7							1500.0	

/Эх үүсвэр Улсын ГЗБ ерөнхий төлөвлөгөө 2003 он/

Хүснэгт№3.17. Хот суурины нутаг дэвсгэрийн байгалийн нөхцлийн үнэлгээ

№	Хот суурины нэр	Газрын гадаргуу			Байрлалын өндөршилт			Цэвдэг хөрсний тархалт			Овоолт суулттай хөрсний тархалт			Газар чичирхийллийн балл			Хөрсний усны илрэх төвшин			Ундны усны хангамж			Байгалийн нөхцлийн үнэлгээ	
		Тохиромжтой	Хязгаарлагдмал тохиромжтой	Тохиромжгүй	Тохиромжтой	Хязгаарлагдмал тохиромжтой	Тохиромжгүй	Тохиромжтой	Хязгаарлагдмал тохиромжтой	Тохиромжгүй	Тохиромжтой	Хязгаарлагдмал тохиромжтой	Тохиромжгүй	Тохиромжтой	Хязгаарлагдмал тохиромжтой	Тохиромжгүй	Тохиромжтой	Хязгаарлагдмал тохиромжтой	Тохиромжгүй	Сайн	Дунд	Дундаж балл	Балл	Үнэлгээ
1	Даланзадгад	5				4		5			5				3		4			4		4.3	Хязгаарлагдмал тохиромжтой	
2	Баяндалай	5				4		5				3		3		4		5				4.1	Хязгаарлагдмал тохиромжтой	
3	Баян-Овоо	5			5			5			5			4		4		5				4.7	Хязгаарлагдмал тохиромжтой	
4	Булган	5			5			5				3		4		4		5				4.4	Хязгаарлагдмал тохиромжтой	
5	Гурвантэс	5					3	5			5				3		4		5			4.3	Хязгаарлагдмал тохиромжтой	
6	Мандал-Овоо	5			5			5				3	5			4		5				4.0	Хязгаарлагдмал тохиромжтой	
7	Манлай	5			5			5				3	5			4		5				4.4	Хязгаарлагдмал тохиромжтой	
8	Номгон	5			5			5			5			4		4		5				4.7	Тохиромжтой	
9	Ноён	5				4		5				3		4		4		5				4.3	Хязгаарлагдмал тохиромжтой	
10	Сэврэй	5			5			5				3		3		4		5				4.3	Хязгаарлагдмал тохиромжтой	
11	Ханбогд		4		5			5				3	5			4		5				4.4	Хязгаарлагдмал тохиромжтой	
12	Ханхонгор		4		5			5			5			4		4		5				4.6	Хязгаарлагдмал тохиромжтой	
13	Хүрмэн	5				4		5			5				3		4		5			3.8	Хязгаарлагдмал тохиромжтой	
14	Цогт-Овоо	5			5			5				3	5			4			4			4.4	Хязгаарлагдмал тохиромжтой	
15	Цогтцэций	5			5			5				3		4		4		5				4.4	Хязгаарлагдмал тохиромжтой	

Сумын төвийн нутаг дэвсгэрийн байгалийн нөхцлийн үнэлгээний дүгнэлт

- Гадаргын налуугын үнэлгээгээр: Аймгийн сум суурин газрууд бүгд харьцангуй тохиромжтой налуу бүхий нутаг дэвсгэрт оршдог.
- Далайн төвшнөөс дээш өргөгдсөн байдлын үнэлгээгээр: 1550-2500 метрийн өндөрт оршдог Баяндалай, Даланзадгад, Ноён, Хүрмэн сумд хязгаарлагдмал тохиромжтой үнэлгээтэй, бусад сумд тохиромжтой үнэлгээтэй байна.
- Цэвдэг хөрсний тархалт үзүүлэлтээр: Аймгийн бүх сум цэвдэг хөрсгүй тохиромжтой нутаг дэвсгэрт оршдог.
- Овоолт суулттай хөрсний тархалтын үзүүлэлтээр: Даланзадгад, Баяновоо, Гурвантэс, Номгон, Ханхонгор, Хүрмэн, Цогтцэций сумд тохиромжтой хөрс бүхий нутаг дэвсгэрт байрладаг. Хөөлт, суулт, гулсалт бүхий хөрстэй Баяндалай, Булган, Ханбогд, Мандал-Овоо, Манлай, Ноён, Сэврэй, Цогт-Овоо сумдад барилга байгууламж барихдаа хөрсөнд тохирсон арга хэмжээ авах шаардлагатай.
- Газар чичирхийллийн мужлалаар: Мандал-Овоо, Манлай, Цогт-Овоо сумд 6 баллын мужлалд оршдог учир тохиромжтой нөхцөлтэй. 7-8 баллын мужлалд оршдог Булган, Баяновоо, Номгон, Ноён сумд хязгаарлагдмал тохиромжтой. 9 –өөс дээш баллын мужлалд оршдог Даланзадгад, Баяндалай, Гурвантэс, Сэврэй, Хүрмэн сумдад барилга байгууламж барихад газар хөдлөлийн эсрэг арга хэмжээ авах шаардлагатай.
- Хөрсний усны илрэх төвшингийн үзүүлэлтээр: Хөрсний ус бүх сумдад 3 метрээс доош гүнд илэрдэг учир тохиромжтой нөхцөл хэмээн үнэлэгдэж байна.
- Ундны усны хангамжаар Даланзадгад, Цогт-Овоо сумд дунд, бусад бүх сумд сайн байна.

3.2.4. Хот байгуулалтад тавигдах шаардлага

Хот байгуулалт нь түүх, соёл иргэншлийн уламжлал, эдийн засаг нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, хүрээлэн буй орчны хамгаалалд нийцсэн амьдрах тааламжтай орон зайг бүрдүүлэх үйл ажиллагаа юм.

Хот тосгоны ирээдүйн хөгжил, эдийн засаг нийгмийн зохистой орчин бий болгохын тулд газар ашиглалт, орон зайн зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор хот төлөвлөлт хийгдэнэ. Хот төлөвлөлт нь Хүн амын нутагшил суурьшлийн ерөнхий төсөл, Бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө гэсэн үе шатаар хийгдэнэ. Ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн хугацаа нь 20-25 жил, эхний ээлжийн хугацаа нь 8-10 жил байна.

Хот тосгон нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тогтоосон барилгажих хязгаартай, оршин суугчдын орон сууц, нийгмийн үйлчилгээний барилга байгууламжтай, хүн амыг хүнсээр хангах болон хот орчмын бүсийн нутаг дэвсгэртэй байна.

Хот тосгоны ерөнхий төлөвлөгөөнд хүн амын амьдрах таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн хөгжлийг тодорхойлж, хот тосгоны хил хязгаар, газар ашиглалтын бүсчлэлийг тогтоож хот байгуулалтын бодлогыг тодорхойлно. Хот байгуулалтын орон зайн төлөвлөлт бодлогыг боловсруулахад бүсүүд хоорондын болон орон сууц олон нийт нийгмийн үйлчилгээ үйлдвэрлэл аж ахуйн барилга байгууламжийн архитектур-орон зайн төлөвлөлтийг зам тээвэр, инженерийн дэд бүтцээр хангаж, хүн амын үндэсний ёс заншил, уламжлалыг байгаль орчны нөхцөлтэй уялдуулсан иж бүрэн шийдэл гаргана.

Хот тосгоны эдэлбэр газрыг хот байгуулалтын олон талт үйл ажиллагааны зориулалтаар ангилан, бүсчилж зам тээврийн сүлжээг зохион байгуулан байгаль орчин хүн амын аюулгүй таатай орчинд амьдрах нөхцлийг хангана.

Хот тосгоны хөгжлийн чиг хандлага, байгаль цаг уур, инженер- геологийн нөхцөл, байгалийн нөөц, хүн амын суурьшил, дэд бүтцийн хангамж нь хот байгуулалт төлөвлөлтийн үндсэн хүчин зүйл юм. Эдгээр хүчин зүйлийг харгалзан хот тосгоны эдэлбэр газар буюу барилгажих нутаг дэвсгэрийг бүсчлэн тогтооно.

Хот төлөвлөлтийн үндсэн бүсүүд:

1. Суурьшлийн буюу орон сууц, олон нийтийн бүсүүд
2. Үйлдвэрийн аж ахуйн бүс
3. Гудамж зам тээвэр, дэд бүтцийн бүс
4. Ногоон байгууламж, амралт зугаалгын бүс
5. Тусгай зориулалтын бүс
6. Хот орчмын бүс
7. Хөдөө аж ахуйн бүс
8. Зуслан

Суурьшлийн бүс

Хүн амын ажиллаж амьдрах эрүүл ахуй, аюулгүйн нөхцөл шаардлагыг хангасан орон зайг нь суурьшлын нутаг дэвсгэр буюу суурьшлын бүс юм. Энэ нь хот тосгоны

захиргаа олон нийт соёл ахуйн үйлчилгээ, орон сууц, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн зам талбайгаас бүрдэнэ.

Суурьшлийн нутаг дэвсгэрт үйлчилгээний зохистой хүрээ бүхий орон сууцны хороолол, хүн амын өдөр тутмын хэрэгцээний соёл ахуй үйлчилгээний барилга байгууламж, олон нийтийн үйлчилгээ захиргааны байгууллага, нийтийн хэрэгцээний цэцэрлэгт талбай байрлана.

Үйлдвэр аж ахуйн бүс

Үйлдвэр аж ахуйн бүсийг зонхилох салхины доод чигт байрлуулна. Үйлдвэр аж ахуйн бүсэд ариун цэвэр эрүүл ахуйн хувьд байгаль орчинд халгүй үйлдвэр аж ахуй, худалдааны захууд, инженерийн барилга байгууламжууд, барилгын үйлдвэрлэлийн бааз, галын депо, мал аж ахуйн түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх цех, түлшний зах, хоёрдогч түүхий эд хүлээн авах цэг байрлана. Тухайн объектыг өмчлөгч, ашиглагч, эзэмшигч нь орчны ус, агаар, хөрсний бохирдлоос орчныг хамгаалах үүрэг хүлээнэ. Мал амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах, химийн бодис, био бэлдмэлийн агуулах, галын ба дэлбэрэх аюултай үйлдвэрлэл, тэдгээрийн агуулах, хог хаягдал устгах объект болон үйлдвэр, уурын зуух, бохир цэвэрлэх байгууламж зэргийг суурьшлийн бүсийн доод чигт байрлуулна.

Гудамж зам тээвэр дэд бүтцийн бүс

Гудамж замын сүлжээ нь хот тосгоны нутаг дэвсгэрийн уялдаа, харилцан таталцлын тэнхлэг болно. Энд төмөр зам, авто болон агаарын тээвэр, цэвэр, бохир ус, дулаан, холбоо, цахилгааны шугам сүлжээний барилга байгууламж байна.

Ногоон байгууламж амралт зугаалгын бүс

Хотын захын нутаг дэвсгэрт ойн сан, ногоон бүс байна. Энд хот орчмы ой, хамгаалалтын ойн зурвас, амралт зугаалгын газар, цэцэрлэгт хүрээлэн, зуслан, цэнгэлдэх хүрээлэн, спортын цогцолбор бүхий орон зайн задгай орчин хамаарна. Энэ бүсийг үндсэн үүргээс нь гадна салхи шуурга, элсний нүүлтээс хамгаалах зориулалттай ойн зурвастай байгуулна. Зурвасын өргөн нь 50 метрээс ихгүй байна.

Тусгай зориулалтын бүс

Тусгай зориулалтын бүсэд улсын нөөц газар, батлан хамгаалах болон хилийн боомтын зориулалттай нутаг дэвсгэр хамаарна.

Хот орчмын бүс

Хот орчмын бүс нь хот тосгоноос 5-15 км-ийн радиуст байх нутаг дэвсгэр хамаарна. Хот орчмын бүс нь хөдөө аж ахуйн бүс, зуслангийн бүсээс бүрдэнэ.

Нисэх онгоцны буудал, авто болон төмөр замын өртөө, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн барилга байгууламжууд, хог хаягдлын цэг, оршуулгын газар хот орчмын бүсэд байрлана. Хот орчмын бүс нь ногоон байгууламжтай, түүний дотоод хязгаар нь хот тосгоны барилгажих нутаг дэвсгэрийн хил байна. Барилгажих хилийн дагуу 500 метрээс багагүй өргөнтэй ойн зурвас байгуулна. Зуслангийн бүс нь улирлын чанартай суурьшин амьдрах нутаг дэвсгэр байна.

Хот тосгоны ус хангамжийн эх үүсвэрийг газрын дээд талд суурьшлын бүсийн ойролцоо байхаар сонгоно. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг хатуу дэглэмийн 1-р бүс, хязгаарлах 2 ба 3-р бүс гэж ангилан тогтооно.

Хүснэгт №3.18. Гүний усны эх үүсвэрийн ариун цэврийн хамгаалалтын бүс

Эх үүсвэрийн нэр	Хэмжих нэгж	Зай хэмжээ
Гүн өрмийн худаг		
1-р бүс	Метр	50
2-р бүс	Метр	100
Нэгдсэн усан сан	Метр	150

Гүний эх үүсвэрт хөрсний ус нэвтрэх нөхцөлтэй, эсвэл урсгал уснаас шууд тэжээгдэх нөхцөлтэй бол эх үүсвэрээс 500 метрээс доошгүй зайд, хөрсний уснаас хамгаалагдсан нөхцөлд 200 метрээс доошгүй зайд хамгаалалтын бүсийг тогтооно.

Ус хангамжийн эх үүсвэрт гадаргын усыг ашигладаг нөхцөлд гол горхи булгийн эргээс 200 метрээс доошгүй зайд 1-р бүсийг, урсгалаас дээш 50км-ээс доошгүй, урсгалаас доош 500 метрээс доошгүй зайд хязгаарлалтын бүсийг тогтооно.

Ус хангамжид усыг цэвэршүүлэх шаардлагатай нөхцөлд цэвэршүүлэх байгууламжийг бий болгож түүний эдэлбэр газрыг хүчин чадлаас нь хамааруулж тогтооно. Үүнд:

- 0.8 мян.м³/хон 1 га
- 0.8 - 12 мян.м³/хон 2 га
- 12 - 32 мян.м³/хон 3 га
- 32 - 60 мян.м³/хон 4 га
- 10 - 125 мян.м³/хон 6 га
- 125 - 250 мян.м³/хон 12 га
- 250 – 400 мян.м³/хон 18 га
- 400-800 мян.м³/хон 24 га

Хот тосгоны бохир ус цэвэрлэх байгууламж нь зонхилох салхины доод чигт, гадаргын нам хэсэгт байрлана.

Хүснэгт №3.19. Бохир ус цэвэрлэх байгууламжийн эдэлбэр газрын дээд хэмжээ


№	Бохир ус цэвэрлэх байгууламжийн хүчин чадал мян.м ³ /хон	Эдэлбэр газрын хэмжээ, га		
		Цэвэрлэх байгууламж	Лагийн талбай	Бохир усны гүн цэвэрлэгээ, биологийн цөөрөм
1	0.7 хүртэл	0.5	0.2	-
2	0.7-17	4	3	3
3	17-40	6	9	6
4	40-130	12	25	20
5	130-175	14	30	30
6	175-280	18	55	-

3.3. Хот суурин газрын газар ашиглалтын бүсийн төлөвлөлт

3.3.1. Хот суурин газрын газар ашиглалтын бүсийн төлөвлөлт/сумдаар/

1. Баяндалай сум

- Барилга байгууламжийн бүс: 2030 онд байх хүчин чадалтай нь уялдуулан хот төлөвлөлтийн нормоор тооцоход тухайн бүсэд 2030 он гэхэд 24.71 га газар шаардлагатай. Харин одоогийн байдлаар нийт **15.19 га** байна. Иймд цаашид 2030 он хүртэл 9.52 га газрыг тус бүсэд төлөвлөж байгаагаас эхний ээлжинд **2.14 га** газрыг төлөвлөв. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ, зам гудамж, ногоон байгууламж байна.
- Гэр орон сууцны бүс: Орон сууцны бүс хот төлөвлөлтийн нормоор 2030 онд тус бүсэд 39.1 га газар шаардлагатай байгаагаас одоогоор **82.64 га**, нөөц газар нь **397.11 га** байна.
- Үйлдвэр аж ахуйн бүс: Энэ бүсэд үйлдвэрүүд, хүнс бараа барилгын материал түлшний захууд, хоёрдогч түүхий эд хүлээн авах цэг, түүхий эдийн зах байрлаж **7.99 га** газарт байхаар төлөвлөв.
- Ойн зурвас ногоон байгууламжыг 22.72 га газарт төлөвлөж байна.
- Амралт зугаалгын бүс: Энэ бүс нь сумын төвийн зүүн хойд талд **58.27 га** газарт байрлана.




Зураг №3.2. Баяндалай сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл




Зураг №3.3. Баяндалай сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

2. Баян-Овоо сум

- Барилга байгууламжийн бүс: 2030 онд байх хүчин чадалтай нь уялдуулан хот төлөвлөлтийн нормоор тооцоход тухайн бүсэд 2030 он гэхэд 22.35 га газар шаардлагатай. Харин одоогийн байдлаар нийт **16.5 га** газар байна. Нөөц нь **15.14 га** газар байхаар төлөвлөв. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ, зам гудамж, ногоон байгууламж байрлана.
- Орон сууцны бүс: Хот төлөвлөлтийн нормоор 2030 онд тус бүсэд 31.0 га газар шаардлагатай байгаагаас одоогоор **132.91 га**, нөөц газар нь 93.26 га байна.
- Үйлдвэр аж ахуйн бүс: Баян-Овоо сум нь **15000 га** газарт үйлдвэрийн парк төлөвлөж байна. Мөн сумын төв дотор **12.57 га** газарт үйлдвэрүүд, хүнс бараа барилгын материал түлшний захууд, хоёрдогч түүхий эд хүлээн авах цэг, түүхий эдийн зах байрлаж байхаар төлөвлөв.
- Ойн зурвас, ногоон байгууламж. Энэ бүс нь сумын төвийн хойно, салхин дээр байрлах бөгөөд 5.8 га газарт байрлана.
- Амралт зугаалгын бүс. Энэ бүс нь сумын төвийн баруун хойд талд **9.26 га** газарт байрлана.
- Цэвэрлэх байгууламжийг сумын төвийн зүүн урд, сумын төвөөс 1.5 км зайнд **2.9 га** газарт байхаар төлөвлөв.




Зураг №3.4. Баян-Овоо сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл




Зураг №3.5 Баян-Овоо сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

3. Булган сум

- Барилга байгууламжийн бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа, үйлчилгээ, зам гудамж байрлана. Эдгээр барилга байгууламжийн 2030 онд байх хүчин чадалтай нь уялдуулан тооцоход тус бүсэд 24.66 га газар шаардлагатай. Одоогийн байдлаар 16.93 га газар, нөөц нь 7.11 га байна.
- Орон сууцны бүс: Хот төлөвлөлтийн нормоор 2030 онд тус бүсэд 35.2 га газар шаардлагатай байгаагаас одоогийн байдлаар **24.2** га байна. Нөөц нь **96.74** га газар байхаар төлөвлөв.
- Үйлдвэр аж ахуйн бүс: Сумын төвийн зүүн урд **3.62** га газарт үйлдвэрүүд, хүнс бараа барилгын материал түлшний захууд, хоёрдогч түүхий эд хүлээн авах цэг, түүхий эдийн зах байрлаж байхаар төлөвлөв.
- Ойн зурвасын бүс: Тус бүсийг 14.9 га газрыг эзлэн сумын төвийн баруун талаар байгуулахаар төлөвлөв.
- Ногооны талбай: Сумын төвийн зүүн урдуур 23.16 га газарт байрлана.
- Амралт зугаалгын бүс нь 6.4 га газартай байна.
- Мөн иргэнд өмчлүүлэх боломжтой газрын нийт хэмжээ 103.97 га газар байна.




Зураг №3.6. Булган сумын газар ашиглалтын бүсчлэл



Зураг № 3.7. Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

4. Гурвантэс сум

- Барилга байгууламжийн бүс: Засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ, зам гудамж ногоон суулгамал энэ бүсэд байрлана. Тэдгээрийн 2030 онд байх хүчин чадалтай нь уялдуулан хот төлөвлөлтийн нормоор тооцоход 2030 онд тус бүсэд 43.74 га газар шаардлагатай. Эндээс одоогийн байдлаар 7.98 га газар, нөөц нь 1.05 га байна.
- Орон сууцны бүс: Одоогийн байдлаар орон сууцны бүс газрын нийт хэмжээ **362.96 га** байна. Нөөц нь **299.1 га** газар байхаар төлөвлөв.
- Үйлдвэрийн бүс: Үйлдвэр районы бүсийг сумын төвийн зүүн талд салхины доор 7.58 га-д төлөвлөсөн.
- Онгоцны буудал, онгоц буух талбай нийлээд 133 га байна.
- Дулааны станц. 0.35 га газарт байрлана.
- Ногооны талбай: Сумын төвийн баруун хойд талд 1.2 га газарт байна.
- Амралт зугаалгын бүс: Энэ бүс нь 1.15 га газарт байрлана.
- Цэвэрлэх байгууламж сумын төвийн хойно 4.01 га газарт байрлана.
- Иргэнд өмчлүүлэх боломжтой газрын нийт хэмжээ 1447.8 га газар байна.




Зураг №3.8. Гурвантэс сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл




Зураг №3.9. Гурвантэс сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

5. Мандал-Овоо сум

- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ, зам гудамж, ногоон суулгамал байна. 2030 онд байх хүчин чадалтай нь уялдуулан хот төлөвлөлтийн нормоор тооцоход тус бүсэд 19.64 га газар шаардлагатай. Эндээс одоогийн байдлаар **7.7 га**, нөөц нь **8.4 га** газар байна.
- Орон сууцны бүс. Одоогийн байдлаар орон сууцны бүс газрын нийт хэмжээ **89.1 га** байна. Нөөц нь **129.9 га** газар байхаар төлөвлөв.
- Үйлдвэрийн бүс. Үйлдвэрийн бүсийг хогийн цэгийн хойно 1.37 га газарт төлөвлөв.
- Хогийн цэг. **2.71 га**-д байна. Талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүй.
- Ногооны талбай. **2.86 га** газартай байна.
- Оршуулгын газар. **1.97 га** газарт байрлана. Талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүй.
- Цэвэрлэх байгууламж. **1.98 га**-д сумын төвийн зүүн талд хогийн цэгийн хойд хэсэгт төлөвлөж байна.
- Нөхөн сэргээх газар. Нөхөн сэргээх шаардлагатай **3.31 га** газар сумын төвийн баруун хэсэгт байрлана.
- Иргэнд өмчлүүлэх боломжтой нийт газрын хэмжээ 826.77 га газар байна.




Зураг №3.10. Мандал-Овоо сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл



Зураг №3.11. Мандал-Овоо сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

6. Манлай сум

- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа, олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ, зам гудамж, ногоон суулгамал байна. 2030 онд байх хүчин чадалтай нь уялдуулан хот төлөвлөлтийн нормоор тооцоход тус бүсэд 23.9 га газар шаардлагатай. Одоогийн байдлаар 13.36 га газар, нөөц нь 11.2 га байна.
- Орон сууцны бүс. Хот төлөвлөлтийн нормоор тооцоход 2030 онд тус бүсэд 36.3 га газар шаардлагатай байгаа ч одоогийн байдлаар орон сууцны бүс газар нийт 67.5 га газар байна. Сумын нийт хүн амын өмчлөлд зориулж 2030 онд тус бүсийг 242.8 га-аар нэмэгдүүлэхээр төлөвлөж, эхний ээлжинд **154.3 га** газрыг төлөвлөв.
- Үйлдвэрийн бүс. Коксны үйлдвэр 509.27 га-д төлөвлөж байна. Мөн сумын төвд 2.3 га үйлдвэрийн бүс төлөвлөж байна.
- Дулааны станц. Сумын төвийн зүүн урд 5.28га газарт байрлана.
- Хогийн цэг. 9.93 га газарт байна. Талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүй.
- Иргэнд өмчлүүлэх боломжтой газрын нийт хэмжээ 811.5 га газар байна.




Зураг№3.12. Манлай сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл




Зураг№3.13. Манлай сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

7. Ноён сум

- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ, зам гудамж, ногоон суулгамал байна. Тэдгээрийн 2030 онд байх хүчин чадалтай нь уялдуулан хот төлөвлөлтийн нормоор тооцоход тус бүсэд 25.4 га газар шаардлагатай байна. Одоогийн байдлаар тус бүсийн нийт газар 14.24 га, нөөц нь 5.01 га байна.
- Орон сууцны бүс. Энэ бүс нутаг 49.52 га байна. Нөөц нь 310.3 га байна.
- Үйлдвэрийн бүс. Үйлдвэрийн бүсийг сумын төвийн зүүн урд 4.45 га газарт төлөвлөв.
- Дулааны станц. 0.13 га газарт байрлана.
- Ойн зурвас ногоон байгууламж. 7.3 га газартай байна.
- Хогийн цэг. 20.99га талбайтай байна. Талбайг нэмэгдүүлэхгүй
- Амралт зугаалгын бүс. 31.97 га газартай байхаар төлөвлөв.
- Ногооны талбай. 0.5 га газартай байна.
- Оршуулгын газар. 1.25 га газарт байрлана. Талбайг нэмэгдүүлэхгүй.




Зураг №3.14. Ноён сумын газар ашиглалтын бүсчлэл




Зураг №3.15. Ноён сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

8. Номгон сум

- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг худалдаа үйлчилгээ, зам гудамж, ногоон суулгамал байна. Тэдгээрийн 2030 онд байх хүчин чадалтай нь уялдуулан хот төлөвлөлтийн нормоор тооцоход тус бүсэд 21.71 га газар шаардлагатай. Одоогийн байдлаар 32.36 га газар байна. Нөөц нь 31.97 га газар байна.
- Орон сууцны бүс. Одоогийн байдлаар 67.67 га газар байна. Нөөц нь 299.27 га газар байна.
- Үйлдвэрийн бүсийг сумын төвийн зүүн урд 6.95 га газарт төлөвлөв.
- Онгоцны буудал. Сумын төвийн зүүн талд онгоц буух, хөөрөх зориулалтаар 7.71 га газрыг төлөвлөж байна.
- Дулааны станц. 1.33 га газарт байрлана.
- Ойн зурвас. Сумын төвийн баруун хойд талаар 12.57 га газрыг эзэлсэн хамгаалалтын ойн зурвас байгуулахаар төлөвлөв.
- Хогийн цэг. 17.8 га талбайтай байгааг нэмэгдүүлэхгүй.
- Цэвэрлэх байгууламж. 2.37 га газарт хогийн цэгийн хойно төлөвлөж байна.




Зураг №3.16. Номгон сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл



Зураг №3.17. Номгон сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

9. Сэврэй сум

- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. 2030 онд байх тэдгээр байгууллагын хүчин чадалтай нь уялдуулан хот төлөвлөлтийн нормоор тооцоход 26.8 га газар шаардлагатай. Одоогийн байдлаар тус бүс нутгийн нийт талбай 11.93 га газар, нөөц нь 3.13 га газар байна.
- Орон сууцны бүс. Одоогийн байдлаар орон сууц, гэр хорооллын бүсийн нийт талбай 58.73 га газар, нөөц нь 256.82 га байна.
- Үйлдвэрийн бүс. 12.7 га газарт байрлана.
- Ойн зурвас, ногоон байгууламжын бүс 7.1 га газарт байрлана.




Зураг№3.18. Сэврэй сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл




Зураг№3.19. Сэврэй сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

10. Ханбогд сум

- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. 2030 онд байх тэдгээр байгууллагын хүчин чадалтай нь уялдуулан хот төлөвлөлтийн нормоор тооцоход 33.9 га газар шаардлагатай гэсэн тооцоо гарсанч одоогийн байдлаар барилга байгууламжийн бүс нутгийн нийт талбай 140.6 га газар, нөөц нь 117 га газар байна.
- Орон сууцны бүс. Одоогийн байдлаар орон сууц гэр хорооллын бүс нутгийн нийт талбай 692 га газар байна. Нөөц нь 457,2 га байна.
- Үйлдвэрийн бүс. Тус бүсийг 14.37 га газарт байхаар төлөвлөв.
- Дулааны станц. 4.18 га газарт байрлана.
- Ойн зурвас, ногоон байгууламжын бүс. 41.9га газарт байрлана.
- Ногооны талбай. 15.51 га-д байрлана.
- Иргэнд өмчлүүлэх боломжтой газрын нийт хэмжээ 1548.5 га байна.



Зураг №3.20. Ханбогд сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл




Зураг №3.21. Ханбогд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө


11. Ханхонгор сум

- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. 2030 онд байх тэдгээр байгууллагын хүчин чадалтай нь уялдуулан хот төлөвлөлтийн нормоор тооцоход 22.0 га газар шаардлагатай гэсэн тооцоо гарсанч одоогийн байдлаар барилга байгууламжийн бүс нутгийн нийт талбай 3.39 га газар, нөөц нь 3.82 га газар байна.

- Орон сууцны бүс. Одоогийн байдлаар орон сууц, гэр хорооллын бүс газрын нийт талбай 72.71 га. Нөөц нь 5333.72 га байна. Ханхонгор сум нь аймгийн төвөөс орж ирдэг төв зам дагуу суурьшлийн бүс төлөвлөж байгаа нь 5100 га газрын нөөцтэй байна.
- Үйлдвэрийн бүс. Тус бүсийн нийт талбай 158.37 га газар байна. Шинээр аймгийн төвөөс орж ирдэг зам дагуу 137 га газарт үйлдвэрийн бүс төлөвлөж байна.
- Ойн зурвас, ногоон байгууламж. Энэ бүс нь 38.44 га газарт байгуулагдана.
- Үерээс хамгаалах далан. 4.16 га газарт төлөвлөж өгөв.




Зураг№3.22. Ханхонгор сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл




Зураг№3.23. Ханхонгор сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

12. Хүрмэн сум

- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. 2030 онд байх тэдгээр байгууллагын хүчин чадалтай нь уялдуулан хот төлөвлөлтийн нормоор тооцоход 24.6 га газар шаардлагатай. Одоогийн байдлаар барилга байгууламжийн бүс нутгийн нийт талбай 11.27 га газар, нөөц нь 11.9 га газар байна.
- Орон сууцны бүс. Одоогийн байдлаар орон сууц гэр хорооллын бүс газрын нийт талбай 26.5 га, нөөц нь 134.29 га байна.
- Үйлдвэрийн бүс. Хогийн цэгийн баруун талд 2.37 га газарт төлөвлөж байна.
- Дулааны станц. 0.41 га газарт байрлана.
- Ногоон байгууламжийн бүс. Энэ бүс нь 11.69 га газар байна.
- Хогийн цэг. Сумын төвийн зүүн талд 23.47 га газарт байрлана. Талбайн хэмжээг хот төлөвлөлтийн нормын дагуу хумих шаардлагатай.
- Ногооны талбай. Сумын төвийн урд хэсэгт 6.85 га газарт байрлана.
- Амралт зугаалгын бүс. 3.6 га газарт байрлахаар төлөвлөв.
- Оршуулгын газар. 1.01 га газартай байна. Талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүй.
- Цэвэрлэх байгууламж. 1.36 га газарт байрлана.




Зураг №3.24. Хүрмэн сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл




Зураг №3.25. Хүрмэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

13. Цогт-Овоо сум

- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. 2030 онд байх тэдгээр байгууллагын хүчин чадалтай нь уялдуулан хот төлөвлөлтийн нормоор тооцоход 24.52 га газар шаардлагатай. Одоогийн байдлаар барилга байгууламжийн бүс нутгийн нийт талбай 32.32 га газар, нөөц нь 5.69 га газар байна.
- Орон сууцны бүс. Одоогийн байдлаар орон сууц гэр хорооллын бүс газрын нийт талбай 33 га, нөөц нь 124.2га байна.
- Үйлдвэр аж ахуйн бүс. Энэ бүсэд үйлдвэрүүд, хүнс бараа, түлш, барилгын материалын зах, агуулах байрлана. Нутаг дэвсгэрийн хэмжээ нь 9.8 га байна.
- Ойн зурвас ногоон байгууламж. Сумын төвийн хойд талаар 13.79га газарт хамгаалалтын ногоон зурвас байхаар төлөвлөв.
- Хогийн цэг. Энэ нь 0.46 га газарт байрлана. Талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүй.
- Цэвэрлэх байгууламж. 0.98 га газартай байна.
- Иргэнд өмчлүүлэх боломжтой газрын нийт хэмжээ 1043.1 га газар байна.



Зураг№3.26. Цогт-Овоо сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл




Өмнөговь аймгийн Цогт-Овоо сум
СУМЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ


Зураг№3.27. Цогт-Овоо сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

14. Цогтцэций сум

- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зам гудамж ногоон суулгамал байрлана. 2030 онд байх тэдгээр байгууллагын хүчин чадалтай нь уялдуулан хот төлөвлөлтийн нормоор тооцоход 24.52 га газар шаардлагатай гэсэн тооцоо байгаа ч одоогийн байдлаар барилга байгууламжийн бүс нутгийн нийт талбай 63.16 га газар, нөөц нь 4.33 га газар байна.
- Орон сууцны бүс. Одоогийн байдлаар орон сууц гэр хорооллын бүс газрын нийт талбай 387.9 га, нөөц нь 222.25 га байна.
- Үйлдвэрийн бүсийг 13.04 га-д төлөвлөж байна.
- Онгоцны буудал 125.6 га газарт байрлана.
- Ойн зурвас, ногоон байгууламж. 13.79 га газарт байна.
- Иргэнд өмчлүүлэх боломжтой газрын нийт хэмжээ 17053 га газар байна.



Зураг№3.28. Цогтцэций сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл



Зураг №3.29. Цогтцэций сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл




Зураг №3.30. Цогтцэций сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

15. Даланзадгад

- Барилга байгууламжийн бүс. Энэ бүсэд засаг захиргаа олон нийтийн байгууллагууд, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, зам гудамж, худалдаа үйлчилгээ, ногоон суулгамал байрлана. Бүсийн нутаг дэвсгэр нь 108.85 га байна.
- Суурьшлийн бүс. Бүсийн газар нутгийн хэмжээ 1182.11 га байна. Нөөц нь 2334.65 га байна.
- Үйлдвэрлэлийн бүс. Үйлдвэрүүд, хүнс, бараа барилгын материал, түлшний зах агуулахууд тус бүсэд байрлаж 2960.6 га газартай байна.

- Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бүс. Хотын зүүн баруун талд нийт 678 га газрыг хамран байрлахаар төлөвлөв.
- Онгоцны буудал. 96.3 га газартай байна.
- Ногоон байгууламж, амралт зугаалгын бүс. Хотын хойно зонхилох салхины дээд тал болон баруун урд талаар нийт 2697.021 га газар нутагт байрлана.
- Иргэнд өмчлүүлэх боломжтой газрын нийт хэмжээ 15419.21 га байна.



Зураг №3.31. Даланзадгад сумын төвийн газар ашиглалтын бүсчлэл

Хүснэгт №3.20. Өмнөговь аймгийн сумдын төвийн газар ашиглалтын одоогийн байгаа байдал, төлөвлөлт

№	Сумдын нэр	Засаг захиргаа, соёл үйлчилгээ, барилга байгууламжийн бүс	Засаг захиргаа, соёл үйлчилгээ, барилга байгууламжийн бүсийн нөөц газар	Гэр орон сууцны бүс	Гэр орон сууцны нөөц газар	Үйлдвэр аж ахуйн бүс	Эрчимжсэн МАА хөгжүүлэх бүс	Онгоцны буудал	Дулааны станц	Ойн зурвас ногоон байгууламж	Хогийн цэг	Ногооны талбай	Амралт зугаалгын бүс	Оршуулгын газар	Цэвэрлэх байгууламж	Нөхөн сэргээх газар	Үерээс хамгаалах далан	Иргэнд өмчлүүлэх боломжтой газар	Нийт талбай /га-аар/
		0	1	2	3	4	5	6	7	8	10	12	13	14	17	18	19	20	23
1	Даланзадгад	108.85		1182.11	2334.65	2960.64	677.74	96.38		2697.01								15419.21	
2	Баяндалай	15.19	2.14	82.64	397.11	7.99				22.72			58.27						586.06
3	Баян-Овоо	16.5	15.14	132.91	93.26	15012.57				5.8			9.26		2.99				15288.43
4	Булган	16.93	7.11	24.24	96.74	3.62				14.9		23.16	6.4					103.97	297.07
5	Гурвантэс	7.98	1.05	362.96	299.16	7.58		132.97	0.35	9.8		1.2	1.15		4.01			1447.78	2275.99
6	Мандал-Овоо	7.7	8.4	89.16	129.88	1.37				6.6	2.71	2.86		1.97	1.98	3.31		826.77	1082.71
7	Манлай	13.36	11.25	67.55	154.33	509.27			5.28	6.6	9.93							811.5	1589.07
8	Номгон	32.36	31.97	67.67	299.27	6.95		7.71	1.33	12.57	17.8				2.37				480
9	Ноён	14.24	5.01	49.52	310.3	4.45			0.13	7.3	20.99	0.5	31.97	1.25					445.66
10	Сэврэй	11.95	3.13	58.73	256.82	12.7				7.1									350.43
11	Ханбогд	140.66	117.366	692.02	457.22	14.37			4.18	41.9		15.51						1548.54	3031.766
12	Ханхонгор	3.39	3.82	72.71	5333	158.38				38.44							4.16		5613.9
13	Хүрмэн	11.27	11.9	26.55	134.29	2.37			0.41	11.69	23.47	6.85	3.61	1.01	1.36				234.78
14	Цогтовоо	32.32	5.69	33	124.26	9.8				3.5	0.46				0.98			1043.05	1253.06
15	Цогтцэций	63.16	4.33	387.91	222.55	13.04		125.65		13.79								17053.3	17883.76
16	НИЙТ	495.86	228.306	3329.68	10642.84	18725.1	677.7	362.7	11.68	2899.72	75.36	50.08	110.66	4.23	13.69	3.31	4.16	38254.15	75889.276

Хүснэгт №3.21. Өмнөговь аймгийн сумдын тэг гортигийн төлөвлөлт

№	Сум	Одоо байгаа тэг гортиг /га/	Нэмэгдэх талбай /га/	Нийт талбай /га/
1	Даланзадгад	2310.13	-	2310.13
2	Баяндалай	279.78	565.32	845.1
3	Баяновоо	529.72	748.42	1278.14
4	Булган	344.57	744.263	1088.833
5	Гурвантэс	445.39	700.89	1146.28
6	Мандал-Овоо	211.85	405.5	617.35
7	Манлай	144.82	1197.76	1342.58
8	Номгон	4796.28	-	4796.28
9	Ноён	296.71	402.1	698.81
10	Сэврэй	502.79	886.33	1389.12
11	Ханбогд	135.58	4894.4	5029.98
12	Ханхонгор	1074.8	1648.74	2723.54
13	Хүрмэн	398.52	927.55	1326.07
14	Цогтовоо	2923.59	-	2923.59
15	Цогтцэций	921.61	1445.29	2366.9
НИЙТ		15316.14	14566.563	29882.703

3.3.2. Хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх

Хот байгуулалтын зураг төслийн дагуу эхний ээлжинд зам тээвэр, инженерийн үндсэн дэд бүтцийг барьж байгуулах, орон сууцны хороолол, үйлдвэр үйлчилгээний барилга байгууламжийг бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, тохижилтын хамт иж бүрэн барих шаардлагатай.

Хот байгуулалтын зураг төслийн үндсэн шаардлага, үе шатны зорилт, эдэлбэр газрын зориулалт, инженерийн шугам сүлжээний даац, технологийн горимын дагуу газар олголт хийж, ерөнхий төлөвлөгөөг зөрчихийг хориглоно.

Түүх соёлын дурсгалт газар, тусгай хамгаалалттай болон дархан цаазтай газрын бүс, усны эх, түүний эрүүл ахуй хамгаалалтын бүс, ашигт малтмалын орд бүхий газар, байгалийн болон гэнэтийн осолд өртөх өндөр магадлалтай газар, экологийн онцгой байдалтай газар, инженерийн дэд бүтэц бүхий бүсэд хот байгуулалтын үйл ажиллагааг хязгаарлана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАМ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ**4.1. Зам шугам сүлжээний газрын одоогийн байдал****4.1.1. Зам, тээврийн сүлжээний өнөөгийн байдал**

Монгол орны ихэнх аймгуудын адил энэ бүс нутгийн хувьд авто зам тэргүүн зэргийн ач холбогдолтой. Өмнөговь аймгаас Улаанбаатар хүртэл зам нь зорчигч тээврийн гол зам бөгөөд 2014 онд хатуу хучилттай замтай болсон.

Аймгийн төв Даланзадгад хотоос сумдуудад хүрэх 1672 км шороон замтай. Харин Таван Толгойгоос Гашуун Сухайтын боомт хүртэл даацын 267 км хатуу хучилттай замыг Энержи ресурс компани өөрийн хөрөнгөөр барьж дуусгасан байна. Нарийн сухайт-Шивээ хүрэнгийн чиглэлд 43.2 км хүнд даацын машин явах боломжтой хатуу хучилттай авто замыг концессын гэрээгээр барьж 2014 оны 9 сард ашиглалтанд оруулжээ. Нийт 466.2 км хатуу хучилттай зам ашиглагдаж байна.

Хүснэгт №4.1. Зам, шугам сүлжээний газар дахь авто замын эзлэх хэмжээ/2013 оны ГНС-н тайлангаар/

Сумдын нэр	Зам, шугам сүлжээний газар /га/	
	Нийт газар	Зам тээврийн газар
Баяндалай	579.41	472.00
БаянОвоо	3406.48	3134.28
Булган	497.81	451.00
Гурвантэс	2208.86	1938.67
Даланзадгад	545.20	366.37
Мандал-овоо	711.80	610.20
Манлай	1288.28	780.00
Номгон	504.85	394.00
Ноён	557.57	512.00
Сэврэй	484.02	448.00
Ханбогд	7589.6	5272.73
Ханхонгор	1716.92	775.37
Хүрмэн	680.54	617.00
ЦогтОвоо	766.65	616.12
Цогтцэций	5284.12	3741.41
Дүн	26822.08	20129.15

Тус аймагт уул уурхай эрчимтэй хөгжиж байгаа боловч хатуу хучилттай зам тавигдаагүй ердийн хөрсөн замаар хүнд даацын автомашинаар тээвэрлэлт хийж байгаагаас говийн эмзэг хөрс, ургамал авто замын тоос шороонд дарагдан, хөрс их хэмжээгээр эвдэрч, ургамлын бүрхэвч өөрчлөгдөж, байгаль-экологи их хэмжээгээр сүйтгэгдэх болсноос гадна зэрлэг болон ховор ан амьтан орон нутгаас дайжих, хорогдох зэрэг сөрөг нөлөөлүүд гарсаар байна. Энэ ноцтой байдалд дүгнэлт хийж, уул уурхайн тээврийн авто замуудыг хатуу хучилттай болгох улмаар ихээхэн хэмжээний олборлолт хийж түүнийг автотээврээр хийж байгаа уурхайн тээврийг /Таван толгой г. м./ төмөр замын тээврээр солих, түүнийг хөгжүүлэх ажил хийгдэж эхлээд байна.

Хүснэгт №4.2. Өмнөговь аймгийн хот хоорондын болон уул уурхайн замуудын одоогийн байдал

Авто замын чиглэл, нэр	Хучилтын төрөл	Хүчин чадал /км/	Төсөвт өртөг Тэрбум/төг
Мандалговь-Даланзадгад	Хатуу хучилттай	156.0	2014 онд баригдаж дуусна
Тавантолгой -Гашуунсухайт	Хатуу хучилттай	267.0	Баригдсан

Нарийнсухайт-Шивээхүрэн	Хатуу хучилттай	43.2	Концессоор баригдсанбаригдсан
Оюунтолгой-Гашуунсухайт	Хатуу хучилттай	90.0	Уухайн хөрөнгөөр баригдсан
Дүн		466.2	
Оюунтолгой-Ханбогд-Ханги чиглэл	Ердийн хөрсөн	435.0	Концессийн тендер зарлагдаад байна.
Цогт-Овоо-Цогтцэций	Ердийн хөрсөн	80.0	
Даланзадгад-Цогтцэций /Тавантолгой/	Ердийн хөрсөн	94.8	
Дүн		609.8	

Хүснэгт №4.3. Өмнөговь аймгийн сумууд аймгийн төвийн хоорондын замуудын одоогийн байдал

№	Авто замын чиглэл	Нийт зай /км/	Хучилтын төрөл
1	Баяндалай	84.0	Ердийн хөрсөн
2	Баян-Овоо	162.0	Ердийн хөрсөн
3	Булган	98.0	Ердийн хөрсөн
4	Гурвантэс	320.0	Ердийн хөрсөн
5	Даланзадгад		
6	Мандал-Овоо	140.0	Ердийн хөрсөн
7	Манлай	224.0	Ердийн хөрсөн
8	Номгон	106.0	Ердийн хөрсөн
9	Ноён	216.0	Ердийн хөрсөн
10	Сэврэй	214.0	Ердийн хөрсөн
11	Ханбогд	250.0	Ердийн хөрсөн
12	Ханхонгор	25.0	Ердийн хөрсөн
13	Хүрмэн	61.0	Ердийн хөрсөн
14	Цогт-Овоо	126.0	Хатуу хучилттай
15	Цогтцэций	98.0	Ердийн хөрсөн
	Дүн	1672.0	
	Үүнээс: Хатуу хучилттай	126.0	

Аймгийн төвийг сумуудтай холбосон нийт замын урт нь 1672 км бөгөөд үүнээс Цогт-Овоо хатуу хучилттай замаар холбогдсон ба бусад сумууд нь ердийн хөрсөн замтай байна.

Өмнөговь аймгийн зам тээврийн одоогийн байдлын SWOT шинжилгээ :
давуу талууд :

- Улаанбаатар болон бусад хотуудтай хатуу хучилттай замаар холбогдсон
- Шинээр байгуулах замын чиглэл нь тодорхой концесс зарлагдсан
- Нутгийн баруун талаар босоо тэнхлэгийн чиглэлийн зам дайран өнгөрдөг
- Улсын чанартай замууд нь сумуудыг аймагтайгаа холбосон замтай давхцдаг
- Уул уурхай хөгжиж байгаас болон аймгийн хэмжээгээр автомашины тоо нэмэгдэж байгаагаас болж замын хөдөлгөөний эрчим жил бүр нэмэгдэж байгаа

Сул талууд :

- Нийслэл хотоос зайтай оршдог
- Ажил гүйцэтгэхэд улирлын чанартай байдаг
- Аймгийн төв нь сумуудтайгаа шороон замаар холбогдсон.

- Говийн эмзэг хөрс, ургамалтай

Боломж :

- Замын бэлэн суурь баазтай
- Байгалийн зам барилгын материалтай элбэгтэй
- Мэргэжлийн байгууллага, боловсон хүчинтэй

Аюул занал :

- Автозамын тоос шороо нь байгаль орчин бохирдуулах, бэлчээр сүйтгэх
- Зэрлэг ан амьтанд сөрөг нөлөө үзүүлэх
- Барьсан зам нь үеэр ус болон бусад байгалийн гэнэтийн аюулд өртөх магадлалтай
- Барьж байгуулахад байгалийн шалгуур өндөр

Агаарын тээвэр

Улаанбаатараас Даланзадгадын чиглэлд агаарын зорчиг тээврийн 3 компани ажиллаж, ИНЕГ-ын харьяа 3 нисэх буудал үйчлilгээг хариуцдаг. Тус аймагт төвийн Говь-Гурван сайхан нисэх буудал, Оюутолгойн нисэх буудал буюу Ханбумбат, Овоотын нисэх буудал гэсэн хатуу хучилт бүхий нисэх буух зурвастай гурван нисэх буудал ажиллаж байна. Оюутолгой, Овоотын нисэх буудлуудыг компаниуд өөрийн хөрөнгөөр байгуулсан.

Хүснэгт №4.4. Агаарын тээвэр

Агаарын тээврийн компани	Онгоцны төрөл	Суудлын тоо	Өвлийн нислэгийн тоо	Зуны нислэгийн тоо
МИАТ ХХК	АН 24	42	2	2
Изинис эйрвэйс	СААБ	34	2	5-11
Аеромонгол ХХК	Фокер 50	50	Захиалгаар	Захиалгаар

Төмөр зам

Одоогийн байдлаар судалгааны нутагт төмөр замын сүлжээ байхгүй. Цаашид Монгол Улсын 2010-2015 оны эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлд уул уурхайн төмөр замын салбарыг хөгжүүлэхээр заажээ. Ойрын ирээдүйд уул уурхайн бүтээгдэхүүнийг дотоодын хэрэгцээ шаардлагыг хангахад мөн экспортод гаргахад чиглэгдсэн ихээхэн хэмжээний ачаа урсгал бий болох бөгөөд энэхүү ачаа урсгалыг үр дүнтэй, найдвартай төмөр замын тээврээр хангах шаардлага зүй ёсоор урган гарж байна. Ялангуяа нэн тэргүүн ээлжинд цаг алдалгүй шийдвэрлэх асуудал бол говийн бүс нутаг дахь төмөр замын дэд бүтцийн асуудал болоод байна.

4.1.2. Шугам сүлжээний газрын өнөөгийн байдалХолбоо мэдээллийн сүлжээ

Судалгааны бүс нутагт болох Дундговь, Өмнөговь аймгуудад Монголын цахилгаан холбоо, Монгол шуудан компаниуд шуудангийн үйлчилгээг үзүүлдэг ба эдгээр компаниудын 60 орчим салбарууд үйл ажиллагаа явуулж байна. Бодлого судлалын төвийн судалгаанаас харахад сүүлийн жилүүдэд суурин телефон утас, телефон яриа, цахилгаан

мэдээ, албан бичиг болон захидал илгээх зэрэг шуудан холбооны уламжлалт хэрэглээ буурч харин үүрэн телефон утасны хэрэглээ эрс нэмэгдсэн байна. Судалгааны нутагт Мобиком, Скайтел, Юнител, Ж-мобайл, МЦХ зэрэг операторууд үүрэн телефоны үйлчилгээг үзүүлж байна. Аймгийн төвийн хүн амын 20 орчим хувь нь, сумдын хүн амын 2 орчим хувь нь интернэт хэрэглэж байна. Өмнөговь аймагт телевизийн 4 суваг, 2 сонин ажилладаг. Аймгийн телевиз нь 25 км-т нэвтрүүлгээ цацдаг. Малчин өрхүүдийн ихэнх нь радио эсвэл сансрын антеннаар дамжуулан үндэсний радио, телевизийн нэвтрүүлгийг хүлээн авч үздэг.

Өмнөговь аймгийн холбооны одоогийн байдлын SWOT шинжилгээ :

Давуу талууд :

- Нийслэл хоттой шилэн кабелиар холбогдсон.
- 6 сумаас бусад нь аймгийнхаа төвтэй шилэн кабелиар холбогдсон.
- Даланзадгад сумын төвд радио өргөн нэвтрүүлгийн станцтай.
- Аймгийн төв болон сум нь интернетийн үйлчилгээтэй.
- Холбооны үйлчилгээ явуулдаг бэлэн суурь баазтай.
- Бүх сумуудын төвүүдэд нь хөдөлгөөнт холбооны сүлжээ орсон.

Сул талууд :

- 6 сум шилэн кабельд холбогдоогүй.
- Хөдөөгийн малчдад хөдөлгөөнт холбооны сүлжээгээр бүрэн хангагдаагүй.

Боломж :

- Мэргэжлийн байгууллага, боловсон хүчинтэй
- Шилэн кабель орсон сумууд интернет болон бусад холбооны үйлчилгээ авах бүрэн боломжтой
- Радио, телевизийг тоон технологид шилжих бололцоог хангасан

Аюул занал :

- Холбооны агаарын шугамууд нь байгалийн эрсдэлд орох талтай
- Холбооны шугам байгуулах, үйлчилгээ явуулахад байгалийн хүнд нөхцөлтэй
- Өргөн уудам газар нутагт байнга нүүдэллэн амьдарч байгаа хөдөөгийн малчдыг хөдөлгөөнт холбооны сүлжээгээр хангахад бэрхшээлтэй

Цахилгаан эрчим хүчний шугам сүлжээний өнөөгийн байдал

2013 оны 07 сард Даланзадгадад баригдсан 110/350/10 кВ-ын 2 x 10 МВА трансформатортай дэд станц ашиглалтанд орсноор төвийн бүсийн эрчим хүчний системд Цогтцэций сумын нутаг дахь “Тавантолгой” дэд станцаас 110 кВ-ын ЦДАШ-аар аймгийн төв ба 9 сум Төвийн эрчим хүчний систем, Даланзадгадын ДЦС-д холбогдон 2 талын тэжээлтэй, Манлай сум Цогтцэций сумын нутаг дахь “Тавантолгой” дэд станцаас 35 кВ-ын ЦДАШ-аар төвийн эрчим хүчний системд холбогдсон, Ноён, Сэврэй, Гурвантэс сумд БНХАУ-аас Нарийнсухайтын уурхайн эх үүсвэрээс эрчим хүчээ авдаг байна. Ханбогд, Баян-Овоо сумд Оюутолгойгоор дамжуулан БНХАУ-аас ЦЭХ-ээр хангагддаг. Өмнөговийн хэрэглэгчдийг Төвийн эрчим хүчний системтэй холбосон Мандалговь-Тавантолгой-Оюутолгойн 220 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам баригдсанаар Өмнөд бүсийг төвийн эрчим хүчний системд холбож, говийн бүсийн хэрэглэгчид

найдвартай цахилгаанаар хангагдах төдийгүй Төвийн бүсийн хэрэглэгчдийн цахилгаан хангамжийн байдлыг дээшлүүлэх боломж бүрдэж байгаа юм.

Аймгийн хэмжээнд 2013 оны байдлаар эрчим хүчний шугам, станцын эзлэх талбай 2325.34 га байна.

Хүснэгт№4.5. Өмнөговь аймгийн цахилгаан хангамжийн судалгаа, 2014оны 01-р сарын байдлаар

Аймгийн нэр	Нийт сумдын тоо	Дотоодын төвлөрсөн цахилгаан хангамжийн системд өндөр хүчдэлийн ЦДАШ-р холбогдсон сумд	Төвийн эрчим хүчний системд холбогдсон	БНХАУ-ын хил орчмийн эрчим хүчний системд ЦДАШ-р холбогдсон сумд	Төвлөрсөн цахилгаан хангамжинд холбогдоогүй дан ганц Дизель станцаар хангагдаж буй сумд	Тайлбар
Өмнөговь	15	9	10	3	-	10 сум ТЭХС-д, 9 сум Даланзадгадын ДЦС-д холбогдсон. Ноён, Сэврэй, Гурвантэс сумд Нарийнсухайтын уурхайн БНХАУ-аас татсан 35 кВ-ын ЦДАШ-д холбогдсон. Ханбогд, Баян-Овоо сумд Оюутолгойгоор БНХАУ-аас, Манлай сум дан ТЭХС-ээс, бусад 9 нь Дал ДЦС-ээс 2 талын эх үүсвэртэй

Доорхи хүснэгтэд Өмнөговь аймгийн 15 сумдын эрчим хүчний эх үүсвэр, ашиглалтанд орсон хугацаа, шугамын төрөл, шугамын урт, хүчин чадал, хөрөнгө оруулалт зэргийг тусгаж өгсөн болно.

Хүснэгт№4.6. Өмнөговь аймгийн цахилгаан шугам сүлжээ

№	Сумдын нэр	Эх үүсвэр	Ашиглалтанд орсон хугацаа	Хүчин чадал	Хөрөнгө оруулалт /сая ₮/
1	Ханбогд	Оюу толгой, Ханбогд	2013	35кВ-ын дэд станц	6900.0
2	Манлай	Таван толгой, Цогтцэций Нар, салхи хосолсон цахилгаан станц	2011	35кВ-ын дэд станц	910
3	Баяновоо	Оюу толгой, Ханбогд	2013	35кВ-ын дэд станц	Тодорхойгүй
4	Цогтцэций	Тавантолгойгоос 10 кВ-ын 12,4 км ЦДАШ	2008	10/0.4 кВ-ын 1х0.1, 1х0.16 МВА дэд станц	300
5	Номгон	Даланзадгад сумаас 15 кВ-ын 101.2 км ЦДАШ	2007	6/15 кВ-ын 1х0.25 МВА, 15/0.4 кВ-ын 2х0.1 МВА дэд станц	1168.0
6	Цогт-Овоо	Дундговь аймгийн Хулд сумаас 15 кВ-ын 91.922 км ЦДАШ	2008	10/15 кВ-ын 1х0.25 МВА 15/0.4 кВ-ын 1х0.1, 1х0.16 МВА дэд станц	1025
7	Хан-Хонгор	Даланзадгад сумаас 10 кВ-ын 24км ЦДАШ	2009	10/0.4 кВ-ын 1х0.1, 1х0.16 МВА дэд станц	580
8	Даланзадгад	Даланзадгад ДЦС	2000	5,4 МВт	

9	Мандал-Овоо	Дундговь аймгийн Сайхан-Овоо сумаас 15 кВ-ын 99,26 км ЦДАШ	2007	0.4/15 кВ-ын 1х0.25 МВА, 15/0.4 кВ-ын 1х0.16, 1х0.1 МВА дэд станц	1140
10	Хүрмэн	Даланзадгад сумаас 35 кВ-ын 48.3 км ЦДАШ	2008	110/35/10кВ-ын дэд станц 2х10МВА 35/6 кВ-ын дэд станц 2х10 МВА	621.3
11	Булган	Жуулчин говиос сумаас 15 кВ-ын 59,75 км ЦДАШ		10/15 кВ-ын 1х0.4, 2х0.25 МВА дэд станц	732.2
12	Баяндалай	Хүрмэн сумаас 10 кВ-ын 49,5 ЦДАШ	2002	10/0.4 кВ-ын 1х0.1, 1х0.16 МВА дэд станц	234.5
13	Сэврэй	Ноён сумаас 15 кВ-ын ЦДАШ	2011	60х2, 1х0.1, 1х0.16 МВА дэд станц, Салхин станц 80 кВт	389,4
14	Ноён	Нарийн сухайтаас 35 кВ-ын 86,1 км ЦДАШ,	2011	35/15 кВ-ын 1х0.63 МВА, 2х0.16 МВА дэд станц,	1320 ЦДАШ
15	Гурвантэс	Нарийнсухайтаас 10 кВ-ын ЦДАШ	2009	10/0.4 кВ-ын 1х0.1, 1х0.16 МВА дэд станц	Хувийн ХО

Өмнөговь аймгийн хувьд цахилгаан дамжуулах шугамын хамгаалалтын зурвас газрын хэмжээг гаргахдаа доорхи хүснэгтэнд буй зохих нормын дагуу гаргав. Үүний тулд шугамын төрлөөс хамаарч шугамаас хоёр тийш 10-30м хамгаалалтын зурвасыг авч талбайг гаргав.

Хүснэгт №4.7. Цахилгаан шугамын хамгаалалтын зурвас газрын норм

№	Шугам сүлжээ тоног төхөөрөмж	Хүн оршин суудаггүй газраар өнгөрөх нөхцөлд	Хүн оршин суудаг газраар өнгөрөх нөхцөлд	Дэд станц, дулаан дамжуулах төв, хуваарилах байгууламж	Газар дээр ил байрласан	Газар дор байрласан	Усан дор байрласан	Ой мод, цэцэрлэг дундуур өнгөрөх нөхцөлд
		Шугамын захын утаснаас хоёр тийш						
0	1	2	3	4	5	6	7	8
1	Цахилгааны дамжуулах шугам: а/ 1кв хүртэл	-	1-1.5 м	-	-	-	-	-
	б/1-20 хүртэл кв	10 м	2 м	10 м	-	-	-	2 м
	в/ 35 кв	15 м	4 м	15 м				3 м
	г/ 110 кв	20 м	5 м	20 м				3 м
	д/ 220 кв	25 м	6 м	25 м				4 м
	е/ 330-500 кв	30 м	10 м	30 м				5 м
2	Кабель шугам	-	-	-	-	1 м	100 м	-
3	Дулааны шугам а/ 500 мм хүртэл голчтой	-	-	5 м	3 м	5 м	-	-
	б/ 500 мм-ээс дээш голчтой	-	-	5 м	5 м	7 м	-	-

Хүснэгт №4.8. Өмнөговь аймгийн эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвасын хэмжээ

№	Сумд	Шугамын төрөл /35кВт/	Урт /км/	Талбай /га/
1	Даланзадгад	-	-	-
2	Баяндалай	10кВ	49.5	99

3	Баяновоо	35 кВ	60	180
4	Булган	10кВ	59.75	119.5
5	Гурвантэс	6кВ	28	54
6	Мандал-Овоо	15кВ	99.26	198.52
7	Манлай	35 кВ	138	414
8	Номгон	15кВ	101.2	202.4
9	Ноён	35кВ	86.1	258.3
10	Сэврэй	15кВ	60	120
11	Ханбогд	35 кВ	48	144
12	Ханхонгор	10кВ	24	48
13	Хүрмэн	35кВ	48.3	144.9
14	Цогтовоо	15кВ	91.92	183.84
15	Цогтэций	10кВ	12.4	24.8

Тус аймгийн хувьд нийт эрчим хүчний шугам сүлжээний урт 906.43 км, нийт талбай 2191.26 га байна.

Дулаан хангамж

“Даланзадгадын ДЦС” ТӨХК нь БНСУ-ын зээлийн хөрөнгөөр 6 мВт-ын суурилагдсан хүчин чадалтайгаар байгуулагдсан бөгөөд одоогоор БНХАУ-д үйлдвэрлэгдсэн цагт 27 тонн уур боловсруулах хүчин чадал бүхий ул ширэмт зуух 2, БНХАУ-д үйлдвэрлэсэн эргэлттэй буцламтгай давхаргын шаталттай 25 тн/ц уур үйлдвэрлэх хүчин чадал бүхий 1 зуух, Япон улсад үйлдвэрлэгдсэн 3 мВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадал бүхий 1 турбингенератор, БНХАУ-д үйлдвэрлэгдсэн тус бүр нь 3 мВт хүчин чадал бүхий 2 турбин генератор, 7 Гкал хүчин чадалтай сүлжээний ус халаагч, дулааны шугам сүлжээ, хими ус бэлтгэлийн тоноглол болон туслах тоноглолуудын хамт ажиллаж байна.

Хүснэгт №4.9. Дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадал

№	Эх үүсвэр	Хүчин чадал /цахилгаан, мВт/		Хүчин чадал /Дулаан, Гкал /цаг/	
		Төслийн	одоо байгаа	Төслөөр	одоо байгаа
1	Даланзадгад дулааны цахилгаан станц	9	5.4	7	2

Эх үүсвэр “УГЗБЕТ-нөөс”

2014 оны 01-дүгээр сар хүртэлх хугацаанд 582 аж ахуйн нэгж байгууллага, 5924 айл өрхийг цахилгааны эрчим хүчээр, 154 ААНБ, 903 айл өрхийг 14,0 км хос шугам, 11ш дулаан түгээх төвөөр дамжуулан дулааны эрчим хүчээр тус тус ханган ажиллаж жилд дунджаар 15-16 сая кВт ЦЭХ, 17-18 мян Гкал дулааны эрчим хүчийг хэрэглэгчдэд түгээж 1.4-1.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна. Өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэглээний чадлын дутагдлыг нөхөн хангахын тулд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 3 мВт-ын ДЦС-ыг барьж улсын комисс ажиллуулж ашиглалтанд хүлээж авч 2011 оны 12-р сарын 09-ний өдрөөс эхлэн цахилгаан сүлжээнд залган орон нутагтай ашиглагчийн гэрээ байгуулан ажиллууж байна. Даланзадгадын дулааны цахилгаан станц жилдээ 16 сая кВт.цаг цахилгаан үйлдвэрлэж, 11.7 сая кВт.цаг цахилгаан, 19.2 мян.Гкал дулааныг хэрэглэгчдэд түгээж байна. Өвлийн оргил ачаалал 3.6 МВт. Суурилагдсан чадал нь 5.4 МВт боловч хэрэглээний өсөлт, станцын ашиглалтын байдал,

ажиллагааны хүндрэлээс болж нэг зуух, нэг турбин ажиллуулан их ачаалал, аваарийн үед дизель станц ажиллуулах шаардлага гардаг.

ДЗДЦС” ТӨХК нь Өмнөговь аймагт цахилгаан болон дулааны эрчим хүчийг үйлдвэрлэх, түгээх, хангах ажиллагааг биеэ даасан нэг систем болон ажилладагаараа бусад станцуудаас онцлогтой юм.

4.2. Зам, тээврийн сүлжээг хөгжүүлэх төлөвлөлт

Авто зам

Өмнөговь аймгийн авто замын хэтийн хэрэгцээг төлөвлөхдөө “Монгол улсын мянганы хөгжлийн зорилтот суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод Мянганы замын хэвтээ, босоо тэнхлэгүүдийг барьж дуусгах, бүсийн болон аймгийн төвүүдийг нийсэлтэй хатуу хучилттай замаар, дараагийн шатанд өөр хооронд нь холбох” гэсний дагуу хэтийн төлөвлөлтийг хийлээ.

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр авто замын сүлжээ ихтэй боловч Мандалговь-Даланзадгад гэсэн нийслэлтэй холбосон улсын чанартай зам, Тавантолгой /Ухаахудаг/-Гашуунсухайт, Оюутолгой-Гашуунсухайт, Нарийнсухайт-Шивээхүрэн уул уурхайн тээврийн хатуу хучилттай авто замын маршрутгаас бусад нь ердийн хөрсөн замтай. Тус аймгийн нутаг дэвсгэрийн нилээд хувь нь авто замын тоос шороонд дарагдан, хөрс их хэмжээгээр эвдэрч, ургамлын бүрхэвч өөрчлөгдөж, байгаль-экологи их хэмжээгээр сүйтгэгдэх болжээ. Энэ ноцтой байдалд дүгнэлт хийж, аймгийн нутаг дэвсгэрийг авто замын чанартай сүлжээтэй болгохоор төлөвлөлөө.

Төлөвлөлтөнд ландшафтын төрх байдал, геоморфологийн нөхцөл, геологийн тогтоц, инженер геологийн нөхцөл, ургамал, ан амьтдын тархалт, байршилт, авто замын эдийн засгийн үр ашиг зэрэг олон үзүүлэлтүүдийг хамааруулан авч үзлээ. Авто замын эдийн засгийн үр ашгаас гадна байгаль экологийг хамгаалах асуудал дээгүүр түвшинд тавигдаж байгааг чухалчлан, цаг хугацааны хэмнэлт, техникийн ашиглалтын хугацаа урт удаан эдэлгээний үр ашиг илүү байх талыг нь онцлон авч үзэв.

Төлөвлөж байгаа авто замуудыг 2015-2030 он хүртэл барьж ашиглалтанд оруулахаар төлөвлөлтөнд тусгалаа. Авто замд оруулсан хөрөнгө оруулалт экосистемийг сүйтгэсэн хохирлыг бууруулах зардалтай харьцуулахад 30 дахин бага юм.

Өмнөговь аймгийн авто замын сүлжээ нь одоогийн байдлаар нэн хангамжгүй доогуур түвшинд байгаа юм. Тус аймгийн нийт нутгийн нилээд хувь нь авто машины тоос шороонд дарагдаж ургамлан бүрхэвч өөрчлөгдөж, цөлжих болжээ.

Шинээр сайжруулсан болон хатуу хучилттай авто замуудыг төлөвлөснөөр, зарим сумууд нь аймгийнхаа төвтэй хатуу хучилттай болно. Мөн Бүгд Найрамдах Хятад ард улсын хилийн хэд хэдэн боомтуудтай хатуу хучилттай замтай болж, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, цаг хугацааг хэмнэх, аюулгүй зорчих зэрэг олон өргөн боломжууд нээгдэх юм.

Өмнөговь аймаг нь авто зам тавихад хангай аймгуудтай харьцуулахад харьцангуй уул даваа, гол мөрөн зэрэг бартаа саад багатай боловч говийн эмзэг хөрс, ургамал, зэрлэг ан амьтан ихтэй тул түүний зураг төслийг боловсруулахаас эхлэн, барьж байгуулахдаа энэ

бүгдийг тооцож хамгаалах ажлыг хийх нь зүйтэй юм. Ялангуяа, зээр, хулан зэрэг зэрлэг амьтадын чөлөөт нүүдлийг бүх бололцоо нөхцлөөр хангах, төмөр зам болон авто замыг байгалийн жамаараа хөндлөн гарах гарцыг бүрдүүлэх, төлөвлөх асуудал онцгой чухал юм. Мөн тавих замыг элсний нүүдэл, цасанд боогдохоос сэргийлсэн далан хашлага хийж өгөх шаардлагатай.

Тус аймгийн дэд бүтцийн хөгжил нь байгаль орчин, ан амьтан, уламжлалт мал аж ахуй, ургамалшилд сөрөг нөлөө үзүүлэх нь гарцаагүй билээ. Хөгжлийг байгаль орчноо хамгаалах асуудалтай тэнцвэртэй хослуулах үүднээс 2015-2020, 2021-2025, 2026-30 он гэсэн гурван үе шаттайгаар бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлэхээр төлөвлөлөө. Уул уурхай болон дэд бүтцийн хөгжлөөс биологийн олон янз байдал, экосистемд үзүүлэх нөлөөллийг бууруулах шинжлэх ухааны үндэслэл бүхий “Байгаль орчинд нөлөө багатай төлөвлөх арга”-ыг хэрэгжүүлэхийг зорилоо.

Авто зам болон төмөр замыг төлөвлөхдөө экологийн хувьд анхаарах чухал газруудыг ландшафтаар нь ангилж, ерөнхий төлөвлөгөөнд хадгалан хамгаалах зориулалтын газруудыг сонгож, байгаль-экологийн болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, авто болон төмөр замын төлөвлөлтөнд орсноос өөр газруудыг дүйцүүлэн хамгаалж нөхөн сэргээх аргыг дэд бүтцийн нөөц, нөхцлийн төлөвлөлтөнд хэрэглэсэн болно.

Хүснэгт №4.10. Хатуу хучилттай авто замын 2015-2030 хэтийн төлөвлөлт

№	Одоогийн байгаа зам	Хэрэгцээ	Төлөвлөлт		
			2015- 2020	2021-2025	2026-2030
1	Оюунтолгой-Ханбогд-Ханги чиглэл**	Өмнөговь аймгийн уул уурхайн түүхий эдийг хилийн боомт хүргэх			
2	Цогт-Овоо-Даланзадгадын хатуу хучилттай замаас-Цогтцэций сумын төв	Цогтцэций сум болон Тавантолгой, Оюутолгойтой хатуу хучилттай замаар аймгийн төвтэй холбогдоно.			
3	Оюутолгой-Ханбогд	Оюутолгой, Ханбогд сум хооронд зорчиход хялбар болно.			
4	Оюутолгойг-Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн хатуу хучилттай замтай холбох	Тус хоёр уурхай нэг замаа засварлахад нөгөө замаа ашиглах нөхцөл бүрдэнэ.			
5	Тавантолгой-Гашуунсухайтын чиглэлийн замаас Үнэгтийн уурхай чиглэлд хатуу хучилттай зам тавих	Хүннү ресурс компани Үнэгтийн уурхайгаас Гашуунсухайтын боомт руу хатуу хучилттай замаар тээвэр хийх нөхцөл бүрдэнэ.			
	Үнэгт чиглэлийн замаас салаалан Баян –Овоо сумын	Хүннү ресурс компани Баян-Овоо сум хооронд болон тус сум аймгийн			


6	төвийг хатуу хучилттай замаар холбох	төвтэйгөө хатуу хучилттай замаар холбогдоно..			
7	Даланзадгад-Гурвантэс	Энэ зам нь баруун талын Баяндалай, Ноён зэрэг сумдыг дайран өнгөрөх ба улсын босоо тэнхлэгийн замтай аймгийн төвийг холбоно.			
8	Гурвантэс-Баянлиг*	Мянганы замын босоо тэнхлэг			

*Монгол улсын УИХ-ын 2001 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан Мянганы замын болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэлийн зам.

**Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан концессийн гэрээгээр хэрэгжүүлэх төсөл.

Хүснэгт№4.11. 2015-2030 оны хооронд засахаар төлөвлөж байгаа орон нутгийн зам ба гүүрүүд

№	Одоогийн байгаа зам	Хэрэгцээ	Төлөвлөлт		
			2015- 2020	2021-2025	2026-2030
1	Номгон-Үнэгтийн уурхай хоорондын замыг засах	Ердийн хөрсөн замыг сайжруулах			
2	Номгон-Орвог гашууны бор толгой (Улсын хил)	Аялал жуулчлалд зориулан 145 км замыг сайжруулна.			
3	Манлай-Тавантолгой	Оюутолгой болон хилийн боомт ороход хялбар болно.			
4	Булган суманд зам засах	42 км замыг сайжруулах			
5	Мандал-Овоо суманд зам засах	39 км, 56 км			
6	Даланзадгад-Ханхонгорын замыг засах	25 км			
7	Гялааны давааг засах	Аялал уулчлалд зориулан засварлах			
8	Өөдийн давааг засах	Аялал жуулчлалд зориулан засварлах			
9	Хонгорын элсийг гатлах замыг засах	Аялал жуулчлалд зориулан засварлах			
10	Ноён-Сэврэй хоорондын замыг засах	Аялал жуулчлалд зориулан засварлах			



Зураг №4.1. Авто замын газрын төлөвлөлтийн зураг

Хүснэгт №4.12. 2015-2030 онд шинээр баригдах хатуу хучилттай авто замууд шаардагдах хөрөнгө оруулалт

№	Замын нэр	Хучилтын төрөл	Нийт зай, км	Хөрөнгө оруулалт тэрб.төг
2015-2020 он				
1	Оюунтолгой-Ханбогд-Ханги чиглэл**	Хатуу хучилттай	435.0	260.0
2	Цогт-Овоо-Даланзадгадын хатуу хучилттай замаас—Цогтцэций сумын төв	Хатуу хучилттай	57.0	27.0
			492.0	287.0
Аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтаар				
3	Оюунтолгой-Ханбогд	Хатуу хучилттай	35.0	18.0
4	Оюунтолгой-Тавантолгой-			

	Гашуунсухайт чиглэлийн хатуу хучилттай замтай холбох	Хатуу хучилттай	14.0	9.0
5	Тавантолгой-Гашуунсухайтын чиглэлийн замаас Үнэгтийн уурхай чиглэлд хатуу хучилттай зам тавих	Хатуу хучилттай	36.0	20.0
6	Үнэгт чиглэлд замаас салаалан Баян –Овоо сумын төвийг хатуу хучилттай замаар холбох	Хатуу хучилттай	30.0	16.0
			115.0	63.0
	2021-2025 он			
7	Даланзадгад-Гурвантэс	Хатуу хучилттай	308.0	180.0
	2026-2030 он			
8	Гурвантэс-Баянлиг* /Босоо тэнхлэгийн зам/	Хатуу хучилттай	209.0	130.0
	Бүгд			660,0

Хүснэгт №4.13. Замын зурвас газрын тооцоо

№	Замын нэр	Замын урт /км/	Замын зурвас газрын талбай /га/
1	Оюунтолгой-Ханбогд-Ханги чиглэл**	435.0	870.0
2	Цогт-Овоо-Даланзадгадын хатуу хучилттай замаас— Цогтцэций сумын төв	57.0	114.0
3	Оюунтолгой-Ханбогд	35.0	70.0
4	Оюунтолгой-Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн хатуу хучилттай замтай холбох	14.0	28.0
5	Тавантолгой-Гашуунсухайтын чиглэлийн замаас Үнэгтийн уурхай чиглэлд хатуу хучилттай зам тавих	36.0	72.0
6	Үнэгт чиглэлд замаас салаалан Баян –Овоо сумын төвийг хатуу хучилттай замаар холбох	30.0	60.0
		607.0	1214.0
7	Даланзадгад-Гурвантэс	308.0	616.0
8	Гурвантэс-Баянлиг* /Босоо тэнхлэгийн зам/	209.0	418.0
		517,0	1034,0

*Монгол улсын УИХ-ын 2001 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан Мянганы замын болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэлийн зам.

**Засгийн газрын 2013 оны 317 тогтоол “Төрийн өмчийн концессийн жагсаалт батлах тухай”

Хатуу хучилттай замын зурвас газрыг тооцоходоо замын өргөнийг үер усны хамгаалалтын далангийн хамт 20 м тооцож хийлээ.

Хүснэгт №4.14. Орон нутгийн чанартай авто замын сүлжээний хэтийн төлөв

/ хатуу хучилттай замаас сумдын төвийн холбогдох зай /

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ /км/	Хэрэгжүүлэх шалтгаан	Хөрөнгийн хэмжээ, /сая төг/, эх үүсвэр
1	Номгон-Үнэгтийн уурхай хоорондын замыг засах	62.0	Засаж, сайжруулах	50.0
2	Номгон-Орвог гашууны бор толгой	145.0	Аялал жуулчлалд зориулан 145 км замыг сайжруулна.	120.0
3	Манлай-Тавантолгой		Оюунтолгой болон хилийн боомт	

		115.0	ороход хялбар болно.	100.0
4	Булган суманд зам засах	42.0	42 км замыг сайжруулах	35.0
5	Мандал-Овоо суманд зам засах	95.0	39 км, 56 км	80.0
6	Даланзадгад-Ханхонгорын замыг засах	25.0	Аймгийн төв орох замыг сайжруулах	25.0
7	Гялааны давааг засах	1.0	Аялал уулчлалд зориулан засварлах	20.0
8	Өөдийн давааг засах	1.0	Аялал жуулчлалд зориулан засварлах	20.0
9	Хонгорын элсийг гатлах замыг засах	5.0	Аялал жуулчлалд зориулан засварлах	50.0
10	Ноён-Сэврэй хоорондын замыг засах	59.0	Аялал жуулчлалд зориулан засварлах	50.0
		550.0		550.0
			2015-2020	140
			2021-2025	195
			2026-2030	215

Агаарын тээврийн барилга байгууламж

Аймгийн нисэх буудлыг өргөтгөж, олон улсын зорчигч болон ачаа тээврийн онгоц хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх юм.

Даланзадгадын Говь-Гурвансайхан буудлыг 2016-2020 онд олон улсын нислэг хүлээн авдаг болгоно. Үүнд : өргөтгөлийн ажилд 5.0 Тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөв.

Төмөр замын газар

Төмөр замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлогод “Төмөр замын дэд бүтцийг шинээр барих чиглэлийг тогтоохдоо стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд, боловсруулах үйлдвэрүүдийн тээвэрлэлтийн эрэлт, хэрэгцээг хангах, бүтээгдэхүүнийг эрэлт ихтэй зах зээлд хүргэх, нэг зах зээлээс хамааралгүй байх байдлыг хангахыг зорино” гэж заажээ.


Өмнөд говийн ашигт малтмалын орд газруудыг ашиглахтай холбогдуулан хийсэн тооцоо судалгаагаар бүс нутгийн ашигт малтмалын олборлолтын хэмжээ 2015 онд 17.5 сая тн-нд хүрэх хандлагатай байна. Олборлож, боловсруулсан ашигт малтмал, аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх найдвартай тээврийн дэд бүтэц шаардлагатай байна.

Тавантолгойн нүүрсийг БНХАУ болон гуравдагч зах зээлд нийлүүлэх шаардлагын дагуу Ухаа худаг-Гашуун сухайтын төмөр зам баригдаж байна. Энэ зам 2016 оноос ашиглалтанд орж тээвэр хийж эхлэхээр төлөвлөгдөж байна.

Хүснэгт №4.15. Төмөр замын суурь бүтцийг барих төлөвлөгөө

№	Төмөр замын чиглэл	Хүчин чадал урт (км),	царигийн өргөн (мм)	Хэрэгжүүлэх хугацаа	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1	Ухаа худаг-Оюутолгой-Гашуун сухайт	270 км	1435 мм	2013-2015	Улсын хөрөнгө оруулалт
2	Нарийн сухайт-				Хувийн хөрөнгө

	Шивээхүрэнгийн боомт	47.5 км	1435 мм	2015-2020	оруулалт (Монголын алт ХХК буюу МАК)
3	Таван толгой Цагаан суварга Зүүн баян Сайншанд	400 км	1520 мм	2021-2025	Гадаадын хөрөнгө оруулалт, урт хугацааны зээл
4	Тавантолгой-Нарийн сухайт	500 км	1520.0 мм	2026-2030	Гадаадын хөрөнгө оруулалт, зээл



Зураг №4.2. Төмөр замын төлөвлөлтийн зураг



Зураг №4.3. Төлөвлөгдсөн төмөр замын нэгдсэн сүлжээнд холбогдох байдал

Ухаахудаг-Гашуун сухайт чиглэлийн төмөр зам нь 2 өртөө, 5 зөрлөг, 16 гүүр, 132 мал амьтны гарц, хоолойтой байхаар төлөвлөгдсөн байгаа юм.

Хүснэгт №4.16. Баригдах төмөр замын зурвас газрын тооцоо

Чиглэл	Нийт урт	Үүнээс өртөөний урт /км/	Замын зурвас газар, га	Өртөөний тоо	Өртөөний газар, га	Нийт газар, га
Тавантолгой-Гашуунсухайт	267	4.0	3156.0	2	120	3276.0
Нарийн сухайт-Шивээхүрэнгийн боомт	47.5	4.0	522.0	2	120	642.0
Тавантолгой-Цагаан суврага	250.0	12.0	2856.0	6	360.0	3196.0
Тавантолгой-Нарийн сухайт	500.0	22.0	5736.0	11	660.0	6396.0

Тайлбар : Өртөөний газрыг 2 км урт, 300 м өргөнөөр, төмөр замын зурвас газрын өргөнийг 120 м төлөвлөв.

Бусад замуудын ТЭЗҮ болон зураг төслийн ажлууд хийгдээгүй байгаа учраас газар ашиглалтын тооцоог ерөнхий гаргав.

Засгийн газрын хөтөлбөрт тусгаснаас үзэхэд Таван толгойгоос Оюу толгой, Гашуун сухайтын чиглэлийн 260 км, Овоот толгойгоос Шивээ хүрэнгийн 45 км урт төмөр замыг эхний ээлжинд барихаар төлөвлөж байна. Мөн эндээс Сайншандыг дамжин Чойбалсантай холбох, улмаар ОХУ-руу төмөр зам татах хувилбарын төслүүдийг боловсруулсан байна.

4.3. Шугам сүлжээний газрын төлөвлөлт

Холбоо мэдээллийн сүлжээний төлөвлөлт

Тус аймгийн төвийг сумуудтай холбогдсон нийт шилэн кабелийн урт 862 км бөгөөд Ноён, Сэврэй, Гурвантэс, Цогт-Овоо, Ханхонгор, Цогтцэций сумуудын төвүүд шилэн кабельд холбогдоогүй байна.

Цаашид эдгээр сумуудын төвийг аймгийн төвтэй шилэн кабелиар холбоно. Үүнд 1000 орчим км шилэн кабель орно.

Хэрвээ шилэн кабелиар холбох боломжгүй сум үлдвэл 2016 оноос өөрийн улсын хиймэл дагуултай болсноор түүнд холбогдоно.

Даланзадгадын радио өргөн нэвтрүүлгийн станцыг тоон системд шилжүүлэхээс гадна телевизийн нэвтрүүлгийг шууд тоон системээр хүлээн авдаг болно.

Цаашид өмнөд говийн уул уурхайн олборлох, баяжуулах үйлдвэр, боловсруулах аж үйлдвэрийг мэдээлэл, холбооны, өргөн зурвасын өндөр хурдны сүлжээ шаардлагтай болох тул тэдгээрийг холбох ажлыг хийж гүйцэтгэнэ.

Цахилгаан эрчим хүчний сүлжээний төлөвлөлт

Тус аймагт шинээр барих эрчим хүчний эх үүсвэрийг Монгол орны цахилгааны хэрэглээний өсөлт, хэтийн төлөв, уул уурхайн салбарын хэтийн төлөв, цаашдын хөгжил, сэргээгдэх эрчим хүчний хөгжлийн талаар баримтлах хэтийн чиглэл, бодлого хэрэгжүүлэх арга замтай уялдуулан шийдэх нь оновчтой гэж үзэж байна. Үүнд:

- Шинэ эх үүсвэр нь ойрын жилүүдэд зайлшгүй шаардагдаж байгаа цахилгааны хэрэглээг хэрхэн оновчтой хангах вэ гэдгийг тооцох
- Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний тогтвортой, найдвартай ажиллагаа, бие даасан байдлыг хангахад чухал нөлөөтэй байх, баруун зүүн бүсийн системтэй зэрэгцээ ажиллагааг хангахад горимын хувьд хамгийн оновчтой байх
- Сэргээгдэх эрчим хүчний томоохон эх үүсвэр барьж нэгдсэн сүлжээнд холбох зэрэг зарчмын асуудлуудыг хамгийн зөв шийдэх үүднээс хандах шаардлагатай юм.

Сүүлийн жилүүдэд эрчим хүчний системийн найдваржилтыг хангах зорилгын үүднээс тоног төхөөрөмж, технологийн шинэчлэлийг хэрэгжүүлсэн ба бүс нутгийн эрчим хүчний системүүдийг бий болгож, тэдгээрийг эх үүсвэрээр хангах болон зарим бэлтгэл ажил хийгдэж буй үе шат билээ.

Өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах Таван толгойн ДЦС эрчим хүчний системийн томоохон эх үүсвэрүүд, дамжуулах өндөр хүчин чадалтай гол шугамууд баригдаж Эрчим хүчний нэгдсэн систем бүрэлдэн бий болох хөгжлийн шинэ үе шат гэж тооцож байгаа болно.

Оюутолгойн уурхайг цахилгаанаар хангахын тулд Улаанбаатар-Мандалговь-Оюутолгой гэсэн чиглэлд 220 кВ-ын хүчдэлтэй өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамыг 2013 онд барьж дууссан. Энэ шугам нь тус уурхайн эхний 3-5 жилийн цахилгааны хэрэгцээг бүрэн хангаж чадах бөгөөд нэгдсэн систем талаас цахилгаанаар

хангах нэг эх үүсвэр нөгөө талаас шинээр барих эх үүсвэрийг одоогийн системтэй зэрэгцээ ажиллуулах холбоос шугам болж өгнө.

Мөн Ухаахудагийн нүүрсний ордыг түшиглэн 12 мвт-ын жижиг цахилгаан станц баригдсан нь уг станцыг Оюутолгойтой холбовол уурхайг хоёр талын тэжээлтэй найдвартай цахилгаанаар урт хугацааны турш хангах асуудлыг иж бүрэн шийдэх юм. Мөн Таван толгойн станцыг барихад эхний ээлжинд шаардагдах чадлыг төвийн бүсийн шугамаар хангах бололцоотой болох юм.

Аймгийн хэмжээнд Сэврэй суманд салхин цахилгаан станц, Ноён суманд нарны цахилгаан станц, Манлай суманд нар салхи хосолсон цахилгаан станц байна. Гэвч одоогоор ашиглалтгүй байна. Ашиглах боломж эзэнгүй байгаа.

Хүснэгт №4.17. Сумдын төвийг цахилгаанаар хангах зорилгоор байгуулсан нар, салхи, усан цахилгаан станцын ашиглалтын одоогийн байдал

Аймгийн нэр	Эрчим хүчний эх үүсвэрийн чадал	Ашиглалтанд орсон огноо	Тайлбар	
Салхин цахилгаан станц				
1	Өмнөговь Сэврэй	80 кВт	11/26/2008	Инвертор нь удаа дараа гэмтэж байсан.
Наран цахилгаан станц				
2	Өмнөговь Ноён	200 кВт	9/10/2003	Аккумулятор муудсан байгаа
Наран цахилгаан станц + Салхин цахилгаан станц				
3	Өмнөговь Манлай	PV(30)/WP (120) 150 кВт	Улсын комисс ажиллаагүй	Инвертор болон контроллер нь ажиллагаагүй болсон.

Цаашид Цогтцэций суман дээр “Цэций” салхин цахилгаан станцыг байгуулахаар төлөвлөж байна. “Цэций” салхин цахилгаан станц ашиглалтанд орсноор улсын нэгдсэн сүлжээнд жил бүр 124.7 сая кВт цаг цахилгаан эрчим хүч нийлүүлж, дулааны цахилгаан станцаас цахилгааны үйлдвэрлэлтэй харьцуулахад 230 мянган тонн хүлэмжийн хий ялгаруулалтыг бууруулах тооцоо гарсан байна. Ингэснээр 180 мянган тонн нүүрс, 1.2 сая тонн ус хэмнэх аж. “Өмнөговь аймгийн хөгжлийн хөтөлбөр 2010-2020 он”-д тусгагдсан эрчим хүчний бодлогод дараах арга хэмжээнүүд орсон байна.

Зорилт1:

- Таван толгойн 400 МкВт-ын цахилгаан станц баригдаж, эрчим хүчний нэгдсэн системтэй холбогдох хүртэлх хугацаанд айл өрхүүд, албан байгууллагуудын цахилгааны зохистой хэрэглээг тоолууржуулалтаар зохицуулж, суурингуудад үйлдвэрлэлийн зориулалттай шугамын зураг төслийг боловсруулан бэлтгэлийг хангах
- Дулааны болон цахилгаан эрчим хүчний хэрэглээний үнийг үе шаттайгаар бууруулах төсөл тооцооллыг гаргаж бүс нутгийг үйлдвэрлэл үйлчилгээ, амьдрах орчны ая тухтай нөхцөлийг бүрдүүлэхэд бодлогын хувьд анхаарах, бичил бүсүүдийн шинэ сууршилийн бүсүүдэд дулааны эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэ технологийг нэвтрүүлэх асуудлыг судалж төсөл боловсруулан хэрэгжүүлэх;
- Хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоолсны үндсэн дээр эрчим хүчний салбарын шинэчлэл, хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлж сумдын халаалтын тогоонуудад шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, техникийн шинэчлэл хийх;
- Аймгийн хэмжээнд цахилгаан эрчим хүчний нэгдсэн системд болон аймгийн

төвөөс цахилгааны шугамаар холбогдсон сумдыг цагийн ялгаварт тоолуурт оруулж, цахилгаан эрчим хүчний өртөгийг бууруулах замаар хэрэглээг нэмэгдүүлэх;

➤ Цахилгааны эх үүсвэрийг шинээр байгуулан, байнгын цахилгааны эх үүсвэргүй 3 сумыг холбох замаар аймгийн хэмжээнд эрчим хүчний нэгдсэн системд холбогдох;

Зорилт2:

- Сумдын түвшинд бага оврын халаалтын зуухтай хэрэглэгчдийг дулаан хангамжийн төвлөрсөн системд холбож, хэрэглээг нэмэгдүүлэх;
- Хөдөөгийн малчин айл өрхийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр бүрэн хангах;
- Нүүрснээс утаагүй түлш үйлдвэрлэх бага оврын үйлдвэрүүд байгуулж ажиллуулах;
- Сумдын эрчим хүчний байгууллагын үйл ажиллагааг өргөтгөх, мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, сургаж дадлагажуулах.

Дээрх хөтөлбөрүүдээс Улаанбаатар-Мандалговь-Тавантолгой-Оюутолгойн 220 квт-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станц баригдаж дууссан. Мөн Ухаа худагийн нүүрсний ордыг түшиглэн 12 мвт-ын жижиг цахилгаан станц баригдсан. Харин хээрийн судалгааны үе шатанд сумдаас өгсөн саналуудыг 4.22, 4.23, 4.24-р хүснэгтүүдэд тусгав.


Хүснэгт №4.18. Дэд станц байгуулах

№	Сумдын нэр	Байршил	Зориулалт	Он	Төлөвлөсөн арга хэмжээ
1	Даланзадгад	Даланзадгад хотын төвд	Нэмж дулааны цахилгаан станц барих шаардлагатай байна.	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх

Хүснэгт №4.19. Эрчим хүч дамжуулах шугам татах

№	Сумдын нэр	Байршил	Зориулалт	Он	Төлөвлөсөн арга хэмжээ
1	Манлай	Сумын төвөөс баруун урагш	Газар өмчлөх бүрэн боломжтой.	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
		Далай багийн төвд	Газар тариалан хөгжих бүрэн боломжтой.	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
		Жаргалант багийн төвд	Газар тариалан, ЭМАА хөгжих бүрэн боломжтой.	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
2	Баяновоо	Налих багийн төв	Газар тариалан эрхлэх бүрэн боломжтой	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
		Хар заг баг руу	ЭМАА хөгжүүлэх бүрэн боломжтой	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
3	Номгон	Эмгэн булаг	ЭМАА, газар тариалан хөгжүүлэх	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
		Хармагтай баг руу	ЭМАА, газар тариалан хөгжүүлэх	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
4	Цогтовоо	Сумаас 32 км Замын шанд баг руу	Ахуйн хэрэглээ	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
		Сумаас 23 км Бор тээг баг руу	Ахуйн хэрэглээ	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
		Сумаас 46 км Найз баг руу	Ахуйн хэрэглээ	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх

5	Ханхонгор	Жаргалант багийн төв рүү	Ахуйн хэрэглээ	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
		Аймгаас хот явах зам дагуу	Суурьшлийн бүс худалдаа үйлчилгээ төлөвлөсөн	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
6	Ноён	Сумын төв рүү Тера-Энержи ХХК-аас	Ахуйн хэрэглээ	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх
		Зам дагасан суурьшлийн бүс рүү	Суурьшлийн бүс худалдаа үйлчилгээ төлөвлөсөн	2015-2021	Нарийвчилсан судалгаа хийх



Зураг №4.4. Эрчим хүчний шугам сүлжээ, эрчим хүч үйлдвэрлэлийн байгууламжын төлөвлөлтийн зураг

Дулааны шугам сүлжээ, үйлдвэрлэлийн байгууламж

Өмнөговь аймаг төвийн нэгдсэн системд холбогдсон тул цахилгаан хангамжийн хувьд бүрэн шийдэгдсэн. Тиймээс тус станцын цахилгааны ачаалал хөнгөрсөн боловч,

дулааны ачаалал 2016 он гэхэд одоогийн ачаалалаас 4-5 дахин нэмэгдэх ба, аймгийн нийт цахилгаан хэрэглээний 42%, дулааны эрчим хүчний 100%ийг хангаж ажиллах төлөв үүсч байна. Дулааны ачаалал нэмэгдэхийн хирээр хөгжилтэйгээ уялдаж эрчим хүч нь дараах ажлыг хийх зайлшгүй шаардлага үүссэн. Үүнд:

1-р: Өмнөговь аймаг шинэ Даланзадгад хот барьж байгаа бөгөөд түүнд хэрэглэгдэх дулааны нийт чадал 28 Гкал\цаг, энэ чадлыг 2014- 2015 оны өвлөөс эхлэн авч хэрэглэх ба одоо 5,9 Гкал\цаг хүчин чадалтай нэг ЦТП ашиглалтанд орсон, энэ намар 7,06Гкал, 5,15 Гкал-ийн хүчин чадалтай хоёр ЦТП ашиглалтанд орохоор баригдаж байна. Үүнээс тооцож үзэхэд хуучин хэрэглээн дээр нэмэгдээд 2014-2015 оны өвлийн их ачаалалын үед 24,1 Гкал ийн хэрэглээ тооцоогоор үүсч байгаа бөгөөд бидний суурьлагдсан чадал 19Гкал, тиймээс 12 ГкалХ2ш хүчин чадалтай уур усны бойлер суурьлуулах шаардлагатай.

2-р: Өмнөговь аймаг 3,2 км урт DU 377 ийн хос шугамыг орон нутгийн хөрөнгө оруулалтаар барьсан, энэ шугамаар шинэ хотын 4ш ЦТП –ний 1-р контур тэжээгдэнэ. Одоо ашиглаж байгаа сүлжээний насосны хүчин чадал 180м3Х2ш, харин шинэ хотын 1-р контурыг тэжээхэд 400м3Х2ш хүчин чадалтай сүлжээний насосыг суурьлуулах шаардлагатай.

3-р: Тус станцын улсын төсвөөр баригдсан 2ш ул ширэмт, 27тн\цаг хүчин чадалтай зуухны АҮК 50% аас хэтэрдэггүй, ашиглалтын болон засварын зардал өндөр, гар ажиллагаа ихтэй, дундажаар 13тн\цаг чадал авахад хоногт 80-150 тн нүүрс түлдэг, бөгөөд үнсээ гараар татаж тэргээр гадагш нь гарган асгаж, автомашинаар 24 цагийн хугацаанд 3км тээвэрлэж асгадаг.

Энэ байдал нь 14 жилийн өмнө болж байсан, үүргээ гүйцэтгэсэн боловч одоо монгол улсад бараг байхгүй ийм техникийг цаашид ашиглах нь эдийн засгийн болон үр ашгийн хувьд, ХАБЭ, байгаль орчны хувьд, мөн запас сэлбэгийн олдоц, нийлүүлэлтийн хувьд бараг байхгүй зэрэг олон асуудлууд байнга гарч байдаг.

Эхний ээлжинд энэ зуухны аль нэгний галын хотлын шаталтын процессийг өөрчлөн сайжруулаад өөрөөр хэлвэл нам даралтад буцламтгай үет шаталтад процесст шилжүүлээд, дулааны ачаалалд ажиллуулвал, ТЭЗҮ сайжирч, жишмэл түлшний хувийн зарцуулалт багасаж, АҮК 85-90% -д хүрнэ, учир нь орон нутгийн хөрөнгөөр баригдсан ийм шаталтад процесстой зуухыг бид одоо ашиглаж байгаагийн хувьд хуучин ул ширэмт зуухаа ингэж өөрчлөн сайжруулвал цаашид дахин 10 аас доошгүй жил найдвартай ажиллах үндэслэлтэй гэж үзэж байна.

ТАВДУГААР БҮЛЭГ. ОЙН САН БҮХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ

5.1. Ойн сан бүхий газрын өнөөгийн байдал

5.1.1. Өмнөговь аймгийн ойн сангийн газрын өнөөгийн байдал, өөрчлөлт


Ойн сан бүхий газрын өнөөгийн байдал

Ой зохион байгуулалт, ойн тооллогын дүнгээр Өмнөговь аймгийн ойн сан бүхий газар тус аймгийн нийт нутаг дэвсгэрийн 7.2 хувийг эзэлж, 13 сумын нутаг дэвсгэрт тархасныг тогтоов.

Ойн санг ойн талбай, ойн бус талбай гэсэн үндсэн хоёр хэсэгт ангилна. Ойн талбай нь дотроо ойгоор бүрхэгдсэн, ойгоор бүрхэгдээгүй талбай гэж хоёр хуваагдана. Ойгоор бүрхэгдсэн талбайд тухайн судалгааны үед ойтой байгаа (0.3 ба түүнээс дээш өтгөрөлтэй) болон улсын ойн санд шилжүүлсэн таримал ой, бут сөөгөөр битүү хучигдсан талбай орох ба ойгоор бүрхэгдээгүй ойн талбайд одоогийн байдлаар ой байхгүй боловч цаашдаа ой ургах нөхцөл бололцоотой газрууд (ойжиж байгаа газар, тармаг модод, ойжуулсан талбай), урьд өмнө ойтой байсан талбай (шатсан ой, мод бэлтгэсэн талбай г.м) тус тус хамрагдана. Ойн бус талбайд ойн сан доторх цагаан энгэр, таг царам, хадлан, бэлчээр, гол, жижиг нуур цөөрөм, намаг, элс, мод үржүүлгийн талбай зэрэг газрууд орно.

Өмнөговь аймгийн заган ойн сангийн нийт талбай 1189226 га талбай ба үүний 604750 га байгалийн заган ой, 565731 га тармаг заг, 3857 га талбайг загжих талбай тус тус эзэлж байна.

Ойн сангийн нийт талбайн 51.99 хувийг ойгоор бүрхэгдсэн, 48.01 хувь нь ойгоор бүрхэгдээгүй талбай байна. Ойгоор бүрхэгдсэн талбайн 97.82 хувийг байгалийн ой, 2.18 хувийг бут сөөг, ойгоор бүрхэгдээгүй талбайн 99.08 хувийг тармаг заг, 0,68 хувийг байгалийн аясаар загжиж, 0,10 хувийг заг түүсэн, 0,14 хувийг хатсан заг бүхий талбай тус тус эзэлж байна. Аймгийн Ойн сангийн талбайг бүрдүүвч зураг 5.1-д үзүүлэв. Мөн түүнчлэн Өмнөговь аймгийн Ойн сангийн талбай, нөөц сум тус бүрээр хүснэгт 5.1-д харуулав.



Зураг №5.1. Өмнөговь аймгийн ойн сангийн талбай газрын төрлөөр ангилагдсан байдал

Хүснэгт №5.1. Өмнөговь аймгийн ойн сангийн талбай, нөөц /сум тус бүрээр/

д/д	Сумын нэр	Ойн сангийн талбай, га	Талбайд эзлэх хувь	Ойн сангийн нөөц, м3	Нөөцөд эзлэх хувь
1	Баяндалай	74411	6,26	79624	8,30
2	Баян-овоо	61287	5,15	57971	6,04
3	Булган	18834	1,58	24072	2,51
4	Гурвантэс	569614	47,9	288206	30,03
5	Ханбогд	116593	9,8	109963	11,46
6	Хүрмэн	86744	7,29	188358	19,63
7	Мандал-овоо	48435	4,07	26830	2,8
8	Манлай	10215	0,86	5766	0,60
9	Номгон	41722	3,51	23261	2,42
10	Ноён	59074	4,97	42456	4,42
11	Сэврэй	92252	7,76	110886	11,55
12	Цогт-овоо	10042	0,84	2311	0,24
13	Цогтцэций	3	0,00	-	
Дүн		1189226	100,00	959704	100,00

Өмнөговь аймгийн ойн сан нь “Ойн тухай хууль”-ийн 8.1-д зааснаар бүгд Хамгаалалтын бүсийн ойд хамаарч байна.

Хүснэгт №5.2. Ойн сангийн талбайн газрын төрлийн нэгтгэл /ойн бүсээр/

Ойгоор бүрхэгдсэн		Дүн	Ойгоор бүрхэгдээгүй				Дүн	Ойн талбайн дүн
Байгалийн заг	бут сөөг		Тармаг заг	Хатсан заг	Заг түүсэн	загжиж байгаа		
Дархан цаазат газрын онгон бүс								
1014	350	1364	6332			949	7281	8645
Дархан цаазат газрын хамгаалалтын бүс								
3962	253	4215	4391			1352	5743	9958
Дархан цаазат газрын хязгаарлалтын бүс								
38908		38908	29402			1248	30650	69558
Дархан цаазат газрын орчны бүс								
6422	1183	7605	6017				6017	13622
Дархан цаазат газрын дүн								
50306	1786	52092	46142	0	0	3549	49691	101783
Байгалийн цогцолборт газрын онцгой бүс								
57249		57249	38965				38965	96214
Байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс								
73591	3	73594	105189				105189	178783
Байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын бүс								
74877		74877	107293				107293	182170
Байгалийн цогцолборт газрын орчны бүс								
51596		51596	64318				64318	115914
Байгалийн цогцолборт газрын дүн								
257313	3	257316	315765	0	0	0	315765	573081
Баян бүрдийн болон бусад заган ой								
281788	11697	293485	193922	815	587	308	195632	489117
Улсын хилийн дагуух заган ой								
15343		15343	9902				9902	25245
Аймгийн хэмжээгээр								
604750	13486	618236	565731	815	587	3857	570990	1189226

Улс орон, аймаг, сумын ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбайг нийт нутаг дэвсгэрт нь харьцуулж хувиар илэрхийлсэн үзүүлэлтийг ойрхог чанар гэдэг. Өмнөговь аймгийн ойгоор бүрхэгдсэн талбай /618,2 мян.га/-г аймгийн нийт нутаг дэвсгэр /16500,0 мян.га/-д хувааж гаргахад ойрхог чанар нь 3,75% байна.

Ойн сангийн экологи эдийн засгийн үнэлгээ

Тус аймгийн ойн сан бүгд хамгаалалтын бүсэд хамаарч байгаа тул БОСайдын 1996 оны 230-р тушаалын хавсралтад зааснаар 1-р мужид хамааруулж, БОАЖСайдын 2009 оны 394 дугаар тушаалаар баталсан үнэлгээгээр экологи эдийн засгийн үнэлгээг тогтоов. Ойн талбай, нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг хүснэгт 5-д харуулав.

Хүснэгт №5.3. Ойн талбай, нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээ

Модны төрөл	Ойн талбай					
	Талбай			Нөөц		
	Талбай, га	1 га-н үнэлгээ, мян.төг	Дүн мян.төг	Нөөц, шоо метр	1 га-н үнэлгээ, мян. төг	Дүн мян.төг
Заг	1174054	3210,0	3 768 713 340,0	1099939	90,0	98994510.0
Тоорой	322	1620,0	521 640,0	15484	81,0	1254204.0
Хайлаас	1364	9900,0	13 503 600,0	12845	141,0	1811145.0
Бут сөөг	13486	1620,0	21 847 320,0	6571	81.0	532251.0
Дүн	1189226		3 804 585900.0	1134839.0		102 592110.0


Ойн талбайн экологи эдийн засгийн үнэлгээ 3 их наяд 804 тэрбум 585 сая 900 мянган төгрөг, нөөцийн үнэлгээ 102 тэрбум 592 сая 110 мянган төгрөг болж байна.

5.1.2. Ойн сангийн өөрчлөлт


2011 онд хийгдсэн ой зохион байгуулалтын судалгааны дүнг өмнөх 1990 оны судалгааны дүнтэй харьцуулан ойн сангийн талбайн өөрчлөлтийг газрын төрлийн ангилал тус бүрээр, байгалийн ойнтаксацын дундаж үзүүлэлтийн өөрчлөлтийг модны төрөл тус бүрээр гаргав. Ойн сангийн талбайн өөрчлөлтийг хүснэгт 5.4, график зураг 5.2-д тус тус харуулав.

Хүснэгт №5.4. Өмнөговь аймгийн ойн сангийн газрын өөрчлөлт

Ойн сангийн талбайн төрөл	Газрын төрөл	2011	1991	Зөрүү
Ойгоор бүрхэгдсэн талбай	Байгалийн заг	604,7	921,4	-316,7
	Бут сөөг	13,5		13,5
	Дүн	618,2	921,4	-303,2
Ойгоор бүрхэгдээгүй талбай	Хатсан	0,8		0,8
	Тармаг	565,7	251,5	314,2
	Заг түүсэн	0,6		0,6
	загжиж байгаа	3,9	0,9	3
	Дүн	571	252,4	318,6
НИЙТ		1189,2	1173,8	15,4



Зураг№5.2. Ойн сангийн талбайн өөрчлөлт



Зураг№5.3. Ойн сангийн ангиллын зураг

Талбайн дүнгийн өөрчлөлтөөс харахад ойн сангийн нийт талбай 15,4 мян.га-р нэмэгдсэн боловч ойгоор бүрхэгдсэн талбай 303,2 га-р багасаж, ойгоор бүрхэгдээгүй талбай 318,6 мян.га-р нэмэгдэж гарлаа. Өөрчлөлтийг талбайн төрөл тус бүрээр авч үзвэл байгалийн заган ойн эзлэх талбай 316,7 га-р багассан бол тармаг заг 314,2 га-р, хатсан болон заг түүсэн талбай 1,4 мян. га-р нэмэгдсэн нь загийг их хэмжээгээр түлшинд хэрэглэж байгаа болон сүүлийн жилүүдийн хурайшилттай холбоотойгоор заган ой ихээхэн хэмжээгээр сийрэгжиж байгаатай холбоотой.

5.2. Ойн сан бүхий газрын ашиглалт хамгаалалтын менежмент


5.2.1. Ойрын болон дунд хугацааны төлөвлөлт /2015-2020он/

Ойг хамгаалах арга хэмжээ

Аймгийн ЗДТГазар, Байгаль орчны газар, ойн алба бусад холбогдох байгууллагуудаас заган ойг хамгаалах талаар багагүй арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа боловч заган ойг хулгайгаар бэлтгэх явдал газар авсан хэвээр байна. Мөн түүнчлэн сүүлийн судалгаагаар тус аймагт зайлшгүй ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх шаардлагатай 12500 га талбай байгаа нь тогтоогджээ. Иймээс цаашид заган ойг хамгаалах талаар хэрэгжүүлэх зохион байгуулалтын ажлын зэрэгцээ ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх арга хэмжээг 2015-2020 онд төлөвлөсөн болно. Энэ арга хэмжээг хүснэгт 5.5-д харуулав.

Хүснэгт №5.5. Өмнөговь аймгийн 2015-2020 онд ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх төлөвлөгөө

№	Сумдын нэр	Тэмцэл явуулах шаардлагатай талбай га	Он						Дүн
			2015	2016	2017	2018	2019	2020	
1	Даланзадгад	3.0	3.0						3.0
2	Ноён	1.0		1.0					1.0
3	Цогтцэций	2.0			0.5	0.5	0.5	0.5	2.0
4	Номгон	4.0	3.0	1.0					4.0
5	Сэврэй	2.5		2.5					2.5
Аймгийн дүн		12.5	6.0	4.5	0.5	0.5	0.5	0.5	12.5




Зураг №5.4. Ойн өвчин, хортонтой тэмцэх шаардлагатай газруудын байршлын зураг

Сүүлийн жилүүдэд ойжуулах, ургамалжуулах, хөрсний элэгдэл эвдрэлийг багасгах зорилгоор аймгийн хэмжээнд олон ажлуудыг хийж байна. Гэхдээ эдгээр ажлын ихэнх нь төв суурин газрыг элсний нүүлтээс хамгаалах, цэцэрлэгжүүлэх чиглэлээр хийгдэж байна. Харин заган ой бүхий газруудын ихэнх нь төв суурин газраас алслагдмал байдалтай байдгаас тэнд ойн аж ахуйн арга хэмжээ мэдэгдэхүйц түлхэц далайцтайгаар хийгдэхгүй байна. удалгааны дүнгээр ой нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай 570990 га заг түүсэн, хатаж хуурайшсан болон тармаг заг бүхий талбай байна. Өөрөөр хэлбэл ойн сангийн нийт талбайн 50.5 хувьд нь ямар нэг хэмжээгээр ойжуулалт ой нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна гэсэн үг. Ойжуулах шаардлагатай талбайг аймаг, сумын хэмжээнд хүснэгт 5.6-д үзүүлэв. 2015-2020 онд ойжуулах, байгалийн сэргэн ургалтанд туслах, ойн зурвас байгуулах ажлын хэмжээг хүснэгт 5.7, 5.8, 5.9-д үзүүлэв.

Хүснэгт №5.6. Ойн сангийн ойжуулах шаардлагатай талбай /сум тус бүрээр/

д/д	Сумын нэр	Ойн сангийн талбай, га	Ойгоор бүрхэгдсэн талбай, га	Ойгоор бүрэгдээгүй талбай, га				Дүн
				Тармаг	Хатсан	Заг түүсэн	Загжиж байгаа	
1	Баяндалай	74411	51309	23102	-	-	-	23102
2	Баян-овоо	61287	32404	25334	-	-	3549	28883
3	Булган	18834	16683	2151	-	-	-	2151
4	Гурвантэс	569614	237520	332094	-	-	-	32094
5	Ханбогд	116593	76152	39127	727	587	-	40441
6	Хүрмэн	86744	47301	39135	-	-	308	39443
7	Мандал-овоо	48435	36672	1763	-	-	-	1763
8	Манлай	10215	6321	3806	88	-	-	3894
9	Номгон	41722	27128	14594	-	-	-	14594
10	Ноён	59074	27295	31779	-	-	-	31779
11	Сэврэй	92252	54403	37849	-	-	-	37849
12	Цогт-овоо	10042	5048	4994	-	-	-	4994
13	Цогтцэций	3	-	3	-	-	-	3
	Дүн	1189226	618236	565731	815	587	3857	570990




Зураг №5.5. Ойн нөхөн сэргээлт хийх шаардлагатай газруудын байршил

Хүснэгт №5.7. 2015-2020 онд ойжуулах талбай, га

д/д	Сумдын нэр	Ойг нөхөн сэргээх шаардлагатай талбай, га	5 жилд ойжуулсан талбай га	2015	2016	2017	2018	2019	2020	Дүн
1	Баяндалай	23102								
2	Баян-овоо	28883								
3	Булган	2151	240	100						100
4	Гурвантэс	32094							100	100
5	Ханбогд	40441	11.6		20					20
6	Хүрмэн	39443				40				40
7	Мандал-овоо	1763								
8	Манлай	3894								
9	Номгон	14594								
10	Ноён	31779					60			60
11	Сэврэй	37849						30		30
12	Цогт-овоо	4994								
13	Цогтцэций	3								
14	Ханхонгор		140							
15	Даланзадгад		25							
	Дүн	570990	416.6	100	20	40	60	30	100	350

Хүснэгт №5.9. 2015-2020 онд байгуулах ойн зурвас

д/д	Сумдын нэр	Ойн зурвас, талбай га	2015	2016	2017	2018	2019	2020	Дүн
1	Баяндалай							8	8
2	Баян-овоо					5			5
3	Булган	6			3				3
4	Гурвантэс							10	10
5	Ханбогд							20	20
6	Хүрмэн		3						3
7	Мандал-овоо					5			5
8	Манлай					5			5
9	Номгон						5		5
10	Ноён							3	3
11	Сэврэй				5				5
12	Цогт-овоо		3						3
13	Цогтцэций					4			4
14	Ханхонгор	105.6		10	20		30		60
15	Даланзадгад		2	10	-	-	10	-	22
	Нийт дүн	111.6	8	20	28	19	45	41	161



Зураг №5.7. Ойн нөхөн сэргээлт хийх шаардлагатай газруудын байршил

5.2.2. Хэтийн төсөөлөл

Өмнөговь аймгийн хэмжээнд ойг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний алс хэтийн 2021-2030 оны төсөөллийг гаргахыг оролдов. Хэтийн төсөөллийг аймгийн хэмжээнд баримжаалан хийсэн бөгөөд сумдаар төлөвлөх боломжгүй гэж үзэж байна. Ойг хамгаалах арга хэмжээний хувьд төв, орон нутгийн уламжлалт зохион байгуулалтын болон хяналт шалгалтын ажлыг харуулах боломж хязгаарлагдмал юм. Мөн түүнчлэн ойн хөнөөлт шавьж, өвчний тархалтын судалгааг 2020 онд зохион байгуулж энэ судалгааны үр дүнд тулгуурлан 2021-2030 онд тэмцэх ажлыг төлөвлөх боломж бүрдэнэ. Гэхдээ 2021-2030 онд 35.0 мянган га талбайд ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх ажлыг төлөвлөсөн болно.

Хүснэгт №5.10. Өмнөговь аймгийн 2021-2030 онд ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх талбай, га

д/д	Сумын нэр	2015-2020 оны ойжуулах талбай га	2015-2020 оны дундаж	2021-2025 он	2026-2030 он	Дүн
1	Баяндалай					
2	Баян-овоо					
3	Булган					
4	Гурвантэс					
5	Ханбогд					
6	Хүрмэн					
7	Мандал-овоо					
8	Манлай					
9	Номгон	4.0				
10	Ноён	1.0				
11	Сэврэй	2.5				
12	Цогт-овоо					
13	Цогтцэций	2.0				
14	Ханхонгор					
15	Даланзадгад	3.0				
	Дүн	12.5	2.08	15.0	20.0	35.0

Хүснэгт №5.10. Өмнөговь аймгийн 2021-2030 онд ойжуулах талбай, га

д/д	Сумын нэр	2015-2020 оны ойжуулах талбай га	2015-2020 оны дундаж	2021-2025 он	2026-2030 он	Дүн
1	Баяндалай					
2	Баян-овоо					
3	Булган					
4	Гурвантэс					
5	Ханбогд					
6	Хүрмэн					
7	Мандал-овоо					
8	Манлай					
9	Номгон					
10	Ноён					
11	Сэврэй					
12	Цогт-овоо					
13	Цогтцэций					

14	Ханхонгор					
15	Даланзадгад					
	Дүн	161	150	380	500	880

Хүснэгт №5.12. 2021-2030 онд байгуулах ойн зурвас

д/д	Сумын нэр	2015-2020 оны байгалийн сэргэн ургалтанд туслах талбай га	2015-2020 оны дундаж	2021-2025 он	2026-2030 он	Дүн
1	Баяндалай					
2	Баян-овоо					
3	Булган	30				
4	Гурвантэс	40				
5	Ханбогд	80				
6	Хүрмэн	60				
7	Мандал-овоо	10				
8	Манлай	10				
9	Номгон					
10	Ноён					
11	Сэврэй					
12	Цогт-овоо					
13	Цогтэций					
14	Ханхонгор	120				
15	Даланзадгад					
	Дүн	330	66	370	460	830

Хүснэгт №5.13. 2015-2030 онд явуулах ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд шаардагдах зардлын тооцоо

д/д	Ойн аж ахуйн арга хэмжээ	Нэг бүрийн үнэ Мян.төг	2015-2020 он		2021-2025 он		2026-2030 он		Дүн	
			Хэм-жээ	Зар-дал, сая төг	Хэм-жээ	Зар-дал сая төг	Хэм-жээ	Зар-дал сая төг	Хэм-жээ	Зар-дал сая төг
1	Ойн хөнөөлт өвчинтэй тэмцэх	48.4	12.5	0.605	15.0	0.726	20.0	0.968	47.5	2299.0
2	Ойжуулалт	905.0	350	316.75	380	343.9	500	452.5	1230	1113.15
3	Ойн зурвас	2000.0	161	322.0	370	740.0	460	920.0	991	1982.0
	Дүн	-		639.355		1084.62		1373.47		5394.15

5.2.3. Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөлтийн товчоо, зөвлөмж

Ойг хамгаалах арга хэмжээний төлөвлөлт

Ойн тооллого, ой зохион байгуулалтын ажлыг цаг хугацаанд нь явуулж, түүнд тусгагдсан ой хамгаалах арга хэмжээг хэрэгжүүснээр ойн экологийн ач холбогдол дээшилж, түүний чанар сайжирна. 2015-2030 онд ойг хамгаалах, хяналт шалгалт явуулах уламжлалт зохион байгуулалтын арга хэмжээг авахын зэрэгцээ, ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх ажлыг 2015-2020 онд 12.5мян.га талбайд, 2021-2025 онд 15.0 мян га талбайд, 2026-2030 онд 20.0 мян.га табайд тус тус гүйцэтгэнэ.

Ойг нөхөн сэргээх, ойн зурвас байгуулах ажлын төлөвлөлт

Мод үржүүлгийн газруудыг өргөтгөн бойжуулах тарьц суулгацын хэмжээг нэмэгдүүлэх замаар ойг нөхөн сэргээх ажлын хэмжээг нэмэгдүүлнэ. 2015-2020 онд ойжуулалтын ажлыг 350 га-д, 2021-2025 онд 380 га-д, 2025-2030 онд 500га-д тус тус

хийхээр төлөвлөв. Харин ойн зурвас байгуулах ажлыг 2015-2020 онд 161 га-д, 2021-2025 онд 370 га-д, 2026-2030 онд 460га-д тус тус хийхээр төлөвлөсөн болно.

Шаардагдах зардал

2015-2030 онд явуулах ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд нийт 5394.15сая төгрөг шаардагдах тооцоо гарч байна.

Хүрэх үр дүн шалгуур үзүүлэлт

Газар зохион байгуулалтын тусгагдсан төлөвлөгөөнд тусгагдсан ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлснээр аймгийн хэмжээнд ойн тогтвортой менежмент нэвтэрч, ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд чанарын ахиц гарч, экологийн ач холбогдол бүхий эрүүл ой бий болно. Ойн экосистем, биологийн олон янз байдлын хадгалалт, хамгаалалт сайжирна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ**6.1. Усны сан бүхий газрын өнөөгийн байдал**

Газрын нэгдмэл сангийн тайлангаас үзэхэд усны сан бүхий газар тус аймагт 15.8 мян.га газартай байна.


Хүснэгт.№6.1. Усан сан бүхий газар /2013оны газрын нэгдмэл сангийн ангиллаар/

Сумдын нэр	Бүгд	Гол, мөрний эзлэх газар	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	Горхи, булаг шандын эзлэх газар
Баяндалай	1083.5	42.0	727.0	314.5
Баян-Овоо	113.0	10.0	103.0	
Булган	432.0	5.0	351.0	76.0
Гурвантэс	185.0		33.0	152.0
Даланзадгад	145.0	22.0	71.0	52.0
Мандал-Овоо	7989.0		7818.0	171.0
Манлай	2171.0		2121.0	50.0
Номгон	433.0	23.0	320.0	90.0
Ноён	36.0		32	4
Сэврэй	17.0			17.000
Ханбогд	807.0	41.0	732.0	34.0
Ханхонгор	0.0			
Хүрмэн	890.0	8	750	132
Цогт-Овоо	556		536	20
Цогтцэций	1002.0	98.0	896.0	8.0
Дүн	15859.50	249.00	14490.00	1120.50

Тус аймагт байдаг нуур тойрмуудын хамгийн том нь Мандал-Овоо, Булган сумын хилийн орчимд байдаг Улааннуур юм. Улааннуур нь Э.М.Мурзаев, И.Д.Беспалов нарын тогтоосноор 135-175 км² байсан боловч одоо ширгэж усгүй болсон байна. Энэ нуурыг тэжээдэг цорын ганц эх үүсвэр бол Онгийн гол юм.

Онги гол Хангайн нурууны өвөр Хятрууны уулнаас эх авч Өвөрхангай, Дундговь, Өмнөговь аймгийн 8 сумын нутгийг дамжин 500 орчим км урсан Өмнөговийн Мандал-Овоо, Булган сумын нутаг дахь Улаан нуурт цутгадаг.

Өмнөговь аймгийн хувьд 2004-2013 он хүртэлх хугацаанд усны сан бүхий газрын нийт хэмжээнд өөрчлөлт ороогүй боловч 2013 оны жилийн эцсийн байдлаар гол мөрны эзлэх газрын хэмжээ 58 га-р багасч горхи, булаг шандын эзлэх газар 58 га-р нэмэгдэж, нуур цөөрөм тойрмын талбайд өөрчлөлт ороогүй байна. Гадаргын усны тооллогын материалаас үзэхэд нийт 4940 худаг, булаг 405, услалтын систем 13, Хадат, Нэмэлт, Зөөлөн, Энгэр бүлээн, Талхийн шанд зэрэг рашаанууд тоологдсон байна.



Зураг №6.1. Сумдын усан сан бүхий газрын талбайн хэмжээ, 2005-2013 оны өөрчлөлт /га/

6.2. Усны сан бүхий газрын төлөвлөлт

6.2.1. Ахуйн хэрэглээний болон үйлдвэрлэлийн ус ашиглалт

Говийн бүс нутагт унд ахуйн усны хүртээмжээс гадна чанарын асуудал ихээхэн хурцаар тавигдах бөгөөд усны эх үүсвэрийн судалгаа орд газруудыг хамгаалах нь нэн чухал сэдэв юм. Тус аймагт Монголдоо төдийгүй дэлхийд томоохонд тооцогдох орд газрууд илэрч хүн ам ихээр төвлөрч, үйлдвэрлэлийн зориулалттай усны хэрэгцээ нэмэгдсэн байна.

Хүснэгт №6.2. Өмнөговь аймгийн 100 м³-с дээш ус ашиглагчдын 2013 оны ус ашиглалтын судалгаа

№	Сумын нэр	Аж ахуйн нэгж байгууллага, иргэний нэр	Үйл ажиллагааны чиглэл	Сав газар	Нийт ашиглах усны хэмжээ /м ³ /	Нийт ус ашигласаны төлбөр /төг/
1	Баян - Овоо	“ЭНК” ХХК	Нүүрс баяжуулж кокс, давирхай гарган авах, экспортлох	Галба Өөш долоодын говь	144472	242583894
2	Гурвантэс	“МАК” ХХК	Ашигт малтмал олборлолт	Алтайн өвөр говь	95785	122933031
3		“Чин хуа – МАК – Нарийн сухайт” ХХК	Ашигт малтмал олборлолт	Алтайн өвөр говь	244530	466130615
4		“Саус гоби сэндс” ХХК	Ашигт малтмал олборлолт	Алтайн өвөр говь	433243.5	615749185
5		“Жавхлант орд” ХХК	Ашигт малтмал олборлолт	Алтайн өвөр говь	22755	35151119.2
6	Номгон	“Дун юань” ХХК	Холимог металлын ордоос хар тугалга олборлох	Алтайн өвөр говь	37947.5	52480569.3
7	Ханбогд	“Оюу толгой” ХХК	Алт, зэс баяжуулах, олборлох	Галба Өөш долоодын говь	9476548	16255727202
8	Цогтцэций	“Энержи ресурс” ХХК	Нүүрс баяжуулах	Галба Өөш долоодын говь	2400000	4 219 767 000
9		“Ухаа худаг ус хангамж” ХХК	Унд ахуйн болон үйлдвэрлэл	Галба Өөш долоодын говь	391945	496 221 043
10		“Эрдэнэс таван толгой” ХК	Унд ахуйн болон үйлдвэрлэл	Галба Өөш долоодын говь	89105	95 189 096
11		“Таван толгой” ХК	Унд ахуйн болон үйлдвэрлэл	Галба Өөш долоодын говь	468595	680 328963
12		“Монголын Төмөр Зам” ХХК	Төмөр замын далангийн шороон овоолгыг нягтруулах	Галба Өөш долоодын говь	733886.68	1 287 144 299

13	Даланзадгад	“Гүний ус”ХХК	Нийтийн аж ахуй үйлчилгээ	Онги гол	368044	300087646
Нийт					1036829.3	24869493662.5

Үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай усны хэрглээ нэмэгдэх хэрээр гадна бохир усны хэмжээ ихээхэн нэмэгдэх бөгөөд түүнийг цэвэрлэх байгууламжын төлөвлөлтийн асуудлыг нэн тэргүүнд хийх шаардлагатай. Доорхи хүснэгтэд бохир ус цэвэрлэх байгууламжын төлөвлөлт, одоогийн байдлыг үзүүлэв.

Хүснэгт№6.3. Нийтийн аж ахуйн байгууллагуудын бохир ус цэвэрлэх байгууламжийн судалгаа, төлөвлөлт

Цэвэрлэх байгууламжийн байршил	Ашиглалтад орсон, он	Хүчин чадал, м³/хон		Цэвэрлэгээний төрөл		Хугацаа		
		Төслийн	ашиглалтийн	Механик	Биологи	Өргөтгөн шинэчилсэн	Өргөтгөн шинэчлэх	Шинээр барих
Даланзадгад	1971	1800	850		1	2008		2014-2015
Цогт-Цэций	2013	3000						2013
Ханбогд -Оюутолгой	2006	4000		1		2010		
Гурвантэс								

Хүснэгт№6.4. Төлөвлөж буй бохир ус цэвэрлэх байгууламжийн судалгаа

№	Сумдын нэр	Байршил	Цэвэрлэгээний төрөл	Талбайн хэмжээ	Хугацаа
1	Баяндалай	Сумын төвийн зүүн талд	ТЭЗҮ-ээр тодорхойлох	0.5 га	2015
2	Цогт-Овоо	Сумын төвийн урд		1 га	2015
3	Номгон	Сумын төвийн зүүн урд хогийн цэгийн хажууд		0.7 га	2015
4	Баян-овоо	Сумын төвийн зүүн урд 1.5 км орчим		0.5 га	2016
5	Мандал-Овоо	Сумын төвийн зүүн урд хогийн цэгийн хойд талд		1 га	2016
6	Манлай				
7	Хүрмэн	Сумын төвийн урд		0.7 га	2017
8	Сэврэй	Сумын төвийн урд зүгт 6 км орчимд		0,5 га	2015

Хүснэгт№6.5. 2014 оноос өмнөх хийгдсэн ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгааны ажлыг талаарх мэдээлэл болон 2015-2016 онуудад хийхээр төлөвлөж байгаа аймаг, сумдын ус хангамжийн үүсвэрийн хайгуулын ажил

№	Сумын нэр	Ус хангамжийн эх үүсвэрт хайгуул хийгдсэн он	Нөөц багтуулсан хугацаа	Дахин ГДУ-ны нөөцийн хайгуул хийх эсэх	Шинэ төсөлд хамрагдах эсэх			ГДУ-ны нөөц хүрэлцээтэй эсэх	Усны чанар стандартад нийцэж байгаа эсэх	Зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулах шаардлагатай эсэх	Орон нутгаас усны хайгуул хийх шаардлагатай эсэх	2015-2016 онуудад аймаг, сумдад хийх усны эх үүсвэрийн хайгуул төлөвлөсөн сумд	
					2013 он	2014 он	2015 он					2015 он	2016 он
1	Ханбогд	Гүний хоолой	2008	2003-2004, 2007-2008	-	Цогт-Овоо сум	Цогт-Овоо сум	Ашиглах боломжит нөөцийг баталгаажуулсан	Шаарлага хангахгүй	Тийм	Тийм	+	+

2	Цогтцэций	Наймантын хөндий	2008					Ашиглах боломжит нөөцийг баталгаажуулсан	Шаарлага хангахгүй	Тийм	Тийм		+	+
3	Даланзадгад	БОАЖЯамны санхүүжилтээр 2011 онд Даланзадгад хотын усны эх үүсвэрийн нөөцийг баталгаажуулах хайгуулыг Төв ус ХХК хийж гүйцэтгэсэн боловч одоог хүртэл нөөц баталгаажуулж, тайлан гаргаагүй байна.								Тийм	Тийм		+	+
4	Баян-Овоо	Баян-Овоо сумын Таван алд нэртэй газар Таван толгойн ордын усан хангамжийн зориулалтаар 2013 онд гидрогеологийн хайгуул хийгдсэн. Тайлан, мэдээлэл байхгүй.								Тийм	Тийм			
5	Мандал-Овоо									Тийм	Тийм			
6	Манлай									Тийм	Тийм			
7	Номгон									Тийм	Тийм			
8	Ноён									Тийм	Тийм			
9	Сэврэй									Тийм	Тийм			
10	Ханбогд									Тийм	Тийм			
11	Мандал-Овоо									Тийм	Тийм			
12	Хүрмэн									Тийм	Тийм			
13	Цогт-Овоо									Тийм	Тийм			
14	Цогтцэций									Тийм	Тийм			
15	Даланзадгад									Тийм	Тийм			

Үйлдвэр, ахуйн хэрэглээнд ус ашиглалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ

1. Хүнсний бус үйлдвэрлэлийн усан хангамжийн сүлжээг унд ахуйн болон хүнсний үйлдвэрийн усан хангамжийн сүлжээнээс салгахын зэрэгцээ үйлдвэрлэлийн технологийн шаардлагатай уялдуулан технологийн хэрэгцээний усыг эргэлтээр болон давтан ашиглах системд шилжүүлэх, үүний тулд энэ чиглэлээр хийгдэх судалгаа, туршилтын ажлыг өргөжүүлэх арга хэмжээ авах,

2. Аймгийн төвийн гэр хорооллын хүн амыг хэсгийн усан хангамжийн байнгын сүлжээнээс усаар хангах тогтолцоонд аажимдаа шилжүүлэх,

3. Сумын төв, түүнтэй адилтгах хэмжээний хөдөөгийн төв сууринг хэрэглэгчдийн байршилтай уялдуулан хэсэгчилсэн байнгын сүлжээнээс усаар хангах,

4. Усан хангамжийн шугам сүлжээний усны алдагдлыг багасгахын тулд шугам сүлжээн дээрхи арматур, ариун цэврийн тоног хэрэгслийг найдвартай ажиллагаатай орчин

үеийн тоног хэрэгслээр солих техникийн бодлого баримтлахын зэрэгцээ хэрэглэгчдийг тоолууржуулах ажлыг үргэлжлүүлэх,

5. Төв суурин газрын ойролцоо орших гадаргын усны эх үүсвэрийн ариун цэврийн хамгаалалтын нөхцлийг сайжруулах, ундны усны эх үүсвэрийн нэгэн адил үзэж ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоох,

6. Хөдөөгийн төв суурингийн хүн амын унд, мал сүргийн усан хангамжинд ашиглаж байгаа уст цэг, худгийг зааглан салгаж, ариун цэврийн хамгаалалтыг сайжруулах ажлыг нэн даруй хэрэгжүүлэх,

7. Усны чанарыг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэхийн зэрэгцээ бусад орны туршлагыг судлан нэвтрүүлэх,

8. Ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжуудын найдвартай ажиллагааг хангаж, техник, технологийн шинэчлэл хийх замаар төслийн техникийн удирдамжийн хэмжээнд хүртэл бохир усыг цэвэршүүлэх тогтвортой горимоор ажилладаг болгох,

9. Хөдөөгийн малчид, хөдөлмөрчид ундны усны стандартын шаардлага хангасан ус ундандаа хэрэглэх нөхцлийг бүрдүүлэхийн тулд айл өрхийн зориулалттай ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх жижиг төхөөрөмжийг зохион бүтээх, туршилтын журмаар үйлдвэрлэсэн төхөөрөмжийн хийц, чанарыг сайжруулах, бусад орны туршлагыг судлан ашиглах зэрэг асуудлууд байна.

6.2.2. Усны сан бүхий газрын талхагдал доройтлыг бууруулах

Усны сан бүхий газрын доройтолд бэлчээр ашиглалтын хэв маяг, гол горхи, нуур, худаг уст цэг дагасан бэлчээрийн талхагдал нь усны сан бүхий газрын чанар нөөцөд ихээхэн нөлөөлж байдаг бөгөөд усжуулагдаагүй бэлчээр бараг ашиглагддаггүй учраас түүний ачаалал нь усжуулагдсан хэсэгтээ ирж бэлчээрийн усжуулагдсан хэсгийн ачаалал хэтэрч талхлагдах явдал их байна.

Говь нутгийн бэлчээрийг бүрэн дүүрэн, зөв зохистой, үр ашигтай ашиглах, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тууштай хөгжүүлэх үндсэн нөхцлийн нэг нь бэлчээр усжуулалтын асуудал юм. Иймээс ч манай төр засгаас бэлчээр нутгийг усжуулах, мал сүргийг усаар хангах ажилд ихээхэн анхаарал тавьж хүч хөрөнгө зарцуулж байгаа билээ.

Өмнөговь аймгийн хотгор гүдгэр нь дундаж өндөр болон уул,тал, хотгорын хамарч түүний гадаад төрх нь Монголын говийн үзэсгэлэнт байдлыг бий болгож байна. Өмнөговь аймгийн хотгор гүдгэрийн үнэлгээг хийхдээ газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээг гадаргын хэрчигдлийн шигүү, гадаргын хэрчигдлийн гүн, гадаргын налуу, суурин амралтын газар байгуулах нутаг дэвсгэр гэсэн дөрвөн шалгуур үзүүлэлтийг сонгон үнэлгээ хийсэн /Зураг№8.1/. Судалгааны үр дүнд тус аймгийн нутагт гадаргын хувьд аялал рекреацийн сул, дунд, өндөр, нэн өндөр үнэлгээтэй ландшафтын хэв шинжүүдийг ялгасан болно. Гадаргын хотгор гүдгэрийн үнэлгээгээр Гурван тэс, Сэврэй, Ноён, Булган Номгон, Хүрмэн сумдын нутаг дэвсгэрийн ландшафтын хэв шинжүүд нэн өндөр ба өндөр үнэлгээтэй гарсан тул ландшафтын бусад бүрэлдэхүүн хэсгүүдийн хамт тус сумдын нутагт аялал-рекреацийн олон төрлийн үйлдлийг хийж болно.

8.2.1.4. Уур амьсгалын рекреацийн үнэлгээ

Өмнөговь аймгийн уур амьсгалын рекреацийн үнэлгээний шатлал, шалгуурыг Үндэсний атласт орсон нар гийгүүлэх хугацаа, агаарын температурын хоногийн дундаж 10° ба түүнээс дээш байх өдөр, агаарын харьцангуй чийгийн дундаж, цасан бүрхүүлийн зузаан, тогтвортой цасан бүрхүүл үүсэх хугацаа гэсэн 5 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар 1:3000000 масштабтай газрын зургийг тулгуур материал болгон ашиглан хийлээ. /Зураг8.2/.




Зураг№8.2. Аялал-рекреацийн уур амьсгалын үнэлгээ

Бидний судалгаагаар Өмнөговь аймагт аялал рекреацийн тохиромжтой хугацаа нь олон жилийн дунджаар 90-110 хоног байна. Уур амьсгалын хувьд өндөр, дунд, сул үнэлгээтэй нутгууд ялгарч байна. Үүнд: Гурван тэс, Ноён, Сэврэй, Баяндалай, Хүрмэн, Булган, Номгон, Баян-овоо сумдын нутаг дэвсгэрүүд өндөр үзүүлэлттэй гарсан байна. Энэ нь дээрх сумуудад аялал рекреацийн үйл ажиллагааг явуулахад уур амьсгалын хувьд тохиромжтой болохыг илэрхийлж байна

8.2.1.5. Гадаргын ус, рашааны аялал рекреацийн үнэлгээ

Өмнөговь аймгийн гадаргын ус, рашааны рекреацийн нөөцийн үнэлгээг 3 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар Үндэсний атласаас “Голын сүлжээний нягтшил” 1:12000000 масштабтай газрын зургийг, “Рашаан”, “Гол мөрний нийлбэр урсац” 1:9000000 масштабтай газрын зургуудыг тулгуур материал болгон ашиглав.

Өмнөговь аймгийн гадаргын ус, рашааны аялал рекреацийн үнэлгээгээр өндөр, дунд, сул гэсэн хэв шинжүүд ялгарсан бөгөөд нэн өндөр хэв шинж ялгарсангүй. Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Цогт-Овоо, Булган, Ханхонгор сумдын нутгийн ландшафтын нилээд хэв шинжүүдэд гадаргын ус рашааны аялал рекреацийн үнэлгээгээр өндөр болон дунд гэсэн үнэлгээтэй гарсан байна/Зураг8.3/.




Зураг№8.3. Ус, рашааны аялал-рекреацийн үнэлгээний зураг

8.2.1.6. Өмнөговь аймгийн ургамалжилтын аялал рекреацийн үнэлгээ

Өмнөговь аймгийн ургамалжилтын рекреацийн үнэлгээний шатлал, шалгуурыг Үндэсний атласт орсон “Ургамлын бүлгэмдлийн хэв шинж”, “Нутаг дэвсгэрийн зайн байдал”, “Ховор ургамал” гэсэн 3 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар 1:3000000 масштабтай газрын зургийг тулгуур материал болгон ашиглав.


Өмнөговь аймгийн ургамалжилтын аялал рекреацийн үнэлгээгээр өндөр, дунд, сул хэв шинжүүд ялгарсан бөгөөд нэн өндөр хэв шинж гарсангүй. Тус аймгийн Гурван тэс, Ноён, Цогт-овоо, Ханхонгор сумдын нутаг дэвсгэрийн ихэнх хэсэг нь өндөр үнэлгээтэй гарсан байна. Дээрхи сумдын нутагт хунчир, алтан үндэс, дэгд, сэржмядаг зэрэг олон зүйлийн эмийн, хармаг, гоёо, цулхир мэтийн амтлаг ургамал, заган ойтойгоос гадна хайлс, тоорой, жигд зэрэг мод элбэгтэй/Зураг8.4/.



Зураг №8.4. Ургамалын аялал-рекреацийн үнэлгээний зураг

8.2.1.7. Өмнөговь аймгийн ховор амьтны аялал рекреацийн үнэлгээ

Өмнөговь аймгийн амьтны рекреацийн үнэлгээний шатлал, шалгуурыг Үндэсний атласт орсон”, “Шувууны газарзүйн мужлалт, ховор шувуу”, “Хөхтөний газарзүйн мужлалт, ховор хөхтөн” гэсэн 2 шалгуур үзүүлэлт, 4 шатлалаар 1:3.000.000 масштабтай газрын зургийг тулгуур материал болгон ашиглан хийлээ.




Зураг №8.5. Ховор амьтны аялал-рекреацийн зураг

Бидний судалгаагаар ховор амьтны аялал рекреацийн үнэлгээгээр өндөр, дунд, сул хэв шинжийн нутаг дэвсгэрүүд ялгарсан/Зураг 8.5/.

8.2.1.8. Өмнөговь аймгийн ландшафтын рекреацийн нэгдсэн үнэлгээ

Ландшафт-рекреацийн нэгдсэн үнэлгээгээр ландшафтын болон аялал-рекреацийн хувьд онцгой ач холбогдолтой газруудыг олж тогтоох, ашиглаж байгаа болон ашиглаж болохуйц газруудад учирч буй эрсдэл, энэ эрсдлийг бууруулах болон арилгах боломж, хүн ам байнга оршин суудаг болон эзэмшигдээгүй нутаг дэвсгэрийн хөгжлийн асуудал, түүнтэй уялдан тухайн газарт аялал-рекреацийн нутаг дэвсгэрийн систем бүрэлдэх урьдчилсан нөхцлийг илрүүлэх нь зүйтэй. Өмнөговь аймгийн ландшафтын рекреацийн нэгдсэн үнэлгээг байгалийн иж бүрдүүлүүдийн үзүүлэлт бүрээр хийсэн үнэлгээнийхээ үр дүнг нэгтгэж гаргав. Ийнхүү Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийг ландшафт-рекреацийн чадавхийн сул, дунд, өндөр гэсэн гурван түвшинг ангиллаа. Үүнд: Гурван-тэс, Сэврэй, Хүрмэн, Номгон сумдын нутаг дэвсгэрийн ихэнх хэсэг буюу Говь гурван сайханы нуруу орчмын нутаг өндөр үнэлгээтэй гарсан байна. Бидний хийсэн ландшафтын болон байгалийн бүрэлдэхүүн хэсэг болгоны аялал рекреацийн үнэлгээний үр дүн нь тухайн нутаг дэвсгэрийн аялал рекреацийн чадавхиар ялган бүсчилж, ашиглалтын хэтийн төлвийг тодорхойлох боломжтой/Зураг 8.6/.




Зураг №8.6. Аялал-рекреацийн ландшафтын үнэлгээний зураг

8.2.1.9. Байгалийн үзэсгэлэнт газар, түүх-соёлын дурсгалуудын аялал-рекреацийн үнэлгээ

Өмнөговь аймгийн байгалийн үзэсгэлэнт газар болон түүх соёлын дурсгалуудын аялал рекреацийн үнэлгээг хийхийн тулд засаг, захиргааны нэгж болох тухайн сумын нутаг дэвсгэр дэхь дурсгалуудын жагсаалтыг гаргаж, үр дүнгээр нь тоон утгыг тооцсон. Энэ тоон үзүүлэлтэнд үндэслэн Өмнөговь аймгийн байгалийн үзэсгэлэнт газар, түүх-


соёлын чадавхийн аялал-рекреацийн үнэлгээг сум тус бүрээр 4 шатлалын дагуу үнэлгээний дүнг нэгтгэн гаргаж, түүх, соёлын нөөцийн ерөнхий чадавхийг тогтоосон. Тэгэхдээ улсын хамгаалалтанд байгаа болон “Монгол нутаг дахь түүх, соёлын дурсгал” лавлах толь бичигт орсон болон улсын хамгаалалтанд байгаа газраас үл хөдлөх дурсгал байхгүй нутгийг чадавхи султай, 1 байгаа нутгийг дунд зэргийн, 2-3 байгаа нутгийг өндөр, 4-өөс дээш байгаа нутгийг нэн өндөр татах чадвартай гэж үнэлэв /Зураг8.7.



Зураг№8.7. Байгалийн болон түүх соёлын аялал рекреацийн үнэлгээний зураг

8.2.1.10. Аялал-рекреацийн чадавхийн иж бүрэн үнэлгээ

Аялал-рекреацийн чадавхийн иж бүрэн үнэлгээг хийхдээ засаг, захиргааны хувиарыг баримтлав. Тэгэхдээ түүх, соёлын аялал-рекреацийн чадавхийн түвшинг ландшафт-рекреацийн чадавхийн дундаж түвшинтэй харьцуулж тухайн нутаг дэвсгэрийн аялал-рекреацийн чадавхийн иж бүрэн үнэлгээг хийсэн.



Зураг №8.8. Аялал-рекреацийн нэгдсэн үнэлгээний зураг

Өмнөговь аймгийн засаг захиргааны нэгж сумаар авч үзвэл аялал рекреацийн өндөр чадавхитай нутгуудад Сэврэй, Булган, Номгон, Ноён, Ханбогд сумд, дунд чадавхитай нутгуудад Гурвантэс, Баяндалай, Хүрмэн, Цогтовоо, Баян-овоо сумуудын нутаг дэвсгэр, харин сул чадавхитай Ханхонгор, Мандал-Овоо, Цогц-Цэций, Манлай гэсэн сумдын нутаг дэвсгэр гарсан байна. Нэг нэгэнтэйгээ зэрэгцэн оршиж буй нутаг дэвсгэрүүдийг үнэлгээний төстэй үзүүлэлтүүдээр нэг ерөнхий ареальд оруулж нэгтгэх замаар бүсчилсний үр дүнд аялал рекреацийн чадавхиараа өндөр, дунд, сул гэсэн гурван түвшний ялгаатай нутгууд илэрч байна/Зураг16/. Энэ нь аялал рекреацийн бүсчлэл хийх үндэс болж байгаа юм. Нэг нэгэнтэйгээ зэрэгцэн оршиж буй нутаг дэвсгэрүүдийг үнэлгээний төстэй үзүүлэлтүүдээр нь нэг ерөнхий ареальд оруулж нэгтгэх замаар бүсчилсний үр дүнд тус аймагт аялал рекреацийн гурван район ялгарч байна/Зураг8.8/. Үүнд:

1. Аялал рекреацийн чадавхи өндөртэй бүс нутаг
2. Аялал рекреацийн чадавхи дунд бүс нутаг
3. Аялал рекреацийн чадавхи султай бүс нутаг гэсэн аялал рекреацийн чадавхийн түвшний ялгаатай нутгууд юм.


8.2.2. Аялал-рекреацийн бүс нутгийг хөгжүүлэх төлөвлөлт**8.2.2.1. Өмнөговь аймагт хөгжүүлэх боломжтой аялалын төрлүүд**

Хүснэгт №8.5. Аялал рекреацийн бүс нутгуудад хөгжүүлэх боломжтой аяллын төрлүүд

Аялал рекреацийн бүсүүд	Жуулчны сэтгэл татах үзмэрүүд	Цаашид хөгжүүлэх боломжтой ерөнхий ба тусгай сонирхолын аяллын төрлүүд
Аялал рекреацийн чадавхи өндөртэй бүс нутаг/ Сэврэй, Булган, Номгон, Ноён, Ханбогд /	Дэмчигийн хийд, Улаан сахиусын хийд, Үнстийн хийд, Галбын уулын үзэсгэлэнт газар, Баяжихын агуй Оцон мааньт, Гурван зээрдийн агуй, Говийн бага дархан газрын А хэсэг, Говийн бага дархан газрын Б хэсэг, Ловончомбо агуй, Оюу толгойн уурхай, Хонгорын гол, Хонгорын элс, Сэрүүн булгийн баянбүрд, Наранбулаг, Зөөлөнгийн нуруу, Нарангийн адгийн бичигт хөшөө, Монгол бичигт хад, Их сэврэй уул, Нэмэгт уул, Сэврэн уул, Баруун сайханы нуруу, Дунд сайханы нуруу, Зүүн сайханы нуруу, Төгрөгийн ширээ, Баянзаг, Цахиурт, Цоорхой, Майхан толгой, Ёлын ам, Ноён уул, Толь хад	Тусгай сонирхолын аялалаас дараах төрлүүд хийгдэж байна. -Шувуу ажиглах: Жороо тоодог /Horbaru bustard/, Хулан жороо /Mongolian ground jay/, Цөлийн зэржигэнэ /Desert Warbler/, Алтайн хойлог /Altai is snow cock/, Ногтруу / Palla is sand grouses/, Цармын бялзуухай /Wall creeper/, Ёл / Lammergier/ зэрэг говь цөлийн унаган шувуудыг харах боломжтой -Байгалийн иж бүрдлийн аялал: /Ёлын ам – Дүнгэнээ – Аргалантын өвөр – Ямаатын рашаан – Гэгээтийн хөндий – Хонгорын гол - Чоно шургуул – Адаг гашуун / гэсэн маршрутаар аялах -Фото сафари -Судалгаа шинжилгээний аялал - Нэн ховор амьтан түүний ул мөрөөр аялах аялал - Уулын аялал - Шувуу ажиглах аялал - Түүх соёлын аялал - Эрдэм шинжилгээ судалгааны аялал -Бартаат замын буюу авто аялал - Морь , тэмээн аялал -”Есөн гайхамшигийн” аялал / Өмнөговь аймгийн “Есөн гайхамшиг”-ийг шалгаруулах ажлыг зохион байгуулсан. Энэ есөн гайхамшигт байгалийн өвөрмөц тогтоц бүхий дараах газрууд мөн хүний гараа бүтээгдсэн зүйлс багтсан. 1. Говь гурван сайхан 2. Хонгорын элс 3. Баянзаг 4. Хэрмэн цав 5. Толь хад 6. Алгуй улаан цав 7. Галбын говь 8. Сангийн далай хийд 9. Ноён, Сэврэй хийцийн мөнгөн эдлэл/ - Хил орчмын аялал -Палеонтологийн аялал: Археологи, палеонтологийн олдвороор дэлхийд эртнээс танигдсан эртний үлэг гүрвэлийн олдвор бүхий /Баянзаг, Нэмэгт, Хэрмэн цав/ нөөц газруудтай. Ихэвчлэн доорх маршрутын дагуу явагддаг. /Баянзаг – Төгрөгийн ширээ – Хонгорын гол – Боодог – Улаан хонгил – Наран дац – Зулганай – Хэрмэн цав – Шаригийн ганга – Бүгийн цав – Баянхонгорын Шаргалжуут /

<p>Аялал рекреацийн дунд чадавхитай нутгуудад / Гурвантэс, Баяндалай, Хүрмэн, Цогт-Овоо, Баян-овоо/</p>	<p>Бичигт гэдэг газар орших сүг зурагтай хад, Хэрмэн цав, Наран даац, Говь гурван сайхан БЦГ, Улаан суврага</p>	<p>-”Есөн гайхамшигийн” аялал - Шувуу ажиглах аялал - Агнуурын аялал - Палеонтологийн аялал - Хил орчмын аялал / Гашуун сухайтын хилийн боомтоор БНХАУ-аас жуулчин оруулах эхний алхам хийгдсэн бөгөөд цаашид Гурвантэс сумын Шивээ хүрэнгийн боомтоор ӨМӨЗО-ны Альшаа аймагтай жуулчин солилцох боломжтой / -Тэмээн аялал: Монгол улсын хоёр бөхт тэмээний 38 хувь буюу 86.0 мянган толгой нь тус аймагт байдаг. Өмнөговь аймгийн сүргийн бүтцийн 70%-г тэмээ дангаараа эзэлдэг. Иймээс тэмээн аялал нь тус аймгийн уламжлалт аяллын маршрутанд орсон байдаг. Мөн жил бүрийн хаврын тэргүүн сарын шинийн 8-нд Тэмээний баярыг зохион байгуулдаг уламжлал тогтоод байгаа бөгөөд энэ баярт оролцох гадаадын жуулчдын тоо жилээс жилд нэмэгдэж байна. Мөн үүнээс гадна Ингэний айрагны баяр, Тэмээн поло тэмцээн зэрэг арга хэмжээг тогтмол зохион байгуулснаар гадаад дотоодын жуулчдыг татах бүтээгдэхүүн болгох боломжтой байгаа юм.</p>
<p>Аялал рекреацийн чадавхи султай бүс нутаг/ Ханхонгор, Мандал-Овоо, Цогц-Цэций, Манлай/</p>	<p>Загийн ус, Сүйхэнт уул, Сайн бичигт хийдийн монгол бичиг</p>	<p>-”Есөн гайхамшигийн” аялал - Бизнес аялал -тэмээн аялал -байгалийн аялал</p>

Санал болгож буй эдгээр аяллыг дагнасан хэлбэрээр хөгжүүлэхээс гадна хосолсон байдлаар хэрэгжүүлэх нь ач холбогдолтой юм. Мөн сумын наадам, даншиг, овоо тахилга, бэсрэг наадам зэрэг орон нутгийн тэмдэглэлт үйл явдлуудтай холбосон аяллын хөтөлбөр, тухайн бүсийн онцлогт тулгуурласан төрөл бүрийн эвент арга хэмжээг зохион байгуулах нь илүү үр дүнтэй. Морь, тэмээ хөлслөхөөс гадна орон нутгийн онцлогийг харуулсан гар урлалын бүтээгдэхүүн бэлэг дурсгалын зүйлсийг үйлдвэрлэхэд нутгийн иргэдийг татан оролцуулж, тэдний орлогыг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй. Сонирхогч талуудын дэмжлэгтэйгээр иргэд, малчдын нөхөрлөлд сургалт зохион байгуулан, эсгий урлал, нэхмэл, хатгамал, сийлбэр хийх, үндэсний хувцас дээл, малгай, хантааз оёх зэрэг өрхийн болон жижиг үйлдвэрлэлийг дэмжих боломж байна.



Зураг№8.9. Өмнөговь аймгийн аялал-рекреацийн үнэлгээнд тулгуурласан төлөвлөлтийн зураг

8.2.2.2. Өмнөговь аймгийн аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой газар нутгууд, аялалын төрлүүд

Өмнөговь аймгийн аялал жуулчлалын нийт нөөцүүдийг хэд хэдэн бүлэгт хуваан авч үзэж болох бөгөөд нөөцүүдийн аялал жуулчлалд ашиглагдаж байгаа шинж байдал болон төрлөөс хамааран аяллын дэд бүсийг ангилан тодорхойлж болох юм. Тухайлбал:

1. Ханбогдын дэд бүс
2. Сэврэйн дэд бүс
3. Булганы дэд бүс

ХАН БОГДЫН ДЭД БҮС

Уг бүс нь Өмнөговь аймгийн нутгийн зүүн өмнөд хэсгийг хамаарах буюу Ханбогд сумын нутаг дэвсгэр дэх түүх соёл, байгалийн үзмэрүүд орно. Ханбогдын бүсэд орших түүх соёлын дурсгалуудыг ашиглан тусгайлан аялалын хөтөлбөр маршрутыг бий болгон эдийн засгийн эргэлтэнд оруулах шаардлагатай байна. Энэ бүсэд шашин мөргөлийн холбогдол бүхий сүм хийд 3 байгаа бөгөөд байгалийн өвөрмөгц сонин тогтоцийг түшиглэсэн нь аялал жуулчлалд идэвхитэй оролцох боломж нөхцлийг илэрхийлж байна.

Хан богдын дэд бүсэд жуулчдын сонирхол татахуйц дараах үзмэрүүд байна.

- Дэмчигийн хийд
- Улаан сахиусын хийд
- Үнстийн хийд
- Галбын уулын үзэсгэлэнт газар

- Баяжихын агуй
- Оцон мааньт
- Гурван зээрдийн агуй
- Говийн бага дархан газрын А хэсэг
- Говийн бага дархан газрын Б хэсэг
- Ловончомбо агуй
- Оюу толгойн уурхай зэрэг болно.

Уг бүсэд Галбын 3 хийдийг түшиглэн Үртийн булгийн жуулчны бааз үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт№8.6. Ханбогдын дэд бүсэд хөгжүүлэх жуулчлалын замнал-1

№	Чиглэл	Туулах зай	Үзэх үзмэр
1	Даланзадгад-Цэций уул	115 км	Их уул, Цэций уулын байгалийн үзэсгэлэнт газар
2	Цэций уул-Ханбогд сум	137 км	Хавиргын тал, Гурван галавын уулын үзэсгэлэнт газар
3	Ханбогд-Галбын уул	45 км	Дэмчигийн хийд, Улаансахиусын хийд, Үнстийн хийд
4	Галбын уул-Баяжихын агуй	20 км	Баяжихын агуй
5	Баяжихын агуй-Гурван зээрдийн агуй	50 км	Гурванзээрдийн агуй
6	Гурван зээрдийн агуй-Даланзадгад	310 км	Оюу толгой

Хүснэгт№8.7. Ханбогдын дэд бүсэд хөгжүүлэх жуулчлалын замнал-2

№	Чиглэл	Туулах зай	Үзэх үзмэр
1	Даланзадгад-Цэций уул	115 км	Их уул, Цэций уулын байгалийн үзэсгэлэнт газар
2	Цэций уул-Ханбогд сум	137 км	Хавиргын тал, Гурван галавын уулын үзэсгэлэнт газар
3	Ханбогд-Галбын уул	45 км	Дэмчигийн хийд, Улаансахиусын хийд, Үнстийн хийд
4	Галбын уул-Даланзадгад	248 км	Даланзадгад

СЭВРЭЙН ДЭД БҮС

Сэврэйн дэд бүс нь Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотоос баруун хойд зүгт Гурвансайханы нурууны баруун хэсэг Сэврэй сумын нутагт орших байгалийн өвөрмөгц шинж байдлыг бүрдүүлсэн байгалийн иж бүрдэл газар юм.

Энд амралт, аялал зугааллага, танин мэдэхүйн болон тусгай сонирхолын аяллын төрлүүд хийгдэж байна. Тусгай сонирхолын аялалаас дараах төрлүүд хийгдэж байна.

-Шувуу ажиглах

-Байгалийн иж бүрдлийн аялал

-Фото сафари

-Судалгаа шинжилгээний аялал зэрэг болно.

Сэврэйн дэд бүсэд дараах жуулчны сонирхол татахуйц үзмэр, нөөцүүд байна.

- Хонгорын гол
- Хонгорын элс
- Сэрүүн булгийн баянбүрд
- Наранбулаг
- Зөөлөнгийн нуруу
- Нарангийн адгийн бичигт хөшөө
- Монгол бичигт хад
- Их сэврэй уул
- Нэмэгт уул
- Сэрвэн уул

Энэ бүсэд аялал жуулчлалын байршлын хэрэгслийн үйлчилгээ үзүүлж буй дараах байгууллагууд ажиллаж байна.

- Дуут манхан
- Төвшин
- Хонгор
- Жуулчин говь
- Жуулчин Ханбогд

Хүснэгт№8.8. Сэврэй дэд бүсэд хөгжүүлэх жуулчлалын замнал-1

№	Чиглэл	Туулах зай	Үзэх үзмэр
1	Даланзадгад-Баяндалай сум	55 км	Зүүн сайханы нуруу, Дунд сайханы нурууны байгалийн үзэсгэлэнт газар
2	Баяндалай -Хоолт	68 км	Төхөмийн тал, Баян төхөмийн нуур
3	Хоолт-Хонгорын элс	45 км	Хонгорын элс, Хонгорын гол, Сэрүүн булаг
4	Хонгорын элс-Сэврэй сум	25 км	Зөөлөнгийн нуруу, Сэврэй сум
5	Сэврэй сум-Буйлсан	30 км	Зөөлөнгийн нуруу, Шар тал, Баян-Өндөр уул
6	Буйлсан-Баяндалай сум	90 км	Баяндалай сум
7	Баяндалай сум-Даланзадгад	55 км	Даланзадгад

Хүснэгт№8.9. Сэврэй дэд бүсэд хөгжүүлэх жуулчлалын замнал-2

№	Чиглэл	Туулах зай	Үзэх үзмэр
1	Даланзадгад-Баяндалай сум	55 км	Зүүн сайханы нуруу, Дунд сайханы нурууны байгалийн үзэсгэлэнт газар
2	Баяндалай –Хоолт	68 км	Төхөмийн тал, Баян төхөмийн нуур
3	Хоолт-Хонгорын элс	45 км	Хонгорын элс, Хонгорын гол, Сэрүүн булаг
4	Хонгорын элс- Хоолт	45 км	Зөөлөнгийн нуруу
5	Хоолт –Баяндалай сум	68 км	Зөөлөнгийн нуруу, Төхөмийн тал, Баян төхөмийн нуур
6	Баяндалай сум-Даланзадгад	55 км	Баяндалай сум, Даланзадгад
7	Баяндалай сум-Даланзадгад	55 км	Даланзадгад

БУЛГАНЫ ДЭД БҮС

Энэ дэд бүс нь Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотоос зүүн хойш Гурван сайханы нурууны баруун хойд үргэлжлэл хэсэг болох бөгөөд Монголын аялал жуулчлалын зах зээлд оролцож буй бүс нутгуудаас нэлээд идэвхитэйд тооцогддог хэсэг юм. Энэ бүсэд тусгай сонирхолын аяллын олон төрөл хэлбэрийг зохион байгуулж болох бөгөөд дэлхий өөрийн өвөрмөгц шинж байдлаараа сурталчилагдаж буй бүс нутаг юм. Байгалийн дүр төрх, эртний амьтан ургамалын үлдэгдэл зэрэг түүхэн олдворын өлгий нутаг болохынхоо хувьд уг бүс судалгаа шинжилгээ болон танин мэдэхүйн ач холбогдол өндөртэй юм. Цаашид Булганы бүс нутагт тусгай сонирхолын аялалын олон төрөл хэлбэрийг төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудын санал санаачлага дэмжлэгээр хөгжүүлэх шаардлагатай байна.

Булганы бүсэд жуулчдын сонирхол татахуйц дараах үзмэрүүд байна.

- Баруун сайханы нуруу
- Дунд сайханы нуруу
- Зүүн сайханы нуруу
- Төгрөгийн ширээ
- Баянзаг
- Цахиурт
- Цоорхой
- Майхан толгой
- Ёлын ам

Хүснэгт №8.10. Сэврэй дэд бүсэд хөгжүүлэх жуулчлалын замнал-2

№	Чиглэл	Туулах зай	Үзэх үзмэр
1	Даланзадгад-Булган сум	96 км	Зүүн сайханы нуруу, Дунд сайханы Баруун сайханы нурууны байгалийн үзэсгэлэнт газар
2	Булган сум -Цахиурт	25 км	Цахиурт, буруу эргийн хоолой
3	Цахиурт-Төгрөгийн ширээ	40 км	Төгрөгийн ширээ, Майхан толгой
4	Төгрөгийн ширээ – Баянзаг	35 км	Баянзаг
5	Баянзаг –Даланзадгад сум	80 км	Даланзадгад

Хүснэгт №8.11. Жуулчны бааз байгуулах газрууд

№	Сумын нэр	Байршил	Үндэслэл	Хугацаа
1	Гурвантэс	Хайлаастайн хөндий	Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэний дараа газар олголт явагдана	2015-2020
		Наран даац		
2	Ноён	Гурван түшмэл орчим		
3	Сэврэй	Хонгорын элсний өвөр Дунд ус		
		Хөтөл булаг орчим		
4	Ханбогд	Дэмчогийн хийдээс баруун тийш 5 км		
5	Ханхонгор	Баяндалай сумын зааг Жаргалантын хөндийд		

8.2.2.2. Маркетингийн төлөвлөлт

Аялал жуулчлал нь бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгож, борлуулах үйл ажиллагаа явуулж байдгаараа үйлдвэрлэлийн шинжтэй. Байгууллага бүрт аялал жуулчлалын улиралд ирэх жуулчдын тоо, бүтцийг тогтоох, зах зээлийн сегментийг сонгох, хэрэглэгчдийн эрэлтийг тодорхойлох, үйлчилгээний чанарыг урьдчилан тогтоох зэрэг шаардлага урган гардаг. Аймгийн хувьд одооноос байгаль орчноо хамгаалах замаар “Хүрээлэн буй орчинд ээлтэй” –гээр аялал жуулчлалыг хөгжүүлэх нь аялал жуулчлалын хөгжлийн алсыг харсан загвар стратеги болж байна.

Өмнөговь аймгийн өнөөгийн нөхцөл байдал, аялал жуулчлалын бүсүүдийн онцлог, нөөц боломжууд, хөгжүүлэхийг зорьж буй бүтээгдэхүүн үйлчилгээний онцлогуудтай уялдан зорилтот зах зээлийг дараахь байдлаар хэсэгчлэн тэдгээрийн онцлогт тулгуурлан маркетингийн ялгаварт стратегиудыг баримтлана.

Зорилтот зах зээлийн хэсэг - дотоодын жуулчид

Дотоодын аялагчид өөрийн орны үзэсгэлэнт байгаль, түүх соёлын дурсгалт газруудтай танилцах, амарч зугаалах зэрэг төрөл бүрийн аялалд оролцох хүсэл сонирхолтой байдаг. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд дотоод зах зээл рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Сүүлийн жилүүдэд дотоодын аялагч амрагчдын тоо эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан, тэдгээрт зориулсан нэгдсэн арга хэмжээг зохион явуулах нь илүү үр дүнтэй. Уртын амралт, Тосонгийн амралт зэрэг нь дотоодын аялагчдын гол түшиц газар юм. Есөн гайхамшигийн аялал, Ёлын ам, Баян заг, Хэрмэн цав, Төгрөгийн ширээ зэрэг үзмэрийг үзэхээр аялагч амрагчид зуны улиралд олноор зорин ирдэг газар юм. Эдгээр газруудад хүмүүсийн үйл ажиллагаагаар хог хаягдал нэмэгдэх болсон байна.

Иймд Улаанбаатар, хөдөө орон нутаг дахь дотоодын аялагчдад зөв амралтын талаар мэдээлэл түгээх, сурталчилах, нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах нь дотоодын аялагчдын тогтвортой үйл ажиллагаанд чухал нөлөөтэй байна. Цаашдаа жуулчны бааз, амралт сувиллын газрын ажиллах хоногийн тоог нэмэгдүүлж, материаллаг нөхцөл, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Зорилтот зах зээлийн хэсэг - гадаадын жуулчид

Бие даан үүргэвчтэй аялагчид тур операторуудын санал болгосон үйлчилгээнд хамрагдалгүй ямар нэг хатуу төлөвлөсөн аяллын хөтөлбөргүйгээр аялалд оролцдог учраас тэднээс аль болох зайлсхийх хэрэгтэй.

Харин албан ёсны гэрээтэй багц аялагчдыг татахын тулд жуулчны мэдээллийн төв болон эко гэрт Улаанбаатар хотоос ирэх очих нислэгийн хуваарь, аймаг орон нутаг дахь байрлуулах болон хоол ундааны үйлчилгээний газруудын байршил, үйлчилгээний онцлог, холбоо барих утас, хаяг, ТХГН-ын дэглэм, хоноглох, отоглох газрын байрлал, хаанаас морь, тэмээ, машин хөлслөн авч болох, нүүдэлчин айл малчдын нөхөрлөлийн байршил, үйлчилгээний төрөл үнийн санал, аялал жуулчлалын бүсүүдэд аялахад баримтлах зарчим зэрэг мэдээллийг түгээх шаардлагатай. Эко гэр, жуулчны бааз, малчдын нөхөрлөлүүдээр дамжуулан судалгаа санал авч цаашид ямар төрлийн мэдээлэл үйлчилгээ хэрэгтэйг

тодорхойлон үйл ажиллагаандаа тусгах нь чухал. Аймгийн вэб хуудас, мэдээллийн төв, товхимол, тараах материал зэрэг мэдээллийн сувгийг ашиглах боломжтой. Аймгийн жуулчны мэдээллийн төвийг Улаанбаатар хот дахь аялал жуулчлалын мэдээллийн “Гийчин” төвийн үйл ажиллагаатай уялдуулах хэрэгтэй.

Тур оператороор үйлчлүүлж Монгол улсад ирж буй жуулчдын дийлэнхи хувийг багц аяллын жуулчид эзэлдэг нь судалгаагаар тогтоогдсон. Тус аймагт өнгөрсөн жилүүдэд Испани, Германчууд эзлэж байсан бол сүүлийн жилүүдэд Франц, Италичууд жуулчид дийлэнхи хувийг эзэлж байна. Ирж буй жуулчдын ихэнхи хувь буюу 70-80% нь байгалийн аялал жуулчлал экотуризмыг сонирхдог. Европоос ирж буй жуулчдын дийлэнх нь байгалийн сайханд амрах, аялах, явган аялах, тусгай сонирхолын аялал болох уулын аялагч, спорт аялагч, анчин жуулчин, шувуу сонирхогч зэрэг аяллуудыг сонирхон ирж байна. Иймд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах тур операторуудтай нягт хамтран ажиллах шаардлагатай байна.

Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, нутгийн иргэдэд түшиглэсэн хэлбэрээр зохион байгуулах стратегийг баримтлах нь зүйтэй юм. Дэлхийн өв болсон байгалийн үзэсгэлэн бүхий, ховор нэн ховор амьтдын өлгий нутгаар идэвхитэй эко аяллыг нутгийн иргэдэд түшиглэн тур операторуудын хамтын дэмжлэгтэйгээр бий болгож, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх стратеги барьж ажиллах боломжтой. Цаашдаа улсын чанартай үзэсгэлэн яармаг, уулзалт ярилцлагад тогтмол оролцон аяллын тухай мэдээлэл өгч ажиллах арга нь үр дүнтэй юм.

Жуулчны үйлчилгээг сайжруулах, орон нутгийн иргэдийг идэвхижүүлж чадавхижуулахад тур операторууд, аялал жуулчлалын төрийн бус байгууллага, гадаадын төсөл хөтөлбөрүүд, сонирхогч талуудын дэмжлэгтэйгээр орон нутаг дахь жуулчны үйлчилгээг хүргэгчдийг бэлтгэх, сургах, чадваржуулах улмаар үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай.

Өмнөговь аймгийн хувьд аялал жуулчлалын маркетингийн үйл ажиллагаа нь *дотоодын жуулчдад* хүрээлэн буй орчинд эерэг, зохион байгуулалттай амралт, идэвхитэй аяллыг таниулахад чиглэгдэх бол *Гадаадын жуулчдад* Өмнөговь аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийн талаарх мэдээлэл түгээх, аялал жуулчлалын бүсийн ялгавартай бодлого баримтлах, сурталчилахад чиглэгдэнэ.

Маркетингийн стратеги:

Аялал жуулчлалын зорих газрууд нь өөрчлөгдөн байгаа эрэлт хэрэгцээ, шаардлагуудыг соргоогоор мэдэрч, маркетингийн үйл ажиллагаагаа шинэчилж байх хэрэгтэй байдаг. Аяллын явц, бүтээгдэхүүн, тээвэр, байршуулах зэрэг үйлчилгээний багцуудыг санал болгох зэрэг нь хэдийгээр салангид үйл ажиллагаа мэт боловч бүтээгдэхүүн, үйлчилгээний маркетингийн хувьд цогц асуудал болно.

Өмнөговь аймгийн аялал жуулчлалын бүсүүд өөр өөрийн гэсэн онцлогт тулгуурласан ялгавартай бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох нь зүйтэй.

Стратеги:

1. Бусад бүс нутгуудаас ялгарах имиджийг тодорхойлох

2. АЖ-ын өөрийн нэрийн бүтээгдэхүүн шинээр гаргах, үйлдвэрлэх
3. Бүсийн онцлогт нийцүүлэн, янз бүрийн эвентүүдийг зохион байгуулах
4. Мэдээллээр хангах, түгээх
5. Тээврийн хэрэгсэл, байршуулах газрын стандартыг мөрдөх
6. АЖ-ын үйл ажиллагаа эрхлэгчидтэй хамтарсан маркетингийн идэвхижүүлэлт хийх
7. Нэг жуулчнаас олох ашиг орлогыг нэмэгдүүлэх /үнийг нэмэх бус бүтээгдэхүүний төрөл хэлбэрийг нэмэгдүүлэх замаар ашиг орлогыг өсгөх/
8. Хууль эрх зүйн орчныг сайжруулах
9. Байгаль хамгаалал: Үүнд:
 - Байгаль орчны хувьд эмзэг, ховордсон зүйлийг тодорхойлж, газрын зурагт байрлуулах
 - Аялал жуулчлалд зориулж байгаль орчныг хамгаалах хөтөлбөр гаргах
 - Мэдээллийн самбар, хог хаягдлын менежментийг бий болгох
 - АЖ-ын үйл ажиллагаа явуулж буй компани, хувь хүн, сонирхогч талуудад мэдээлэл түгээх, БОХ талаар чадавхижуулах
 - Байгаль орчинд ээлтэй бизнесийг сертификатжуулах жнь нь: Эко зочид буудал, ногоон гэрүүд, ногоон хот айл, цэцэгсийн мөр, мөөгний зам, Рашааны зам... г.м.
 - Байгаль хамгаалах ерөнхий компани үйл ажиллагааг өргөжүүлэх /жнь: байгаль орчныг хамгаалах талаар календарь гаргах, байгаль орчныг хамгаалах жижиг төсөл боловсруулах/
10. Судалгаа: Үүнд:
 - Байгалийн нөөцийн суурь судалгаа
 - Эдийн засгийн тоо баримт
 - Зах зээлийн судалгаа хийж, дүгнэлт санал боловсруулах
 - Мэдээллийн сан байгуулах
 - Мэдээллээ түгээх

Чанартай үйлчилгээ үзүүлж, стандартыг мөрдөх замаар дэлхийн жишигт нийцсэн үйлчилгээг бий болгох стратеги:

- Жуулчны аюулгүй байдал, даатгал
- Ур чадварыг нэмэгдүүлэх
- Үйлчилгээний чанар
- Хувь хүний хандлага
- Цэвэр орчин
- Харилцаа холбоо авч чадах байдал /интернет, гар утас г.м/
- Жуулчин юу хүсэж байгааг мэдэх
- Чанартай бүтээгдэхүүн санал болгох

Тогтвортой байдал: Ирээдүйд тогтвортой хөгжүүлэх, хэрэглэхийн тулд нөөцөө хамгаалах, хадгалах, тогтвортой амьжиргааг дэмжих стратеги:

- Бүс нутгийн хэмжээний аялал жуулчлалын дагаж мөрдөх зөвлөмж журам боловсруулах

- Ховор ан амьтдын өлгий нутгийн бүсэд дагаж мөрдөх аялал жуулчлалын эко стандартыг боловсруулах
- Жуулчдын хувьд ёс зүйтэй байх /хариуцлагатай/ нөхцлийг бүрдүүлэх
- НИТАЖ (хөдөөний аялал жуулчлал)-ыг хөгжүүлэх, ядуурлыг бууруулах, амьжиргааны эх сурвалжыг бий болгох /туслах аж ахуй, гар урлал бэлэг дурсгал г.м./
- Иргэдийн боловсрол /Аялал жуулчлал, байгаль экологи, соёлын өвийн үнэ цэнэ/
- Төрийн болон хувийн олон нийтийн байгууллага, ард иргэдийн үүрэг, олон нийтийн оролцоог хангах

Аймгийн аялал жуулчлалын бүсүүдийн онцлогт нийцүүлэн бусдаас ялгагдах бүтээгдэхүүнийг зах зээлд санал болгохдоо дараах стратегийг баримтална.

Аялал жуулчлалын бүтээгдэхүүн гаргах үйл ажиллагаа:

- Зах зээлийн судалгаа хийх /гадаад, дотоод/
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа
- Бүтээгдэхүүнийхээ талаар мэдээлэл түгээх сурталчилах:
 1. Уриа, лого имидж бүрдүүлэх
 2. Танилцуулга, брошур гаргах
 3. Үзэсгэлэн яармагт оролцох
- Сувинер бий болгох /орон нутгийн онцлог төрхийг илэрхийлсэн тухайлбал: модон бал, балны тавиурыг давсаар хийх, ирвэсийн зураг бүхий эсгий, ирвэсийн зурагтай цамц, богино өмд, малгай хийх, эсгий шаахай, гэр, ан амьтдын дүрсийг давсаар урлах... г.м /

Аймгийн жуулчны мэдээллийн төвийг байгуулах нь :

1. Аймгийн аялалын үйл ажиллагааг сурталчилах
2. Аймгийн иргэд болон гадаад, дотоодын аялагчдыг мэдээллээр хангах
3. Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах
4. Жуулчны статистик тоо баримттай болох
5. Байгаль хамгаалах талаар мэдлэг түгээх, сурталчилах
6. Бие даан аялагчдад үйлчилгээ, бүтээгдэхүүнийг санал болгох, танилцуулах, мэдээлэл түгээх зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэнэ.

Аймгийн аялал жуулчлалын веб хуудсыг Өмнөговь аймгийн болон Соёл, спорт аялал жуулчлалын яам, Монголын аялал жуулчлалын холбоо, НИТАЖ-ын сүлжээ зэрэг Монголын аялал жуулчлалын салбарын гол веб сайтад холбох шаардлагатай юм.

Аймгийн аялал жуулчлалын имидж буюу “**ЛОГО**”-г бий болгох нь ихээхэн чухал. Имидж нь аймгийн аялал жуулчлалын өвөрмөц онцлогийг тодорхойлж бусдаас ялгарах бүтээгдэхүүн үйлчилгээний давуу талыг харуулна.

Имиджийг бүрдүүлэхдээ:

- Уламжлалт дүр төрхийг сэргээх
- Соёлын өвийг хадгалах
- Шинэ дүр төрхийг олж нээх гэсэн 3 хүчин зүйлийг нягт уялдуулах шаардлагатай.

Өмнөговь аймгийн үндсэн имидж :

1. Дэлхийд ховордсон ирвэсийн өлгий нутаг

2. Өмнөговь аймгийн 9 гайхамшиг
3. Түүх соёлын дурсгал
4. Эртний үлэг гүрвэлийн олдвор
5. Ховор шувууд
6. Байгалийн өвөрмөц тогтоц
7. Тэмээн аялал гэх мэт нэгэнт бүрдсэн давтагдашгүй онцлог, имидж дээр тулгуурлан, шинэ өнгө аясыг мэдрүүлсэн маркетингийн идэвхижүүлэлтийг бий болгох бололцоотой.

Өмнөговь аймгийн хувьд дараах эвент арга хэмжээг зохион байгуулах боломжтой:

- Ардын язгуур урлагийн бэсрэг наадам
- Монгол гэр барих, буулгах, үйлдвэрлэх ажиллагаа
- Нүүдэлчдийн хотхон байгуулах
- Овоо тахилгын бэсрэг наадам
- Тэмээний баяр
- Эсгий хийх, мал хяргах уралдаан
- Цагаан идээ боловсруулах үзүүлэх сургууль
- Тэмээн пөлогийн тэмцээн
- Тэмээн нүүдэл
- Ингэний айрагны баяр


8.2.2.3. Өмнөговь аймгийн аялал жуулчлалын салбарын хөгжлийн цаашдын хандлага

Өмнөговь аймгийн 2020 он хүртэлх жуулчдын тоог урьд жилүүдийн өсөлтийн хувь хэмжээ болон хүлээн авах зорилтод тулгуурлан 2 хувилбараар тооцоолон гаргалаа. Үүнд:

Хувилбар А: 2005 оноос хойшхи жуулчдын тооны өсөлт аажим байгаа учраас 2013-2016 оны өсөлтийг аажимаар нэмэгдэнэ гэж үзэж тооцоолоход 2020 он гэхэд 200,153,4 мян орчим жуулчид хүрэлцэн ирэх прогноз гарч байна. 2013 онд жуулчны бааз-22, амралт, сувилалын газар 5 нийт хүчин чадал нь 1662 ор бүхий ажиллаж байсан бол 2020 онд уг хүчин чадлыг 3,2 дахин нэмэгдүүлэн ажиллах шаардлагатай болно гэсэн тооцоо гарч байна/Хүснэгт 8.11, Зураг 8.10-д үзүүлэв/.

Хүснэгт №8.12. Жуулчны тоо: Хувилбар А

Жуулчны тоо	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Нийт
Нийт жуулчны тоо А	101,011,0	107,071,6	115,637,3	127,201,1	142,465,2	159,561,0	178,708,4	200,153,4	1,131,808,9
Өсөлтийн таамаглал	4,0%	6,0%	8,0%	10,0%	12,0%	12,0%	12,0%	12,0%	76,0%




Зураг №8.10. Жуулчдын өсөлтийн таамаглал/А хувилбар/

Хувилбар Б: 2016 онд 1 сая орон нутагт жуулчин хүлээн авах зорилгод хүрэхийн тулд 2013 оноос эхлэн аялал жуулчлалын салбарт шинэчлэл хийж, 2015, 2016 онуудад тус бүр 30%, 37% өсөлт бий болгож байж хүрэхээр байна. 2020 онд 321,126.4 жуулчин хүлээн авах прогноз гарч байгаа бөгөөд жуулчны үйлчилгээний байгууллагын хүчин чадлыг 2013 оныхоос 5,2 дахин нэмэгдүүлэх шаардлагатай болно/Хүснэгт 8.12, Зураг8.11-д үзүүлэв/.

Хүснэгт №8.13. Жуулчны тоо: Хувилбар Б

Жуулчны тоо	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Нийт I
Нийт жуулчны тоо А	101,982.2	114,220.1	148,486.1	204,081.6	228,571.4	256,000.0	286,720.0	321,126.4	1,661,187.9
Өсөлтийн таамаглал	12,0%	12,0%	30,%	37,4%	12,0%	12,0%	12,0%	12,0%	139,4%



Зураг №8.11. Жуулчдын өсөлтийн таамаглал/Б хувилбар/

8.2.2.4. Өмнөговь аймгийн аялал жуулчлалын хөгжүүлэх төлөвлөлт

Үндэслэл : Эх газрын говийн байгаль, ан амьтан, Дотоодын аялал жуулчлал, Соёлын аялал жуулчлал, Говийн бүсэд говийн унаган төрхөөрөө байгаа эмзэг онгон байгаль, ургамал, цаг уурын үзэгдэл, байгалийн элдэв сонин тогтоц, ховор ан амьтанг

ажиглах, Эртний шим ертөнцийн үлдэгдэл, палеонтологийн олдворыг үзүүлэх, Зөвшөөрөгдсөн зарим ан амьтанг агнуулах, Нар, элсний эмчилгээ засал, сувилгаа хийх, Тэмээний аж ахуйтай танилцуулах чиглэлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.

Богино хугацааны төлөвлөлт / 2014он-2016 он /

Зорилго: Аймгийн аялал жуулчлалын салбарын бүтэц, зохион байгуулалт, маркетингийг сайжруулах, жуулчны бааз, үйлчилгээний байгууллагуудын материаллаг хангамж, боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх,

- Жуулчдын баазын ойролцоо угсаатны зүйн нүүдэлчдийн зан үйлийг сонирхуулах, эмнэг сургах, эсгий хийх, цагаан идээ боловсруулах, тэмээн аялал хийх, үзэсгэлэн гаргах зэрэг арга хэмжээг өргөн зохион байгуулж, энэ чиглэлээр сурталчилгаа явуулах\
- Байгаль орчинд хоргүй, орчин үеийн эрчим хүчний эх үүсвэрээр жуулчны үйлчилгээний газруудыг хангах арга хэмжээ авах
- Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх үүднээс дотоодын амрагчдыг хүлээн авч байгаа айргийн сувилал, ахмадын сувилал, Тосон, Уртын амралт зэрэг амралт сувилалын газруудыг тохижуулж, хүчин чадлыг бүрэн ашиглах, нөхцөл бүрдүүлэх
- Дэмчигийн хийдэд соёлын болон шашны аялал,бясалгалын аялалыг зохион байгуулж тогтмолжуулах
- Түүх соёлын дурсгал болон байгалийн үзэсгэлэнт газруудыг бүртгэлжүүлж, аялал жуулчлал, үзмэрийн зориулалтын нөхцөл бүрдүүлэх
- Аялал жуулчлалын маршрутын авто замыг сайжруулан дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй нягт уялдуулан хэрэгжүүлэх
- Аялал жуулчлалын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн стандартыг хангасан зочид буудал, зоогийн газар, жуулчны бааз, эко гэр байгуулах иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих, боловсон хүчнийг мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах
- Жуулчны бааз, амралт сувиллын газрууд аймаг орон нутгийн удирдлагатай нягт хамтран ажилладаг нөхцөл бүрдүүлэх
- Аялал жуулчлалыг нөөцөд нь тулгуурлан бүс нутгаар хөгжүүлэхэд анхаарах Үүнд: Аялал рекреацийн чадавхи өндөртэй бүс нутаг (Сэврэй, Булган, Номгон, Ноён, Ханбогд) сумдын нутагт байгалийн болон тусгай сонирхолын аяллыг түлхүү хөгжүүлэх
- Аялал жуулчлалын бүсчлэн хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах
- Аялал жуулчлалын хөгжилд орон нутгийн засаг захиргааны байгууллагын санаачлага, дэмжлэгийг нэмэгдүүлэх
- Байгаль орчны хамгаалалт хяналтыг сайжруулах
- Даланзадгад сумын төвд аялал жуулчлалын мэдээллийн төвтэй болжүйл ажиллагааг идэвхижүүлэх

Дунд хугацааны төлөвлөлт/ 2017он -2021он /

Зорилго : Өмнөговь аймагт аялал жуулчлалыг эдийн засгийн бие даасан салбарын хэмжээнд хүргэж оновчтой хөгжүүлнэ.

- Говь Гурван Сайханы байгалийн цогцолборт газарт аялал жуулчлалын цогцолборыг загвар бааз болгон хөгжүүлэх
- Аймгийн болон говийн бүс нутгийн хэмжээнд зохион байгуулж буй аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг хувийн хэвшлийнхэнтэй хамтран зохион байгуулах
- Аялал жуулчлалын чиглэлээр гадаадын сонирхогч компаны хөрөнгө оруулалтыг татан оруулах арга хэмжээг зохион байгуулах
- Аялал жуулчлалын дотоодын болон олон улсын сүлжээнд мэдээллийн сүлжээнд оруулж, зах зээлийн сурталчилгааг оновчтой хийх
- Гадаад, дотоодын аялал жуулчлалын үзэсгэлэн, яармагт оролцох, аймаг орон нутгаа сурталчлах ажлыг идэвхижүүлэх
- Аялал жуулчлалын бааз ангийн отог зоогийн газрын менежментийг сайжруулах зорилгоор ажиллагсдыг төрөлжсөн сургалтанд хамруулан мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх сургалтын төвийг Даланзадгад хотод байгуулах
- Булган сумыг түшиглэн Үлэг гүрвэлийн хүрээлэн байгуулах
- Монголын говийн онгон дагшин байгалиа ашиглан дархан цаазат газрын бүс, говь өвөрмөц байдлыг тусгасан маршрут, археологи палеонтологийн олон услын аялал жуулчлалын бүс аяллын бүс, говийн элс, дэлхийн энергийн төв, нарны эмчилгээ сувилгааны дотоодын аялагч амрагчдад зориулсан бүсүүдээр төрөлжүүлэн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх,
- Аялал жуулчлалыг нөөцөд нь тулгуурлан бүс нутгаар хөгжүүлэхэд анхаарах Үүнд: Аялал рекреацийн чадавхиар дунд бүс нутаг (Гурвантэс, Баяндалай, Хүрмэн, Цогт-Овоо, Баян-овоо) сумдын нутагт Есөн гайхамшигийн” аялал, Хил орчмын аялал, тусгай сонирхолын аяллын төрөл болох палеонтологийн аялал, шувуу ажиглах аялал, агнуурын аялал, шувуу ажиглах аяллыг түлхүү хөгжүүлэх

Урт хугацааны төлөвлөлт/ 2022он -2030 он /

Зорилго : Аялал жуулчлалын салбарыг аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох.

- Дотоод гадаадын жуулчид, анчдыг хүлээн авах олон улсын зэрэглэлийн зочид буудал, жуулчны бааз, дэн буудлын сүлжээ байгуулах
- Хөрш улс орнуудтай хил дамнасан олон улсын аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Аялал жуулчлалд хөрөнгө оруулах дотоод гадаадын хөрөнгө оруулагчдыг хөхүүлэн дэмжих, жуулчдад хандсан сурталчилгааг өргөтгөх
- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан аялал жуулчлалаас олох орлогоос орон нутгийн ард иргэдийн амьжиргааг сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээг авах

- Аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулах, Даланзадгадын нисэх онгоцны буудлын үйлчилгээг сайжруулж олон улсын стандартын шаардлага хангасан үйлчилгээг үзүүлэх
- Ногоон эдийн засаг, ногоон аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалаас байгаль орчинд үзүүж буй сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг авах
- Ёлын амны орчимд байгалийн аялал жуулчлалын цогцолбор байгуулан аялал жуулчлалыг аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

9.1. Уул уурхайн газрын ашиглалтын өнөөгийн байдал, нөөцийн үнэлгээ

Өмнөговь аймаг нь манай улсын ашигт малтмалын нөөц баялгаар хамгийн баян, ашигт малтмалын олборлох, боловсруулах үйлдвэр хөгжүүлэх хамгийн ирээдүйтэй аймгийн нэг юм. Тус аймгийн нутаг дэвсгэрт 2014 оны 10-р сарын 28-ны байдлаар хайгуулын 170, ашиглалтын 74 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг авч үзвэл нүүрсний 40, алтны 15, холимог металлын 5, алт, зэсийн 2, манганы 2, цайрын 2, давсны 2, төмрийн хүдрийн 1, жоншны 1, агальметолитын 1, барилгын материалын 1 тусгай зөвшөөрөл тус тус хүчин төгөлдөр байна. Хайгуулын тусгай зөвшөөрлийн нийт талбайн хэмжээ 3.3 орчим сая Га байна. Харин ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ 500 гаруй мянган Га байна. Тус аймгийн нутаг дэвсгэрт улсын төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтаар явуулсан геологийн судалгаа, эрэл үнэлгээ, хайгуулын ажлын үр дүнгээр 36 нэр төрлийн ашигт малтмалын 256 орд илрэл тогтоогдсон.

Мөн газрын тосны 46621 км² талбай бүхий Борзон ҮП, 13991 км² талбай бүхий Галба XI, 45080 км² талбай бүхий Номгон IX талбайг тус тус ялган газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулан ажиллаж байна. Галба XI талбай дээр явуулсан өрөмдлөг болон судалгааны ажлын үр дүнгээр одоо нөөц нь тогтоогдоод байгаа Дорнод аймгийн Матад сумын нутагт орших Тамсагийн талбайн нөөцөөс багагүй нөөцтэй байж болох магадлалтай нь тогтоогдоод байна. Мөн Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу нүүрсний давхаргын метан хий, шатдаг занар зэрэг газрын тосны уламжлалт бус эх үүсвэрийн эрэл, хайгуулын ажлыг бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсны үндсэн дээр явуулах боломжтой.

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт УИХ-аас тогтоосон стратегийн ач холбогдол бүхий 15 ордоос 3 нь буюу Оюу толгойн зэс, алтны бүлэг орд, Тавантолгойн нүүрсний бүлэг орд, Нарийн сухайтын нүүрсний орд оршдог. Мөн сайн чанарын Баруун наран зэрэг нүүрсний ордууд тус аймгийн нутагт байдаг.

Дэд бүтцийн өнөөгийн байдал

Автозам. Улаанбаатараас Мандалговь хотоор дамжуулан Даланзадгад хүртэл хатуу хучилттай автозамаар холбогдсон. Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн нүүрсний ордоос Ханбогд сумын нутагт орших Гашуунсухайтын хилийн боомт хүртэл мөн хатуу хучилттай автозамаар холбогдсон. Гурвантэс сумын нутагт орших Нарийнсухайтын нүүрсний ордоос тус сумын нутагт орших Шивээ хүрэнгийн хилийн боомт хүртэл 45 км өндөр даацын хатуу хучилттай замаар холбогдсон.

Агаарын зам. Улаанбаатараас Өмнөговь аймгийн төв Даланзадгад, Ханбогд сумын Ханбумбат, Цогтцэций сумын төв хүртэл агаарын шугамаар холбогдож Аэро Монголиа, Хүннү эйр компаниуд нислэг үйлддэг.

Цахилгаан хангамж. Мандалговь-Даланзадгад-Цогтцэций сумын хооронд 110 кВ-ын агаарын шугамаар холбогдсон. Харин Оюу толгойн орд хүртэл БНХАУ-ын ӨМӨЗО-

ны Баяннуур аймгаас 110 кВ-ын агаарын шугамаар холбож Оюу толгойн уулын баяжуулах үйлдвэрийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэсэн. Мөн Оюу толгойгоос Ханбогд сум, Баян-Овоо сум хүртэл 35 кВ-ын агаарын шугам татаж цахилгаан хангамжийн эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэсэн. Нарийнсухайтын нүүрсний орд руу БНХАУ-аас 35 кВ-ын агаарын шугам татаж тус ордод олборлолт явуулдаг Монголын алт (МАК) ХХК, Чинхуа-МАК-Нарийнсухайт ХХК, Соус Гоби Сэндс ХХК болон Гурвантэс сум, Ноён сумын цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэсэн. Өмнөговь аймгийн бусад сумдын төвийг төвийн эрчим хүчний системийн эх үүсвэртэй холбосон.

9.2. Уул уурхайн газрын ашиглалтын хэтийн төлөвлөгөө

“Оюу Толгой” ХХК

Оюу Толгойн зэс, алтны бүлэг орд нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрладаг. Нийслэл Улаанбаатар хотоос урагш 650 км, БНХАУ-ын хилээс хойш 70 км орчим зайд оршдог. Оюу Толгойн бүлэг орд нь тус компаний эзэмшдэг ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай (6709А), Онтрэ ХХК-ийн хамтарсан ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Шивээ Толгой (15226А) ба Жавхлантын (15225А) талбайнуудыг дамнан оршдог. Оюу Толгой нь дэлхий дээр нээгдээд буй порфирын төрлийн зэс-алтны томоохон ордын нэг болно.

Монгол Улсын Засгийн Газар, Айвенхоу Майнз түүний стратегийн түнш болох Рио Тинто компанийн хооронд 2009 оны 10 дугаар сард байгуулагдсан Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу Оюу Толгой ХХК-ийн 66%-ийг Айвенхоу Майнз болон хөрөнгө оруулагчид, 34%-ийг Монгол Улсын Засгийн газар тус тус эзэмшдэг.

Оюу толгойн бүлэг ордыг түшиглүүлэн ил уурхай, далд уурхай, баяжуулах үйлдвэр, тосгон, дулааны станц, цахилгаан хангамжийн сүлжээ, баяжмал ачиж тээвэрлэх байгууламж, үйлдвэрийн усан хангамжийн сүлжээ, баяжуулах үйлдвэрийн хагядлын байгууламж, машин механизмын засварын газар, тэсрэх материалын агуулах, үйлдвэрийн цогцолбор болон бусад хангамж, ложистикийн байгууламжууд баригдах юм. Оюу толгойн уулын баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын үед 10 гаруй мянган хүн, төсөл бүрэн хүчин чадлаараа ажиллах үед 3500 орчим хүн ажиллах юм. Оюу толгойн үйлдвэрийн суурьшлын бүсийг Ханбогд сумыг түшиглүүлэн байгуулах нь зүйтэй гэж үзэн суурьшлын бүсийн судалгааны ажлууд хийгдэж байна.

Ил уурхайн хөрс хуулалтын ажлыг 2011 оны 7 сараас эхлүүлж ил уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна. Оюу Толгой төслийн хүдэр баяжуулах үйлдвэрийн ажил болон дэд бүтцийн ажлууд бүрэн хийгдэж 2013 онд жилд 36 сая тонн хүдэр болосруулах хүчин чадалтайгаар бүрэн ашиглалтанд орсон. Ингэснээр тус үйлдвэрээс жилд 700 мянган тонн зэс, алт, мөнгө агуулсан баяжмал үйлдвэрлэж экспортлох боломж бүрдэж байна. Оюу Толгой ордыг далд аргаар ашиглахаар бэлтгэл ажил хийгдэж байгаа бөгөөд нийт далд уурхайн бэлтгэл малталт 3804.4 метр хийсэн. Далд уурхайн санхүүжилтийн асуудлыг шийдэгдээгүйгээс шалтгаалан 2014 оны эцэс хүртэл зогсолтын байдалтай байна.

“Тавантолгой” ХК, “Энержи Ресурс” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК

Тавантолгойн коксжих нүүрсний бүлэг орд нь Улаанбаатар хотоос өмнө зүгт 500 км-т орших бөгөөд Даланзадгад хотоос зүүн тийш 100 км-т, хамгийн ойролцоо орших төмөр замын Чойр өртөөнөөс баруун урагш 438 км-ийн зайд, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт оршиж байна. Тавантолгойн ордын коксжих нүүрсний илчлэг 6208 ккал/кг, хүхрийн агуулга 0.31-0.7%, чийглэг 6.7-8.7%, үнслэг 26-44% байна.

Тус бүлэг ордод орон нутгийн төрийн өмчит “Тавантолгой” ХК, хувийн хэвшлийн “Энержи Ресурс” ХХК, төрийн 100%-ийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХХК зэрэг компаниуд үйл ажиллагаа явуулдаг. “Тавантолгой” ХК нь жилд 2.0 сая тонн, “Энержи Ресурс” ХХК нь жилд 15 сая тонн, “Эрдэнэс Тавантолгой” ХХК нь жилд 20 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай. “Тавантолгой” ХК нь нүүрсээ боловсруулалтгүйгээр БНХАУ-д экспортлодог бол “Энержи Ресурс” ХХК нь жилд 15 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай 3 блокыг барьж байгуулан ашиглалтад оруулсан. Харин “Эрдэнэс Тавантолгой” ХХК нь жилд 20 сая тонн нүүрс баяжуулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулж батлуулсан боловч үйлдвэрийг барьж байгуулаагүй байна.

“Тавантолгой” ХК нь MV-000287, MV-011943 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд ил аргаар нүүрс олборлолтын үйл ажиллагаа явуулж байна. Тус компани 2013 онд 47582.9 мян.тн нүүрс олборлон, экспортолсон. Тус компани нь төвлөрсөн төлөвлөгөөт нийгмийн үеэс орон нутгийн нүүрсний хэрэгцээг хангаж ирсэн.

“Энержи Ресурс” ХХК нь “Ухаа худаг” төслийн хүрээнд 2962 га талбай бүхий MV-011952 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ордод ил аргаар нүүрс олборлолтын үйл ажиллагаа явуулж байна. Тус компани нь 2013 онд 9177.0 мян.тн нүүрс олборлосон. Тус Энержи Ресурс ХХК нь Цогтцэций сумын төвд ажилчдын орон сууцны Цэций хорооллыг байгуулж өөрийн ажиллагсдыг төдийгүй сумын зарим оршин суугчдыг орон сууцаар хангаж байна. Мөн тус компанийн хөрөнгө оруулалтаар Цогтцэций сумын төвд сургууль байгуулсан. Баяжуулах үйлдвэрийн технологийн усан хангамжийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор Наймдайн хөндийгөөс 45 км шугам хоолой татсан. Ингэснээр үйлдвэрийн төдийгүй Цогтцэций сумын хэрэглэгчдийг цэвэр усны эх үүсвэрээр хангаж байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХХК нь MV-011943, MV-011953, MV-011954, MV-011955, MV-011956 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайнуудад ил аргаар нүүрс олборлолтын үйл ажиллагаа явуулж байна. Тус компани 2013 онд Цанхийн баруун хэсгээс 2564.5 мян.тн нүүрс олборлосон бол Цанхийн зүүн хэсгээс 2736.2 мян.тн нүүрс олборлосон байна. Тус компани нь төслийн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байгаа бөгөөд дээр дурдсан дэд бүтцийн асуудал шийдэгдсэн тохиолдолд төслийн хүчин чадлаараа ажиллах боломж бүрдэнэ. Тус компани нь БНСУ-ын “Корей Газ” корпораттай гэрээ байгуулан Тавантолгойн ордын нүүрсний давхаргын метан хийн судалгааны талаар хамтран ажиллаж байна. Метан хийн ихээхэн хэмжээний нөөц илэрсэн тохиолдолд хийн хоолой татаж Улаанбаатар хотыг хийгээр хангах боломж бүрдэх юм.

Дэд бүтцийн цаашдын төлөвлөлт хэсэгт дурдсанчлан тус ордыг түшиглүүлэн 450 мВт-ын цахилгаан станц баригдана. Мөн БНХАУ-тай нарийн царигийн төмөр замаар, Монгол Улсын төмөр замын зангилаа Сайншанд боомтой өргөн царигийн төмөр замаар холбогдох юм. Ингэснээр сайн чанарын нүүрсийг зөвхөн БНХАУ-д бус Европын орнууд түүнчлэн Япон, БНСУ-д экспортлох боломж бүрдэнэ.

“Монголын Алт”(МАК) ХХК, “Чин Хуа-Мак-Нарийнсухайт” ХХК, “Саусгоби Сэндс” ХХК

Нарийн сухайтын чулуун нүүрсний орд нь Улаанбаатар хотоос 900 км, Монгол улсын хилийн Шивээхүрэн боомтоос 50 км-ийн зайд, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт байрладаг. Нүүрсний чийг 7.32%, үнслэг 13.96%, дэгдэмхий 30.2%, хүхрийн агуулга 1.84%, 6750 ккал/кг илчлэгтэй. Тус нүүрсний ордод “Монголын Алт”(МАК) ХХК, “Чин Хуа-Мак-Нарийнсухайт” ХХК, “Саусгоби Сэндс” ХХК зэрэг компаниуд үйл ажиллагаа явуулж байна.

“Монголын Алт”(МАК) ХХК нь Нарийн сухайтын ордод ил уурхайн аргаар жилд 3 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай бөгөөд 2013 онд 3210.0 мян.тн нүүрс экспортолсон.

Хятадын зах зээлд Нарийн Сухайтын нүүрсийг таниулах, уг орд газарт дэд бүтцийн орчныг бүрдүүлэх зорилгоор 2002 онд “Монголын Алт” (МАК) ХХК БНХАУ-ын ӨМӨЗО-ны Чин Хуа корпорациатай хамтран Монгол-Хятадын хамтарсан “Чинхуа-МАК-Нарийн Сухайт” ХХК-ийг үүсгэн байгуулсан. “Чинхуа-МАК-Нарийн Сухайт” ХХК нь Монгол Улсын ЗГ-тай Тогтвортой байдлын гэрээ байгуулан Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дахь Нарийн Сухайтын орд газрын нүүрсийг экспортлох анхны гарцыг нээсэн. “Чинхуа-МАК-Нарийн Сухайт” ХХК-ийн нүүрсний уурхайн төслийн хүчин чадал 1500 мян.тн бөгөөд 2013 онд 674.45 мян.тн нүүрс олборлон, экспортолсон байна.

“Саусгоби Сэндс” ХХК нь Канадын 100%-ийн хөрөнгө оруулалттай компани бөгөөд тус Нарийн сухайтын ордыг Овоот толгойн хэсэгт олборлолтын үйл ажиллагаа явуулдаг. Овоот (Нарийн сухайт)-ын ордын ил уурхайгаар ашиглах нүүрсний нөөцийг “Баруун” хэсэгт 39.5 сая.тн, “Зүүн-Өмнөд” хэсэгт нь 19.11 сая.тн-оор баталсан. Тус компани 2013 онд 3057.2 олборлосон байна. “Саусгоби Сэндс” ХХК нь тус ордыг түшиглүүлэн хуурай баяжуулах үйлдвэрийг байгуулан ашиглалтад оруулаад байна.

Мөн тус бүлэг ордын хэсэгт “Өсөх Зоос” ХХК 2014 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Ингэснээр тус бүлэг ордоос жилд ойролцоогоор 10 орчим сая тонн нүүрс олборлож БНХАУ-д экспортлох боломжтой.

Нэгэнт дээр дурдсанчлан Шивээ хүрэнгийн боомтоос тус орд хүртэл сайн чанарын автозамтай болсон тул нүүрсний олборлолт, экспорт нэмэгдэх боломжтой.

“Хангад Эксплорейшн” ХХК

Тус компанийн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг Баруун Нарангийн чулуун нүүрсний орд нь Өмнөговь аймгийн Ханхонгор, Цогтцэций сумдын нутагт, аймгийн төв Даланзадгад хотоос зүүн зүгт 61км, нийслэл Улаанбаатар хотоос өмнө зүгт 500км зайд байрладаг.

MV-14493 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 4481,82 га талбайд 2013 онд 494.3 мянган тонн нүүрс олборлосон байна. Жилд 10 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай ил уурхайн техник-эдийн засгийн үндэслэлийг 2010 батлуулсан. Ашиглалтын нийт хугацаа 25 жил байна.

Уул уурхайн бүс нутгийн дэд бүтцийн цаашдын төлөвлөлт

Цахилгаан хангамж. Тавантолгойн ордыг түшиглүүлэн 450 мВт-ын хүчин чадалтай цахилгаан станцыг барьж Тавантолгой, Оюу толгойн ордыг цахилгаанаар хангахаар төлөвлөн ажиллаж байна. Ингэснээр дотоодын цахилгааны хэрэгцээг хангахаас гадна БНХАУ руу цахилгаан экспортлох боломж бүрдэх юм.

Төмөр зам. УИХ-аас баталсан “Төмөр замын талаар төрөөс баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолыг саяхан баталсан. Уг тогтоолд зааснаар Тавантолгой-Гашуунсухайтын хооронд нарийн царигийн төмөр зам, Тавантолгойгоос Сайншанд хүртэл өргөн царигийн төмөр зам тавихаар шийдвэрлэсэн.

9.3. Орд газруудын ашиглалтын байдал

Хүснэгт № 9.1. Нүүрсний орд газруудын судалгаа, ашиглалтын байдал

Д/д	Нүүрсний уурхай, ордын нэр	Аж ахуйн нэгж, компанийн нэр	Байршил	Уурхайн ундны усан хангамж	Цахилгаан хангамж	Нүүрс буталж ангилах, баяжуулах, угаах үйлдвэр	Дэд бүтэц
1	Ногоон хошуу-Баруун Ноён уул-1	"Цагаан өвөлжөө" ХХК	Өмнөговь, Ноён, Зүүн урагш 25км	Гүний худаг-Кемпийн орчинд	Дизель: Atlas Copco Q1X165, 120 кВт, Ingersoll Rand фирмийн 6 ширхэг хөдөлгөөнт дизель гэрэлтүүлэг		Сул хөгжсөн. Ноён сум, аймгийн төвтэй шороон замаар холбогддог. Сумын төвд Мобиком, Скайтел, GМобайле утсан холбоо, интернеттэй.
2	Овоот толгой	"Саусгоби Сэндс" ХХК	Өмнөговь, Гурвантэс-Зүүн урагш 38км,	Тосгон дахь гүний худаг, 2012 оны хайгуулаар илэрсэн гүний худгаас.	Сэхэ-Шивээхүрэн-Нарийнсухайтын 50км 35кВ ЦДАШ-тай. Нөөцөнд 120кВт, 21.6кВт, 127кВт дизель	Нүүрс буталж ангилах үйлдвэр-9.0сая тонн/жил, 50мм-ээс доош хэмжээтэй буталж ангилах.	Нисэх онгоцны буудалтай.
3	Баруун Наран	"Хангад Эксплорэйшн" ХХК	Өмнөговь, Ханхонгор, Даланзадгадаас зүүн зүгт 61км, Ухаа худагаас баруун тийш 31 км	Ажилчид Ухаа худагт байрлаж ээлжээр уурхайд ажиллана.	Дизель-D905-E28gl, Night-Lite, станц		31 км хатуу хучилттай автозам Ухаа худаг хүртэл тавигдсан.

4	Ухаа Худаг	"Энержи Ресурс" ХХК	Өмнөговь, Цогтцэций		18МВт ЦС, 1x1.2МВт-дизель, 4x2МВт-дизель, 3x0.5МВт дизель, Зөөврийн дизель, бусад газрууд руу 110/35/10кВ-ын дэд станцаар дамжуулан түгээж байна.	Жилд тус бүр 5 сая тонн нүүрс баяжуулах 3 модуль ашиглалтанд орсон.	УБ-Цогтцэций шууд нислэгтэй, УБ Цогтцэций шороон зам,
5	Хүрэншанд	Өсөх зоос ХХК	Өмнөговь, Гурвантэс	Уурхайн талбайд ойр байрлах гүний худагаас	Дизель цахилгаан үүсгүүр, 32, 36, 108.8, 144, 59.4, 64, 39.5, 40 кВт		Сум аймгийн төвтэй шороон замаар холбогдоно.
6	Цант-Уул	"Мөнх Ноён Суврага" ХХК	Өмнөговь, Баян-Овоо	2, 6, 9-р гүний худаг	Дизель станц: 327кВт, 220кВт, 116кВт, 70кВт, 56кВт, 40кВт		Сумын төв нь эрчим хүчний системд холбогдсон, аймаг, сум, багтай шороон замаар холбогддог
7	Нарийн сухайт-Бага Овоо Хүрэн толгой	"Чин Хуа МАК Нарийн Сухайт" ХХК	Өмнөговь, Гурвантэс		50км, 35кВ ЦДАШ БНХАУ		Хил хүртэл 55 км засмал зам, байнгын эрчим хүчний эх үүсвэртэй
8	Нарийн сухайт, Төв хэсэг	"Монголын алт" (МАК) ХХК	Өмнөговь, Гурвантэс	Уурхай дээрх гүний 3 худгаас хангадаг.	БНХАУ-ын Далайн хөвөө боомтоос "Чинхуа МАК Нарийн сухайт" ХХК 132км урттай 35кВ-ын ЦДАШ татаж 35/6кВ-ын 6300кВА-ийн дэд станцаас хангаж байгаа		Нисэх онгоцны буудал-2006, Хил-уурхай хатуу хучилттай авто зам, БНХАУ-аас ЦЭХ
9	Таван толгой Цанхийн зүүн	"Эрдэнэс Тавантолгой" ХК	Өмнөговь, Цогтцэций	Уурхайн талбайн зүүн хойно байрлах гүний худаг-4	2013 онд ТЭХС-д холбогдсон. 60-16 кВт-ын 6 дизель, 20кВт-ын 3 дизель-гэрэлтүүлэг	НБУУ-ийн ТЭЗҮ-20 сая.тн/жил-2013-06-13 батлагдсан.	Аймаг, сум, нийслэл хоттой шороон замаар холбогдсон. ТЭХС-д холбогдсон.
10	Таван толгой-Цанхийн баруун хэсэг	"Эрдэнэс Тавантолгой" ХК	Өмнөговь, Цогтцэций	9км зайд гүний худаг, Балгасын нуурын гүний цооног	Дизель генератор 2-3 ширхэг, Мандалговь-Цогтцэцийн 220кВ ЦДАШ-аас Тавантолгойн 220/110/35/10кВ-ын дэд станцаар	НБУУ-ийн ТЭЗҮ-20 сая.тн/жил-2013-06-13 батлагдсан.	Мандалговь-Цогтцэцийн 220кВ ЦДАШ-аас Тавантолгойн 220/110/35/10кВ-ын дэд станц

					110кВ-ын 11км ЦДАШ-аар. Цаашид шинээр баригдах 300 МВт-ын ДЦС-аас		
11	Зангат уулын орд, Баян ундарга-уурхай	"Жавхлант орд" ХХК	Өмнөговь, Гурвантэс, Зүүн хойш 25 км-т	Гүний 1 худаг гаргана. 334 хүн, хоногт 150л/хүн	AKSA AC-825 дизель: 540 кВт хэрэглээ байна.		Мобиком-2006-11, ӨМӨЗО-ны хөрш аймгаас өндөр хүчдэлийн шугам, аймаг сумын төвтэй шороон замаар холбогдсон.
12	Таван толгой	"Таван толгой" ХК	Өмнөговь, Цогтцэций-Баруун урагш 12 км	Хотхон дотор гүний 3 худаг	6 Дизель станц, Цогтцэций-Уурхайн тосгон 10кВ-ын ЦДАШ, дэд станц ТМ400 10/0.4		Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээгээр Төвийн ЭХ-д холбогдсон. Хатуу хучилттай зам тавигдаж байна. Сайншанд өртөө хүртэл 640км шороон зам
13	Баруун Ноён уул	Хур Эрдэнэ Баялаг ХХК	Өмнөговь, Ноён	Ноён сумын төвийн эх үүсвэрээс	БНХАУ-аас Ноён сумын төв рүү ирсэн 35кВ-ын ЦДАШ-аас 21 км	БУ-т нүүрсийг боловсруулж баяжуулна.	Аймаг, сумын төвтэй шороон замаар холбогдоно.

Хүснэгт № 9.2. Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид, ашиглалтын байдал

д/д	Жагсаалт	Сум	Талбайн нэр	Эзэмшигч	Нийт хэмжээ (га)	Анхны нөөцийн тухай мэдээлэл	ТЭЗҮ	Ашигт малтмал
1	MV-000291	Гурвантэс	Дундгол	Зүрийн булан	35.33	ШУТЗ-ын 1962.03.20-ны протокол		Давс
2	MV-001497	Гурвантэс	Дундгол	Сондог	28.5	ГУГ-ын ШУТЗ-ийн 1962.03.20-ны хурлаар нөөцийг баталсан		Давс
3	MV-005464	Мандал-Овоо	Овоот-1	Олон-Овоот гоулд	81.93	ЭБМЗ-ийн 2005-02-04 № 03-02 тоот протокол	АМГ-ын даргын 2010-08-14 № 354 ЭБМЗ-ийн 2010-07-10 № 13-02	Алт
4	MV-006708	Ханбогд	Манахт	Оюу Толгой	4533.32	АМГ-ын даргын 2013.05.06-ний №183 тушаал, ЭБМЗ-ийн ХХ-06-11 дүгнэлт, "Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Манахтын барилгын чулууны орд	2013.06.27	дайрга
5	MV-006709	Ханбогд	Оюу толгой	Оюу Толгой	8489.92	АМГТХЭГ даргын 2007-07-10ны №245 тушаал, ЭБМЗ-ийн 2007-07-03-ны №15-01 протоколоор Оюу толгойн	2008 хайрга, 2009 элс, 2010.03.25	Холимог металл

						зэс алтны нөөц, 2008.05.13-ний №207 Дугатын Хярын гранодиритын ордын нөөц, 2008 онд Халивын элсний ордын нөөц бүртгэгдсэн байна.	2014.04.16 14-07-06 шавар	
6	MV-006710	Ханбогд	Хөх хад	Оюу Толгой	1762.7	АМГТХЭГ 2007-07-10 №245, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Довын элсний орд, АМГ-ын даргын 2013.04.16-ны 143 тоот тушаал, ЭБМЗ-ийн 2013.03.15-ны ХХ-05-09 тоот протокол	2009	Холимог металл
7	MV-009852	Номгон	Хар толгой	Дун-Юань	53.13	1956.11.05-ны Совмонголметалл геологийн экспедицийн ШУТЗ-ын хурлаар нөөц баталжээ. Хар толгойн полиметалын орд 2009-03-26 АМГ№73, ЭБМЗ 01/03 Мо-В-4097.97 тн/178.7 тн, С-16033.44тн/699.6 тн	2/5/2010	Хар тугалга
8	MV-010511	Баяндалай	Нураг уул	Ирмүүнз ээрд	1189.19	АМГ-ын даргын 2012 оны №534 тушаал "Өмнөговь аймгийн Баяндалай сумын нутаг дахь Нураг уулын алтны үндсэн ордод 2002-2011 онд гүйцэтгэсэн хайгуулын ажил		Алт
9	MV-010666	Баяндалай	Хүрмэн-2	Монгол манганей з натурал ресурс	313.18	АМГ-ын даргын №198 тушаал, ЭБМЗ-ийн 2011.04.15-ний ХХ-07-02 дүгнэлт, "Өмнөговь аймгийн Баяндалай сумын нутагт орших хүрмэн-II манганы ордын нарийвчилсан хайгуулын ажил		Манган
10	MV-013852	Гурвантэс	Зүүн хоолой	Трейжа маунтайн интернэ шнл майнинг	335.02	АМГТХЭГ 2008-07-17 №29-01 АМГ ЭБМЗ 2009-04-31 № 18	2008, 2010	баргилт
11	MV-014917	Гурвантэс	Торомхон	Агммайн инг	6470.02	ЭБМЗ-ийн 2009.05.15-ны 06-05 тоот дүгнэлт, "Торомхон" -ны алтны үндсэн орд. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Алагшандын алтны үндсэн ордод АМГ-ын даргын 20/8/2015 №н-152, ЭБМЗ-ийн 09/7/2014 №ХХ-12-07/01 тоот дүгнэлт		Алт
12	MV-014937	Мандал-Овоо	Баян төмөртэй	Рэмет	506.3	АМГ-ын даргын 2012-05-16 № 260, ЭБМЗ-ийн 2012-05-08 № 08-01. Фонд № 6710		Төмөр
13	MV-015032	Номгон	Хар толгой	Дун-Юань	541.52	АМГ-ын даргын 2009.06.17-ны 218 тоот тушаал, ЭБМЗ-ийн	2010.02.05	Хар тугалга

						2009.05.26-ны 09-04 тоот дүгнэлт, "Хар толгой"-н хар тугалганы орд. Нөөцийн блок уг талбайд багтаж байгааг тодруулав.		
14	MV-015033	Номгон	Хар толгой-1	Дун-Юань	424.89	АМГ-ын даргын 2009.06.17-ны 218 тоот тушаал, ЭБМЗ-ийн 2009.05.26-ны 09-04 тоот дүгнэлт, "Хар толгой"-н хар тугалганы орд. Нөөцийн блок уг талбайд багтаж байгааг тодруулав.	2010.02.05	Хар тугалга
15	MV-015219	Гурвантэс	Ягаан худгийн ам	Ивээл-Өлзий	279.21	АМГ-ын даргын 2009.09.07-ны 395 тоот тушаал, ЭБМЗ-ийн 2009.07.08-ны 17-08 тоот дүгнэлт, "Ягаан худаг"-н агальматолит, баритын орд. Агальматолитийн хүдрийн нийт нөөц 3200 тн, В-2164.9 тн, 23.2%-н агуулгатай, С-1034.3 тн, 18.6%-н агуулгатай, Баритийн хүдрийн нөөц С-39022.5 тн, 23.73%-н агуулгатай.	2010.05.27	Агальме толит
16	MV-015225	Ханбогд	Жавхлант	ОНТРЭ	20327.4	ЭБЭХ-ний сайдын 2009 оны 7-р сарын 10-ны өдрийн 167 дугаар тушаал, ЭБМЗ-ийн 2009 оны 7-р сарын 1-ний хуралдааны 15-01 дүгнэлтийн хавсралт 01, Херуга орд	2009	Алт, Зэс
17	MV-015226	Ханбогд	Шивээ толгой	ОНТРЭ	54652.58	ЭБЭХ-ний сайдын 2009 оны 7-р сарын 10-ны өдрийн 167 дугаар тушаал, ЭБМЗ-ийн 2009 оны 7-р сарын 1-ний хуралдааны 15-01 дүгнэлтийн хавсралт 01, Хойд Хюго ордын үргэлжлэл	2009	Алт, Зэс
18	MV-015273	Мандал-Овоо	Олон овоот	Олон-Овоот гоулд	85.39	219А тусгай зөвшөөрөл байсан. Нөхөн олгосон. ЭБМЗ-ийн 2005-02-04 № 03-02 тоот протокол	2003, 2005	Алт
19	MV-015274	Мандал-Овоо	Овоот-1	Олон-Овоот гоулд	940.35	5073А тоот тусгай зөвшөөрөл байсан. Нөхөн олгогдсон. ЭБМЗ-ийн 2005-02-04 № 03-02 тоот протокол		Алт
20	MV-015275	Мандал-Овоо	Гоёот улаан	Олон-Овоот гоулд	256.82	13649А тоот тусгай зөвшөөрөл байсан. Нөхөн олгогдсон. АМГ-ын даргын 2010-07-05 264 ЭБМЗ-ийн 2010-06-18 08-07 Фонд № 6206		Алт
21	MV-015282	Мандал-Овоо	Мөргөцөг уул	Олон-Овоот гоулд	483.57	АМГ-ын даргын 2013-12-09 477 ЭМБЗ-ийн 2013-06-19 ХХ-14-12 Фонд № 7258		Алт

22	MV-015283	Мандал-Овоо	Бороодон	Олон-Овоот гоулд	203.18	АМГ-ын даргын 2013-12-09 477 ЭМБЗ-ийн 2013-06-19 ХХ-14-12 Фонд № 7258		Алт
23	MV-015631	Ханхонгор	Хотгор	Хотгор минералс	2036.63	АМГ-ын даргын 2010.01.18-ны №26 тушаал, ЭБМЗ-ийн 2009.12.29-ны №30-02 дүгнэлт, Өмнөговь аймгийн Ханхонгор, цогт овоо сумын нутагт орших Хотгорын ховор элементийн орд, үр ашигтай анхдагч хүдрийн нөөц (В) нөөцийг 24779.89 мян.тн, металлын нөөц 312.23мян.тн исэлдсэн хүдрийн бодитой нөөц (В) 2083.47 мян.тн, металл 26.46 мян.тн, анхдагч хүдрийн нөөц (С) нөөцийг 12452.86 мян.тн, металлын нөөц 143.21мян.тн исэлдсэн хүдрийн боломжтой нөөц (С) 434.87 мян.тн, металл 4.83 мян.тн	2011/04/21 04-01	Полимет алл
24	MV-016759	Мандал-Овоо	Хоримт	Олон-Овоот гоулд	450.73	АМГ -ын даргын 2010.07.05-ны №264 тушаал, ЭБМЗ-ийн 2010.06.18-ны ХХ-08-07 дүгнэлт, Бурхан дэл нэртэй талбайн алтны үндсэн орд, В зэргийн 2380кг, С зэргийн 2396.8 кг	АМГ-ын даргын 2012-08-24 №487 ЭБМЗ-ийн 2012-07-02 № 05-06 Фонд № 6846	Алт
25	MV-017014	Ноён	Халбас уул	Азиагоул д монголиа	2922.51	АМГ-ын даргын 2010.03.31-ны №130 тушаал, ЭБМЗ-ийн 2010.02.27-ны ХХ-03-03 дүгнэлт, Наранбулагийн алтны үндсэн орд	2013.02.21 13-01-04	Алт
26	MV-017043	Ноён	Товон уул-1	Азиагоул д монголиа	2665.65	АМГ-ын даргын 2010.03.31-ны №130 тушаал, ЭБМЗ-ийн 2010.02.27-ны ХХ-03-03 дүгнэлт, Наранбулагийн алтны үндсэн ордын нөөцийн тодорхой хэсэг орж байна.		Алт
27	MV-017172	Мандал-Овоо	Авдрант-1	Олон-Овоот гоулд	1773.74	АМГ-ын даргын 2012.05.16-ны өдрийн №261 тушаал, ЭБМЗ-ийн 2012.05.08-ны өдрийн ХХ-08-04 дүгнэлт, Баян-Овоогийн хайлуур жоншны орд	ЭБМЗ-ийн 2013-12-24 13-20-0 2013.03.21 13-05-06	Жонш
28	MV-017387	Цогтцэций	Хармагтай	Оюут-Улаан	6647.05	АМГ-ын даргын 2010.09.03-ны №393 тушаал, ЭБМЗ-ийн 2010.07.14-ний ХХ-10-02 дүгнэлт, Хармагтайн алт-зэсийн порфирын орд алт 38.436тн, зэс 34800тн	2013.06.27	Алт

29	MV-017396	Мандал-Овоо	Мушгиа худаг-1	Макс-Импекс	291.64	АМГ-ын даргын 2013.04.01-ний №137 тушаал, ЭБМЗ-ийн 2013.01.23-ны ХХ-03-04 дүгнэлт, Мушгиа худаг-1 /XV-003798/, Мушгиа худаг-2 /XV-003816/ алтны үндсэн орд, В зэргээр 200.66кг, С зэргээр 157.19кг	Алт
30	MV-017397	Мандал-Овоо	Мушгиа худаг-2	Макс-Импекс	1216.55	АМГ-ын даргын 2013.04.01-ний №137 тушаал, ЭБМЗ-ийн 2013.01.23-ны ХХ-03-04 дүгнэлт, Мушгиа худаг-1 /XV-003798/, Мушгиа худаг-2 /XV-003816/ алтны үндсэн орд, В зэргээр 246.63кг, С зэргээр 170.72кг	Алт
31	MV-017452	Гурвантэс	Ямаан усны хяр	Агммайн инг	11247.8	АМГ-ын даргын 2010.08.04-ны №963 тушаал, ЭБМЗ-ийн 2010.02.26-ны ХХ-02-05 дүгнэлт, Торомхон, Ямаан усны хярын алтны үндсэн болон шороон орд, Алагшандын алтны үндсэн орд, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Алагшандын алтны үндсэн ордод АМГ-ын даргын 20/8/2015-ны №н-153 тушаал, ЭБМЗ-ийн 09/7/2014-ны ХХ-12-07/02 дүгнэлтээр дахин нөөц орсон.	алт
32	MV-017521	Ханхонгор	Залаа хайрхан уул-4	Мөст олон булаг	496.26	АМГ-ын даргын 2014.03.20-ны №н-47 тушаал, ЭБМЗ-ийн 2014.02.27-ны ХХ-03-04 дүгнэлт, Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Хүрэн толгойн манганийн орд	Манган

9.4. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордын ашиглалтын төлөвлөлт

2014 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр батлагдсан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу тухайн аймагт оршиж буй орд илэрцийн хайх, ашиглах тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг дарга олгож, хэрэгжилтэнд нь хяналт тавьж байхаар хуульчлагдсан юм. Зам болон барилгын салбар эрчимжтэй хөгжиж буй энэ үед Өмнөговь аймгийн хэмжээнд аж ахуйн эргэлтэнд оруулах боломжтой Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордуудыг хүснэгтээр орууллаа.

Хүснэгт №9.3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордууд

Тоосгоны шавар					
1	Улаан эрэгийн орд	43°46'40" 103°56'15"	Ханхонгор	Давхарга маягийн биетийн дундаж зузаан 6.3-13.2м, урт 180м	$C_2=1963.0$ мян.м ³
2	Даланзадгадын орд	43°32'30" 104°30'00"	Даланзадгад	Давхарга маягийн хэвтэшийн ашигт зузаалгийн дундаж зузаан 1.7м	
3	Эрэг худагийн орд	43°52'35" 105°27'00"	Цогтцэций	Шаврын давхаргын зузаан 150м	$P_1=98700м^3$ $A+B+C_i=1966.6$ $C_2=6300.0$ мян.т
4	Рашаан худагийн орд	43°32'30" 105°19'52"	Цогтцэций	Шаврын зузаан 9.5-10.5м	
5	Бор тээгийн орд	43°10'00" 104°30'00"	Ханхонгор	Шаврын хэвтэшийн урт 1000м, өргөн 270-280м, зузаан 3-10.7м	$V=305.7$ мян.т/ $d=459.0$ $C_2=2502.7$
Шавар					
6	Мандал-Овоогийн орд	44°38'13" 104°07'25"	Мандал-Овоо	Шаврын урт 600м, өргөн 100-350м, зузаан 4-22м.	$C_1=1886845т$ $C_2=1863032т$
7	Цогт-Овоогийн орд	44°16'10" 104°41'20"	Цогт-Овоо	Мэшил маягийн биетийн урт 420м, өргөн 100-200м, зузаан 3-17.2м.	каолины түүхий эд: $V+C_1=109360т$ $C_2=616597т$ Баяжигдсан каолин $V+d=38510т$ $C_2=128164т$
Карбонат чулуулаг					
8	Тэвш уулын орд	43°16'56" 104°35'15"	Ханхонгор		414.41 мян.т
9	Хөх цавын орд	44°16'33" 104°1'20"	Цогт-Овоо	Биетийн урт 500м, өргөн 110-160м.	$C_1=211.2$ $C_2=6613.5$ мян.т
10	Элгэн булагийн орд	44°55'00" 103°38'00"	Мандал-Овоо	Үеийн зузаан 2-5м	Таамаг нөөц 11500м ³
Өнгөлгөөний чулуу					
11	Эрдэнийн орд	43°06'30" 101°43'30"	Ноён	Мэшил маягийн биетийн урт 20-200м, зузаан 0.5-2.5м.	Таамаг нөөц 2791тн

12	Баянхар толгойн илрэл	42°33'26" 107°5Г46"	Баянхар толгойгоос 3У 1.5км-т	200х1000м талбайд габбро, микрогабброгийн дэл судлууд	Нилээд том хавтан авч ашиглах боломжтой
Перлит					
13	Цагаан-Овоогийн орд	43°31'00" 105°55'30"	Цогтцэций	Биетийн хэмжээ 300-1500м-т хэлбэлздэг. Зузаан нь 5-8м-ээс 30м	Таамаг нөөц 1 сая.м ³
Барилгын элс					
14	Хавчил уртын орд	43°24'10" 104°20'47"	Ханхонгор	Ашигт зузаалгийн зузаан 1.8-5.9м.	В=325.5 С ₁ =413.9 мян.т
15	Улаан шивээний илрэл	42°26'40" 107°42'35"	Хүүхэн хар уулаас БХ 1.5км	0.5-1 км өргөн, 4км урт орчин үеийн салхины гаралтай нарийн ширхэгт цагаан шаргал өнгийн сэвсүүл элс	
Барилгын чулуу					
16	Хүрэнгийн орд	43°31'14" 104°29'30"	Даланзадгад	Липаритын зузаан 1-3м.	13846м ⁻³
17	Рашаантын орд	43°34'20" 105°19'20"	Цогтцэций	Порфиритын урт 800м, өргөн 400м, зузаан 23.9-51.8м	В+С ₁ =5215.0 С ₂ =3371.6мян.м ³

**АРАВДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГТГЭЛ,
ХУВААРИЛАЛТ, ЗАРДЛЫН ТОВЧОО**

10.1. ХАА-н газар

10.1.1. Бэлчээр

Аймгийн хүн ам 2020 онд 66.5, 2025 онд 70.7, 2030 онд 75.37 мянгад хүрэхээр байгаа бөгөөд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэл аймгийн нийт хүн амын хэрэгцээг бүрэн хангах боломжтой тул бэлчээрийн даац, багтаамжид тулгуурласан төлөвлөлтийг хийх боломжийг олгож байна. Уг төлөвлөлтөд сүргийн бүтцийг эдийн засгийн хувьд хохиролгүй байхаар тооцоолж малын тоог тогтвортой барих замаар бэлчээрийн даацад **малын тоо, толгойг тохируулах** бодлого баримталж сүргийн зохистой бүтэцийг тодорхойлсон болно.

Мөн бэлчээр ашиглалтын чиглэлээр ашиглалтгүй бэлчээр нутгийн ашиглалтыг сайжруулж, доройтож талхлагдсан бэлчээрийг сайжруулах арга хэмжээг төлөвлөв. Өмнөговь аймгийн хувьд 3064,7 мянган га буюу нийт бэлчээрийн 21,5% талхагдалд өртөн доройтсон байна. Мөн 7 сумын нутагт 1069592.8га бэлчээрийн эдэлбэр газар гар аргаар алт олборлолгч, машин техникийн нөлөөгөөр эвдэрч сүйдсэн байна.

Талхлагдсан бэлчээрийн ачаалаллыг бууруулах, сэргээх зорилгоор доройтлын байдал, талхагдалын зэрэглэл, ургамалжилтын онцлогийг харгалзан богино хугацаанд ашиглах, эсвэл 2-3 жил ашиглахгүй байх, улирлаар өнжөөж ашиглах, хашаалж хамгаалах, чөлөөлөх зэрэг арга хэмжээнүүдийг төлөвлөж зөвлөмжийг боловсруулав.

Ашиглалт багатай бэлчээр нутгийн ашиглалтыг сайжруулж, талхлагдан доройтсон бэлчээр нутагт менежмент хийх боломжийг олгох, усгүйгээс болж ашиглалт багатай байгаа 2235.9 мян.га бэлчээрийг усжуулснаар 762.1 мянган хонин толгой мал бэлчээх боломжтой бэлчээрийг эргэлтэд оруулж, тэр хэмжээний бэлчээрийн газрыг сэлгээнд оруулах боломж нээгдэнэ. Нийт 520 худаг нэн тэргүүнд шаардлагатай. Бэлчээр нутгийг усжуулах зориулалт бүхий хөв цөөрөмийг 3-н сумын саналыг үндэслэн 8-н байршилд төлөвлөж ус хурах талбайн хэмжээг тооцоолов.

10.1.2. Хадлан

Өмнөговь аймагт Даланзадгад сумын 30 га усалгаатай хадлангийн талбай байгаа бөгөөд бусад суманд улсын хэмжээнд бүртгэлтэй хадлангийн газар байхгүй байна. Хадлангийн нөөц бага учир гар тэжээлд онцгой ач холбогдол өгөх хэрэгтэй юм. Монгол улсын статистикийн мэдээгээр Өмнөговь аймаг жил бүр 5.6 мян.тонн өвс, 1.6 мян.тонн гар тэжээл бэлтгэдэг байна. Судалгаагаар Булган, Мандал-Овоо сумын нутагт 253.6 мянган га газрыг хадлангийн бүс нутаг болгохоор санал гаргажээ. Эдгээрийн ихэнх нь Онги голын дагуух цөлийн хээр, цөлийн монгол өвс- таана-бударганат, бор бударгана- таана-баглуурт, харганат, монгол өвс-шавагт бэлчээр байх юм. Нам, хотосын арай чийглэг байж болох газрын хадлан нь жижиг улалж-үетэнт, хармагт, бударганат бэлчээр бөгөөд хадланд ашиглахад ургац нь хэтэрхий бага 1.7-2.0 ц/га юм. Гэвч голын ус хүрэх хэсэгт нам

хотосын нугагжуу хэсгээс сонгож малчдын хэсэг бүлэг, хоршоо, компанид эзэмшүүлэх, сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх замаар хадлангийн бүс байгуулах боломж байна. Тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэхэд орон нутгийн тэжээлийн нөөц: таана, хөмүүл, агь, шаваг, шарилж, тэсэг, тогторгоно гэх мэт ашигт ургамал, амьтны болон ахуйн гаралтай түүхий эдийг малын тэжээлд ашиглан жилийн турш тасралтгүй гар тэжээл бэлтгэх, бэлтгэсэн тэжээлийг борлуулах цэгийг аймаг, сумын төвд нээж ажиллуулах, ӨМӨЗО-ноос хямд үнэтэй тэжээл оруулж ирэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг бүх нийтийн оролцоог бүрдүүлэхэд чиглэсэн эдийн засгийн оновчтой бодлого хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

10.1.3. Газар тариалан

Өмнөговь аймгийн хувьд 2013 оны статистикийн газрын мэдээгээр 2013 онд 647 тн төмс, 601,4 тн хүнсний ногоо хураан авсан ба үр тариа тариалаагүй байна. Энэ нь одоогийн аймгийн нийт хүн амын хэрэгцээг бүрэн хангах хэмжээнд хүрэхгүй байна. Одоогийн байдлаар аймгийн хэрэгцээний үр тариа 0%, төмс 18,5%, хүнсний ногоо 11.7%-ийг хангаж байна. 2030 он хүртлэх төлөвлөлтийн жилүүдэд хүн амын өсөн нэмэгдэх хэрэгцээний төмсний 14.3%, хүнсний ногооны 9.1%-г дөнгөж хангах боломжтой байгаа тул газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Одоо ашиглагдаж буй газар тариалангийн эргэлтийн талбай 815.44 га бөгөөд 2030 он гэхэд газар тариалангийн үйлдвэрлэлд шаардлагатай эргэлтийн талбайн хэмжээ 25170.84 га болгохоор төлөвлөв.

Энэ нь зөвхөн аймгийн хүн амыг төмс хүнсний ногоогоор хангахад боломжтой талбай юм. Тариалангийн газрын эргэлтийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх боломж байгаа боловч үүнд ихээхэн хөрөнгө оруулалт шаардагдаж байна. Орон нутгаас өгсөн санал болон одоо байгаа тариалангийн талбайн хэмжээ нь газар тариалангийн эргэлтийн талбайг 1592.18 га хүртэл нэмэгдүүлэх боломжтойг харуулж байна. Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээгээр нийт нутаг дэвсгэрийн 7,56 % нь газар тариаланд ашиглах боломжтой нь тогтоогдсон бөгөөд бүс нутгийн онцлогт нь тохирсон агро техникийн үйл ажиллагаа явуулж, тохирсон тарималыг сонгон тариалснаар тогтвортой ашиглах бүрэн боломжтой юм. Тохиромжтой талбайн ихэнх хэсэг нь хожуувтар болцтой тариамалд тохиромжтой боловч чийг хангамжын хувьд нэн хуурай бүсэд хамаарах тул усалгаатай нөхцөлд л газар тариалан эрхлэх боломжтой. Мөн хөрсний элэгдэл эвдрэл ихээр явагдах магадлалтай газрууд тул хөрс хамгаалах арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай.

10.1.4. Эрчимжсэн АА

Эрчимжсэн МАА-г хөгжүүлэх чиглэлээр санал өгсөн 6-н сумын 22 байршилд тохиромжтой байдлын үнэлгээ хийсэн бөгөөд ургамалжилтын хувьд уг санал бүхий 22-н газраас байгалийн хадлан бэлтгэх боломжтой талбайтай газар байхгүй бөгөөд бэлчээрийн талбай нь бүх төрлийн бэлчээрийн малд тохиромжтой. Сүү, махны чиглэлийн цэвэр цусны

үхэрт таарамж муутай бэлчээртэй. 4-н байршлаас бусад газар нь тэжээлийн ургамал тариалахад тохиромж муутай, 11-н байршилд усан хангамж муутай нь тогтоогдсон бөгөөд эцсийн үнэлгээгээр Манлай, Баян-Овоо, Номгон, Цогт-Овоо сумдын санал болгосон 2,6,11,18 дугаар бүхий талбайнуудад эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх боломжтой бөгөөд бусад газрууд нь хязгаарлагдмал тохиромжтой болохыг тодорхойлсон. 25 үнээний жишиг ферм байгуулах нөхцөлд тооцоогоор зардлаа 5,4 жилд нөхөх магадлалтай бөгөөд говийн бүсэд байгуулах сүүний чиглэлийн фермийг уурхайн туслах аж ахуйн чиглэлээр тэдний дэмжлэгтэйгээр хөгжүүлэх нь оновчтой байх магадлалтай.

Харин төлөвлөлтийн багийн зүгээс Саалийн 25 үнээний фермийг Гурвантэс, Ханбогд, Цогтцэций, Ханхонгор сумдад, Маналай, Цогтцэций, Номгонд нутгийн тулман хөхт ямааг сүүний ямааны үрээр зохиомол хээлтүүлэг хийх замаар тус бүр 100 ямаатай ферм, бусад сумдад ингэний ферм байгуулахаар төлөвлөв.

Оюутолгой, Тавантолгой, Нарийн сухайт, Олон овоотын орд газрын ойролцоо тус бүр нь 8 мэгж, нэг бодонтой гахайн жижиг фермерийн аж ахуй байгуулах саналтай байгаа бөгөөд шаардагдах тэжээлийг ӨМӨЗО-оос худалдаж авах боломжтой.

10.1.5. Отрын бүс нутаг

Өмнөговь аймгийн хувьд гадагшаа отор нүүдэл хийх боломж муутай, нүүдэл хийхэд хэтэрхий хол зам туулах учраас боломжтой нутгийг сонгож, хамгаалах, тохижуулах замаар сум дундын отрыг хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

10.2. Хот, тосгон бусад суурин газар

Газар зохион байгуулалтын 2014-2030 оны ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд хот байгуулалтанд тавигдах ерөнхий шаардлага, төлөвлөлтийн норм ба дүрмийн дагуу тухайн хот сум суурины төвийн барилга байгууламж, нутаг дэвсгэрийн бүсүүдэд шаардагдах газрын хэмжээг тооцоолж гаргалаа.

Хот тосгоны ерөнхий төлөвлөгөөний тооцооны үндэс болох хүн амын хэтийн тоог 2014-2020, 2021-2025, 2026-2030 оноор тооцоолж хүн амын тоотой уялдуулан орон сууц, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, худалдаа үйлчилгээний барилга байгууламжуудын хүчин чадал, шаардагдах эдэлбэр газрын хэмжээг тодорхойлж хот байгуулалтын үнэлгээг хийв, Тус үнэлгээгээр Номгон сумаас бусад сумдууд аль нэг үзүүлэлтээрээ хязгаарлагдмал тохиромжтой ангилалд орж байна.

Овойлт, суулттай хөрсний тархалтын үзүүлэлтээр Даланзадгад, Баян-Овоо, Гурвантэс, Номгон, Ханхонгор, Хүрмэн, Цогтцэций сумд тохиромжтой хөрс бүхий нутаг дэвсгэрт байрладаг. Хөөлт, суулт, гулсалт бүхий хөрстэй Баяндалай, Булган, Ханбогд, Мандал-Овоо, Манлай, Ноён, Сэврэй, Цогт-Овоо сумдад барилга байгууламж барихдаа хөрсөнд тохирсон арга хэмжээ авах шаардлагатай.

Газар чичирхийллийн мужлалаар Мандал-Овоо, Манлай, Цогт-Овоо сумд 6 баллын мужлалд оршдог учир тохиромжтой нөхцөлтэй. 7-8 баллын мужлалд оршдог Булган, Баян-Овоо, Номгон, Ноён сумд хязгаарлагдмал тохиромжтой. 9 –өөс дээш

баллынмужлалд оршдог Даланзадгад, Баяндалай, Гурвантэс, Сэврэй, Хүрмэн сумдад барилга байгууламж барихад газар хөдлөлийн эсрэг арга хэмжээ авах шаардлагатай.

Хот суурин газрын ашиглалтын тохиромжтой бүсчлэлийг тогтоон, газрын нөөцийг тогтоосон бөгөөд Номгон сумаас бусад сум суурин газрынхаа тэг гортигийг тэлэх шаардлагатай байна. Хот байгуулалтын нормоор тооцоолсон шаардлагатай газрын хэмжээг тогтоосон газар ашиглалтын бүсчлэлээр тогтоосон газрын нөөц үзэхэд бүрэн хангаж байна. Тогтоогдсон нөөц газруудыг ашиглахдаа хот байгуулалтын нарийвчилсан төлөвлөгөөнд үндэслэн хэсэгчлэн тухайн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ. Одоо байгаа гэр орон сууцны бүс 3329,68 га, нэмж 10642,84 га-аар нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. Үйлдвэрийн бүсийг 18725,1 га газарт байгуулахаар төлөвлөлөө. Аймгийн хэмжээнд сумдын төвийн нийт тэг гортигийн газрын хэмжээ 15316,1 га байна. 14566,5 га-гаар нэмэгдэхээр төлөвлөлөө.

10.3. Зам шугам сүлжээний газар

10.3.1. Зам, тээврийн байгууламж

Авто зам

Аймгийн төв Даланзадгад хотоос сумдуудад хүрэх 1672 км шороон замтай. Өмнөговь аймгаас Улаанбаатар хүртэл зам нь зорчигч тээврийн гол зам бөгөөд 2014 онд Улаанбаатар-Даланзадгадын хатуу хучилттай зам ашиглалтанд орсон.

Харин Таван Толгойгоос Гашуун Сухайтын боомт хүртэл даацын 267 км, Оюутолгой-Гашуунсухайтын 90 км хатуу хучилттай замууд уул уурхайн тээвэрт ашиглагдаж байна. Нарийнсухайт-Шивээхүрэнгийн чиглэлд 43.2 км хүнд даацын машин явах боломжтой хатуу хучилттай авто замыг концессын гэрээгээр барьж 2014 оны 9 сард ашиглалтанд оруулжээ. Мөн Даланзадгадаас-Гурвантэс сумын чиглэлд 35 км хатуу хучилттай замыг барьж байгуулсан байна. Тус аймгийн нутагт нийт 591.2 км хатуу хучилттай зам тээвэрт ашиглагдаж байна.

Оюунтолгой-Ханбогд-Ханги чиглэл 435км, Цогт-Овоо-Даланзадгадын хатуу хучилттай замаас—Цогтцэций сумын төв хүртэлх 57 км, Оюунтолгой-Ханбогд чиглэлийн 35 км, Тавантолгой-Гашуунсухайтын чиглэлийн замаас Үнэгтийн уурхай чиглэлд 36 км, Үнэгт чиглэлд тавих замаас салаалан Баян –Овоо сумын төвийг хатуу хучилттай замаар холбох 30 км, Даланзадгад-Гурвантэс 308 км, Гурвантэс-Баянлиг* /Босоо тэнхлэгийн зам/ 209 км хатуу хучилттай замуудыг төлөвлөгөөнд тусгасан ба нийт хөрөнгө оруулалт 660 тэрбум төгрөг байна. Мөн орон нутгаас санал өгсөн 550 км орон нутгийн чанартай шороон замыг засаж сайжруулахаар төлөвлөсөн ба нийт хөрөнгө оруулалт 550сая төгрөг байна.

Агаарын тээврийн барилга байгууламж

Улаанбаатараас Даланзадгадын чиглэлд агаарын зорчигч тээврийн 3 компани үйчилгээг хариуцдаг. Тус аймагт төвийн Говь-Гурван сайхан нисэх буудал, Оюунтолгойн нисэх буудал буюу Ханбумбат, Овоотын нисэх буудал гэсэн хатуу хучилт бүхий нисэх

буух зурвастай гурван нисэх буудал ажиллаж байна. Даланзадгадын Говь-Гурвансайхан буудлыг 2016-2020 онд олон улсын нислэг хүлээн авдаг болгоно. Өргөтгөлийн ажилд 5.0 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөв.

Төмөр замын газар

Одоогийн байдлаар судалгааны нутагт төмөр замын сүлжээ байхгүй. Цаашид Монгол Улсын 2010-2015 оны эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлд уул уурхайн төмөр замын салбарыг хөгжүүлэхээр заажээ. Ухаа худаг-Оюутолгой- Гашуун сухайт, Нарийн сухайт-Шивээхүрэнгийн боомт, Таван толгой - Цагаан суварга - Зүүн баян – Сайншанд, Тавантолгой-Нарийн сухайт чиглэлийн төмөр замууд төлөвлөгдөн ТЭЗҮ боловсруулах, шороон далангийн байгуулалт хийх ажлууд хийгдэж байна. Шаардлагатай зурвас газрын тооцоог хийсэн.

10.3.2. Холбоо мэдээллийн сүлжээ

6 сумаас бусад нь аймгийнхаа төвтэй шилэн кабелиар холбогдсон. Цаашид эдгээр сумуудын төвийг аймгийн төвтэй шилэн кабелиар холбоно. Үүнд орчим 1000 орчим км шилэн кабель орно.

10.3.3. Цахилгаан, дулааны сүлжээ

Одоогийн байдлаар Өмнөговь аймаг нь төвийн бүсийн эрчим хүчний системд багтдаг ба 9 сум Даланзадгадын ДЦС-д холбогдсон, 2 сум төвийн эрчим хүчний системд холбогдсон, Ноён, Сэврэй, Гурвантэс сумд БНХАУ-аас Нарийнсухайтын уурхайн эх үүсвэрээс эрчим хүчээ авдаг байна. Цаашид Таван толгойн 400 МкВт-ын цахилгаан станц баригдаж, эрчим хүчний нэгдсэн системтэй холбогдох хүртэлх хугацаанд айл өрхүүд, албан байгууллагуудын цахилгааны зохистой хэрэглээг тоолууржуулалтаар зохицуулж, суурингуудад үйлдвэрлэлийн зориулалттай шугамын зураг төслийг боловсруулан бэлтгэлийг хангах, цахилгааны эх үүсвэрийг шинээр байгуулан, байнгын дотоодын цахилгааны эх үүсвэргүй 3 сумыг холбох замаар аймгийн хэмжээнд эрчим хүчний нэгдсэн системд холбогдох, сумдын түвшинд бага оврын халаалтын зуухтай хэрэглэгчдийг дулаан хангамжийн төвлөрсөн системд холбож, хэрэглээг нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг төлөвлөж байна.

10.4. Ойн сан бүхий газар

Ой зохион байгуулалт, ойн тооллогын дүнгээр Өмнөговь аймгийн ойн сан бүхий газар тус аймгийн нийт нутаг дэвсгэрийн 7.2 хувийг эзэлж, 13 сумын нутаг дэвсгэрт тархасныг тогтоов. Ойн санг ойн талбай, ойн бус талбай гэсэн үндсэн хоёр хэсэгт ангилна. Ойн талбай нь дотроо ойгоор бүрхэгдсэн, ойгоор бүрхэгдээгүй талбай гэж хоёр хуваагдана. Ойгоор бүрхэгдсэн талбайд тухайн судалгааны үед ойтой байгаа (0.3 ба түүнээс дээш өтгөрөлтэй) болон улсын ойн санд шилжүүлсэн таримал ой, бут сөөгөөр битүү хучигдсан талбай орох ба ойгоор бүрхэгдээгүй ойн талбайд одоогийн байдлаар ой байхгүй боловч цаашдаа ой ургах нөхцөл бололцоотой газрууд (ойжиж байгаа газар,

тармаг модод, ойжуулсан талбай), урьд өмнө ойтой байсан талбай (шатсан ой, мод бэлтгэсэн талбай г.м) тус тус хамрагдана. Ойн бус талбайд ойн сан доторх цагаан энгэр, таг царам, хадлан, бэлчээр, гол, жижиг нуур цөөрөм, намаг, элс, мод үржүүлгийн талбай зэрэг газрууд орно.

Өмнөговь аймгийн заган ойн сангийн нийт талбай 1189226 га талбай ба үүний 604750 га байгалийн заган ой, 565731 га тармаг заг, 3857 га талбайг загжих талбай тус тус эзэлж байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд ойг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний алс хэтийн 2021-2030 оны төсөөллийг гаргахыг оролдов. Хэтийн төсөөллийг аймгийн хэмжээнд баримжаалан хийсэн бөгөөд сумдаар төлөвлөх боломжгүй гэж үзэж байна. Ойг хамгаалах арга хэмжээний хувьд төв, орон нутгийн уламжлалт зохион байгуулалтын болон хяналт шалгалтын ажлыг харуулах боломж хязгаарлагдмал юм. Мөн түүнчлэн ойн хөнөөлт шавьж, өвчний тархалтын судалгааг 2020 онд зохион байгуулж энэ судалгааны үр дүнд тулгуурлан 2021-2030 онд тэмцэх ажлыг төлөвлөх боломж бүрдэнэ. Гэхдээ 2021-2030 онд 35.0 мянган га талбайд ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх ажлыг төлөвлөсөн болно.

Ойн тооллого, ой зохион байгуулалтын ажлыг цаг хугацаанд нь явуулж, түүнд тусгагдсан ой хамгаалах арга хэмжээг хэрэгжүүснээр ойн экологийн ач холбогдол дээшилж, түүний таваарлаг чанар сайжирна. 2015-2030 онд ойг хамгаалах, хяналт шалгалт явуулах уламжлалт зохион байгуулалтын арга хэмжээг авахын зэрэгцээ, ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх ажлыг 2015-2020 онд 12.5 мян.га талбайд, 2021-2025 онд 15.0 мян га талбайд, 2026-2030 онд 20.0 мян.га табайд тус тус гүйцэтгэнэ.

Мод үржүүлгийн газруудыг өргөтгөн бойжуулах тарьц суулгацын хэмжээг нэмэгдүүлэх замаар ойг нөхөн сэргээх ажлын хэмжээг нэмэгдүүлнэ. 2015-2020 онд ойжуулалтын ажлыг 350 га-д, 2021-2025 онд 380 га-д, 2025-2030 онд 500га-д тус тус хийхээр төлөвлөв. Харин ойн зурвас байгуулах ажлыг 2015-2020 онд 161 га-д, 2021-2025 онд 370 га-д, 2026-2030 онд 460га-д тус тус хийхээр төлөвлөсөн болно.

2015-2030 онд явуулах ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд нийт 5394.15 сая төгрөг шаардагдах тооцоо гарч байна.

10.5. Усны сан бүхий газар

Өмнөговь аймгийн хувьд 2004-2013 он хүртэлх хугацаанд усны сан бүхий газрын нийт хэмжээнд өөрчлөлт ороогүй боловч 2013 оны жилийн эцсийн байдлаар гол мөрны эзлэх газрын хэмжээ 58 га-р багасч горхи, булаг шандын эзлэх газар 58 га-р нэмэгдэж, нуур цөөрөм тойрмын талбайд өөрчлөлт ороогүй байна. Гадаргын усны тооллогын материалаас үзэхэд нийт худаг 4940, булаг 405, услалтын систем 13, Хадат, Нэмэлт, Зөөлөн, Энгэр бүлээн, Талхийн шанд зэрэг рашаанууд тоологдсон байна.

Цаашид сум, аймгийн төвийн унд ахуйн усны эрүүл ахуйн бүсийг нарийвчлан тогтоож тэмдэгжүүлэн хамгаалах, усны чанарт шинжилгээ хийж, сайжруулах арга хэмжээ

авах, хүн амын төвлөрөл, усны ашиглалт ихээр нэмэгдсэнтэй холбогдуулан цэвэрлэх байгууламжуудыг сайжруулах, шинээр байгуулах зэрэг арга хэмжээнүүдийг тусгав.

Усны сан бүхий газрын доройтолд бэлчээр ашиглалтын хэв маяг, гол горхи, нуур, худаг уст цэг дагасан бэлчээрийн талхагдал нь усны сан бүхий газрын чанар нөөцөд ихээхэн нөлөөлж байгаа бөгөөд аймгийн ихэнхи сумдын бэлчээрийн даац хэтэрсэнээс бэлчээр ихээр талхлагдаж цөлжиж байна. Иймд бэлчээр усжуулалтын төлөвлөлтөд тусгасан нэн тэргүүнд шаардлагатай байгаа 520 худгийг гаргах. Сумдаас санал болгосон хамгаалах шаардлагатай булгуудыг нэн тэргүүнд тохижуулах, хөв цөөрөм байгуулах санал бүхий 8-н газарт нарийвчилсан судалгаа хийж, техникийн нөхцөлийг тодорхойлсны үндсэн дээр нэмэлтээр төлөвлөлтөд тусгах ажлуудыг төлөвлөв. Мөн усны эх орчмын газрыг хамгаалах чиглэлээр 405 булаг шандын эхийг хамгаалахаар төлөвлөв.

10.6. Тусгай хэрэгцээний газар

2013 оны жилийн эцсийн байдлаар улсын тусгай хэрэгцээний газар тус аймгийн хэмжээнд 3979.8 мян.га буюу нийт нутаг дэвсгэрийн 24,06%-г эзлэж байгаа ба үүнээс 3491,4 мян.га нь улсын тусгай хамгаалалттай газар нутаг байна.

2023 он хүртэлх хугацаанд улсын тусгай хамгаалалтад авах шаардлагатай Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны төлөвлөгөөнд тусгагдсан 18 байршил бүхий газруудыг /2003 онд батлагдсан УГЗБЕТ-өөс/ мөн Ханхонгор сумаас санал өгсөн Хан уул болон Их уул зэрэг газруудыг улсын тусгай хамгаалалтад авах нь зүйтэй бөгөөд түүнийг УТХ-нд авах үндэслэл, хилийн заагийг нарийвчлан тогтоож эрх бүхий байгууллагад хүргүүлэх шаардлагатай. Мөн аймгийн тусгай хэрэгцээнд хамруулах 16-н газрыг судлан хилийн цэсийг баталгаажуулах ажлыг хийх. Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газруудын нөөцийг гарган аймгийн тусгай хамгаалалтанд авахаар тусгалаа.

10.7. Аялал жуулчлал, амралт зугаалгын бүс

Өмнөговь аймгийн хэмжээнд жилдээ 10000-15000 орчим жуулчин ирдэг гэсэн тоо байгаа боловч энэ нь зөвхөн төвлөрсөн жуулчдын баазуудаар дамжин үйлчлүүлсэн жуулчдын тоо юм. Үүнээс гадна хувиараа явж байгаа үүргэвчтэй гэгдэх жуулчдын тоог нэмбэл энэ тоо ихээхэн өсөх нь ойлгомжтой. Булган сумын нутаг Баянзагт 2009 оны 7 сарын 6-нд нэвтрэх цэгийг тогтоож, мэдээллийн төвийг байгуулж ирсэн жуулчдын судалгааг гаргахад 7-р сарын 6-аас 9-р сарын 1 хүртэлх хугацаанд 2500 гаруй жуулчин ирсэн ба нийт жуулчдын 21% Франц, 18% Италийн жуулчид байсан судалгаа гарчээ.

Аялал-рекреацийн чадавхын үнэлгээнд тулгуурлан тогтоосон боломжит аялал жуулчлалын хэлбэрийг хөгжүүлэх шаардлагатай.

Аялал рекреацийн чадавхи өндөртэй бүс нутаг болох Сэврэй, Булган, Номгон, Ноён, Ханбогд сумдад Дэмчигийн хийд, Улаан сахиусын хийд, Үнстийн хийд, Галбын уулын үзэсгэлэнт газар, Баяжихын агуй, Оцон мааньт, Гурван зээрдийн агуй, Говийн бага дархан газрын А хэсэг, Говийн бага дархан газрын Б хэсэг, Ловончомбо агуй, Оюу толгойн уурхай, Хонгорын гол, Хонгорын элс, Сэрүүн булгийн баянбүрд, Наранбулаг,

Зөөлөнгийн нуруу, Нарангийн адгийн бичигт хөшөө, Монгол бичигт хад, Их сэврэй уул, Нэмэгт уул, Сэрвэн уул, Баруун сайханы нуруу, Дунд сайханы нуруу, Зүүн сайханы нуруу, Төгрөгийн ширээ, Баянзаг, Цахиурт, Цоорхой, Майхан толгой, Ёлын ам, Ноён уул, Толь хад зэрэг байгалийн үзмэрүүд байдаг ба Шувуу ажиглах аялал, Палеонтологийн аялал зэргийг хөгжүүлэх боломж байна. Мөн бусад нутагуудад тохиромжтой аялал жуулчлалын нөөцүүдийг тодорхойлов.

Аялал жуулчлалын нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулан, бүс нутгуудыг төрөлжүүлэх. Зар сурталчилгаа, идэвхижүүлэлтийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэн аялал жуулчлалыг дэмжих шаардлагатай байна. Төлөвлөлтөд аялал жуулчлалын ойрын болон дунд хугацааны, урт хугацаанд баримтлах бодлогыг тусгав.

10.8. Уул уурхайн газрын төлөвлөлт

Тус аймгийн нутаг дэвсгэрт 2014 оны 10-р сарын 28-ны байдлаар хайгуулын 170, ашиглалтын 74 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг авч үзвэл нүүрсний 40, алтны 15, холимог металлын 5, алт, зэсийн 2, манганы 2, цайрын 2, давсны 2, төмрийн хүдрийн 1, жоншны 1, агальметолитын 1, барилгын материалын 1 тусгай зөвшөөрөл тус тус хүчин төгөлдөр байна. Хайгуулын тусгай зөвшөөрлийн нийт талбайн хэмжээ 3.3 орчим сая га байна. Харин ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ 500 гаруй мянган га байна. Тус аймгийн нутаг дэвсгэрт улсын төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтаар явуулсан геологийн судалгаа, эрэл үнэлгээ, хайгуулын ажлын үр дүнгээр 36 нэр төрлийн ашигт малтмалын 256 орд илрэл тогтоогдсон.

УИХ-аас баталсан “Төмөр замын талаар төрөөс баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолыг саяхан баталсан. Уг тогтоолд зааснаар Тавантолгой-Гашуунсухайтын хооронд нарийн царигийн төмөр зам, Тавантолгойгоос Сайншанд хүртэл өргөн царигийн төмөр замын барих, Тавантолгойн ордыг түшиглүүлэн 450 мВт-ын хүчин чадалтай цахилгаан станцыг барьж Тавантолгой, Оюутолгойн ордыг цахилгаанаар хангахаар төлөвлөн ажиллаж байна. Ингэснээр дотоодын цахилгааны хэрэгцээг хангахаас гадна БНХАУ руу цахилгаан экспортлох боломж бүрдэх юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

№	Хөтөлбөрийн нэр, батлагдсан огноо, шийдвэрийн дугаар	Хэрэгжүүлэх хугацаа
1	“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” УИХ 2008 оны 01 сарын 31, 12-р тогтоол	
2	Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал	
3	Төрөөс хvнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого 2009 оны 7-р сарын 15	
4	Төрөөс малчдын талаар баримтлах бодлого УИХ-н 2009 оны 39 дүгээр тогтоол	
5	“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилгот хөтөлбөр УИХ-н тогтоол 2010 оны 06 сарын 25 өдөр	
6	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоол	
7	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал УИХ-н 2001 оны 57 дугаар тогтоол	
8	Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар	

	баримтлах бодлого УИХ-н 2009 оны 45 дугаар тогтоол	
9	Монгол улсын засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр /засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03 өдрийн 120-р тогтоол/ Шинэчлэлийн засгийн газар, Яамдын үйл ажиллагааны төлөвлөгөө; Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2012-2016 онд хөгжүүлэх тэргүүлэх чиглэл хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө	2012-2016
10	Өмнөговь аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөр, /аймгийн ИТХ-н тогтоолоор батлагдсан/	2021 он хүртэл хэрэгжих
11	Бүх нийтийн экологийн боловсрол үндэсний хөтөлбөр Засгийн газрын 1997 оны 255 дугаар тогтоол	1997-2030
12	Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр Засгийн газрын 2003 оны 207 дугаар тогтоол	2003-2015
13	“Сүү” үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2006 оны 239 дүгээр тогтоол	2006-2020
14	Хүнсний хангамж аюулгүй байдал, хоол тэжээл хөтөлбөр Засгийн газрын 2001 оны 242 дугаар тогтоол	2001-2020
15	“Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр” Засгийн газрын 2008.07.08 дугаар 288	2008-2016
16	“Хүнсний баталгаат байдал үндэсний хөтөлбөр” Засгийн газрын 2009.02.04-ний 32 дугаар тогтоол	2009-2016
17	“Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр” Засгийн газрын 2009.09.30-ны 299 дүгээр тогтоол	2009-2016
18	“Ариун цэврийн байгууламжийг сайжруулах” хөтөлбөр /Нийтийн бохирын шугам, цооног, бохир усны төрөл бүрийн цэвэрлэх байгууламж/ Засгийн газрын 2006.10.11-ний 246 дугаар тогтоол	2006-2015
19	Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр Засгийн газрын 2003.06.24-ний 160 дугаар тогтоол	2003-2015
20	Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх үндэсний хөтөлбөр Засгийн газрын 1998 оны 103 дугаар тогтоол	1998-2020
21	“Малын чанар сайжруулах” хөтөлбөр. Засгийн газрын 2006.04.26-ны 93 дугаар тогтоол	2006-2015
22	“Малын тэжээл” хөтөлбөр Засгийн газрын 2007.11.07-ны 283 дугаар тогтоол	2008-2015
23	“Төрөөс экологийн талаар баримтлах бодлого” үндэсний хөтөлбөр УИХ-ын 1997 оны 106 дугаар тогт	2000-2021
24	Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр Засгийн газрын 1998 оны 82 дугаар тогтоол	1998-2021
25	Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр Засгийн газрын 1996 оны 163 дугаар тогтоол	1996-2016
26	Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр УИХ-ын 1998 оны 29 дугаар тогтоол	1998-2015
27	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2003.06.04-ний 141 дүгээр тогтоол	2003-2012
28	Ойн тухай үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2001 оны 248 дугаар тогтоол.	2001-2015
29	Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр Засгийн газрын 1999.02.10-ны 25 дугаар тогтоол	1999-2015
30	“Чанарын болон байгаль орчны удирдлага /менежмент/-ийг дэмжих үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2002.07.08-ны 146 дугаар тогтоол	2002-2016
31	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2000 оны 120 дугаар тогтоол	2000-2015
32	Агнуурын загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2008 оны 267 дугаар тогтоол	2008-2015
33	“Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр. Засгийн газрын 2005.03.09-ний 44 дүгээр тогтоол	2005-2025
34	“Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах” хөтөлбөр Засгийн газрын 2006. 12.20-ний 309 дүгээр тогтоол	2010-2015
35	“Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр” Засгийн газрын 2008.02.27-ны 71 дүгээр тогтоол	2008-2015
36	“Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангах хөтөлбөр” Засгийн газрын 2008.03.05-ны 84 дүгээр тогтоол	2008-2015
37	Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2008.02.27-ны 78 дугаар тогтоол	2008-2012
38	Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө	2012 он

39	Хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийн мастер төлөвлөгөө	2011-2021
40	2003 онд батлагдсан УГЗБЕ төлөвлөгөө	2003-2023
41	Галбын говийн ГЗБЕ төлөвлөгөө	2010-2020
42	Тусгай сонирхолын аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө	2012
43	Монгол улсын статистикийн эмхэтгэл	2013